# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 03 сарын 22 өдөр Төрийн ордон,Улаанбаатар хот

**ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ**
**/Шинэчилсэн найруулга/**

## I ХЭСЭГ

## ЕРӨНХИЙ АНГИ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
### НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсад татвар бий болгох, тогтоох, татвар төлөгчийг бүртгэх, татвар ногдуулах, тайлагнах, төлөх, хянан шалгах, хураах, хөнгөлөх, чөлөөлөх, суутган тооцох, буцаан олгох эрх зүйн үндсийг тогтоож, Монголын Татварын алба /цаашид "Татварын алба" гэх/, татвар төлөгч болон энэ хуулийн дагуу татварын албаны өмнө үүрэг хүлээсэн бусад этгээдийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлон, тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл.Татварын хууль тогтоомж**

2.1.Татварын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд татварын хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1.Энэ хууль нь татвар төлөгч, татварын алба болон татварын хууль тогтоомжийн дагуу түүнийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн этгээдэд хамаарна.

3.2.Энэ хуулиар зохицуулаагүй, эсхүл энэ хуульд зааснаас өөрөөр татварын бусад хуульд заасан бол тухайн харилцааг нарийвчлан зохицуулсан татварын хуулийн зүйл, хэсэг, заалт давуу үйлчилнэ.

3.3.Энэ хуулийн 3.2-т заасны дагуу тухайн харилцааг нарийвчлан зохицуулсан хууль, зүйл, хэсэг, заалтыг тодорхойлох боломжгүй бол аль сүүлд батлагдсан хууль, хуулийн зүйл, хэсэг, заалтыг баримтална.

**4 дүгээр зүйл.Татвар бий болгох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох**

4.1.Доор дурдсанаас бусад тохиолдолд татварыг зөвхөн Улсын Их Хурал татварын хуулиар бий болгох, тогтоох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй:

4.1.1.хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийн төлөх татварын хувь, хэмжээг Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасны дагуу тогтворжуулах;

4.1.2.чөлөөт бүсэд мөрдөгдөх татварын тусгай дэглэмийг Чөлөөт бүсийн тухай хуулиар тогтоож, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг татварын холбогдох хуулиар зохицуулах.

4.2.Татварыг хөнгөлөх, чөлөөлөх, татварын хувь, хэмжээ болон татварын суурийг бууруулахтай холбогдсон хуулийн төслийг тухайн жилийн төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт боловсруулна.

**5 дугаар зүйл.Татварын үйл ажиллагаанд баримтлах зарчим**

5.1.Татвар бий болгох, тогтоох, ногдуулах, тайлагнах, төлөх, хяналт шалгалт хийх, хураах, хөнгөлөх, чөлөөлөх үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

5.1.1.зайлшгүй байх;

5.1.2.тодорхой байх;

5.1.3.шударга байх;

5.1.4.үр ашигтай байх.

**6 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт**

6.1.Татварын хууль тогтоомжид хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

6.1.1.“ажил гүйлгээний ашиг хуваах арга” гэж хяналтад байгаа ажил гүйлгээний ашгийг тухайн ажил гүйлгээнд оролцсон харилцан хамаарал бүхий талуудад эдийн засгийн үндэслэлтэй хуваарилж, түүнтэй харьцуулагдах бие даасан ажил гүйлгээний ашгийн түвшинтэй харьцуулан тухайн хяналтад байгаа ажил гүйлгээний нөхцөл, үнийг тодорхойлохыг;

6.1.2.“ажил гүйлгээний цэвэр ашгийн арга” гэж хяналтад байгаа ажил гүйлгээний цэвэр ашгийн түвшний үзүүлэлтүүдийг түүнтэй харьцуулагдах бие даасан ажил гүйлгээний цэвэр ашгийн түвшний үзүүлэлтүүдтэй харьцуулан тухайн хяналтад байгаа ажил гүйлгээний нөхцөл, үнийг тодорхойлохыг;

6.1.3.“ажлын өдөр” гэж долоо хоногийн Бямба, Ням гараг болон нийтээр тэмдэглэх баярын өдрөөс бусад өдрийг;

6.1.4.“албадан гүйцэтгэх ажиллагаа” гэж шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, барьцааны эрхээс барьцаа гаргуулах, татвар төлөгчтэй холбоотой дампуурлын хэрэг үүсгэх, татварын өр хураах үйл ажиллагааг;

6.1.5.“албан татвар” гэж хууль тогтоомжийн дагуу аливаа этгээдийн орлого, хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээнд тодорхой хугацаанд тогтоосон хувь, хэмжээгээр ногдуулж, хариу төлбөргүйгээр төсөвт төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгийг;

6.1.6.“бодит үнэ тодорхойлох зарчим” гэж харилцан хамааралтай этгээд хооронд хийсэн ажил гүйлгээний нөхцөл татварын зорилгоор түүнтэй харьцуулж болох бие даасан ажил гүйлгээний нөхцөлөөс ялгаатай байгаагаас татварын суурь багассан бол тухайн ажил гүйлгээний бодит үнийг тодорхойлж, татварын ногдолд тохируулга хийхийг;

6.1.7."үнэ шилжилтийн тохируулга хийх арга" гэж бодит үнэ тодорхойлох зарчмын дагуу харилцан хамаарал бүхий этгээд хооронд хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нөхцөл, үнийг тодорхойлохыг;

6.1.8.“групп” гэж санхүүгийн тайлагналын зорилгоор нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргадаг, эсхүл аль нэг аж ахуйн нэгжийн хувьцаа хөрөнгийн биржид нээлттэй арилжаалагдах үед нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргадаг, өмчлөл болон удирдлагын хувьд хамааралтай аж ахуйн нэгжүүдийг;

6.1.9.“дамжуулан борлуулах үнийн арга” гэж хяналтад байгаа ажил гүйлгээний нийт ашгийн түвшинг түүнтэй борлуулалтын орлогын хувьд харьцуулагдах бие даасан ажил гүйлгээний нийт ашгийн түвшинтэй харьцуулан тухайн хяналтад байгаа ажил гүйлгээний нөхцөл, үнийг тодорхойлохыг;

6.1.10.“дотоод харьцуулалт хийх ажил гүйлгээ” гэж татвар төлөгчийн харилцан хамааралтай этгээдтэй хийсэн ажил гүйлгээ болон бие даасан этгээдтэй хийсэн ажил гүйлгээг;

6.1.11.“жишиг үнийн арга” гэж татвар төлөгчтэй ойролцоо хүчин чадал, нөхцөл бүхий адилтгах үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийн үйл ажиллагаа, орлого, зарлагын болон бусад бодит тооцоонд үндэслэн татварын ногдлыг тодорхойлохыг, тийм татвар төлөгч байхгүй бол татварын алба өөрт байгаа мэдээллийг үндэслэн татварын ногдлыг тодорхойлохыг;

6.1.12.“итгэмжлэгдсэн төлөөлөгч” гэж татвар төлөгчийн эрх ашгийг итгэмжлэл болон гэрээний үндсэн дээр төлөөлж, татварын албатай харилцах эрх, үүрэг бүхий итгэмжлэгдсэн этгээдийг;

6.1.13.“нөхөн ногдуулалт” гэж энэ хуульд заасны дагуу гүйцэтгэсэн татварын хяналт шалгалтын дүнд үндэслэн татварын албанаас тодорхойлсон татварын дүнг;

6.1.14.“нөхөн ногдуулалтын акт” гэж татварын албанаас тодорхойлсон нөхөн ногдуулалт, торгууль, алдангийн дүнг тусгасан татвар төлөгчид хүргүүлэх баримт бичгийг;

6.1.15.“нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулсан акт” гэж Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд зааснаар албан татвар суутган төлөгчийн татварын ногдуулалт, төлөлтийг татварын алба хянан, баталгаажуулсан баримт бичгийг;

6.1.16.“оршин суугчийн гэрчилгээ” гэж татвар төлөгчийг тухайн татварын жилд тус улсын оршин суугч татвар төлөгч мөн болохыг нотолж тухайн улсын татварын албанаас тогтсон загварын дагуу үйлдсэн баримт бичгийг;

6.1.17.“өртөг дээр нэмэх арга” гэж хяналтад байгаа ажил гүйлгээний нийт ашгийн түвшинг түүнтэй зардлын бүтцийн хувьд харьцуулагдах бие даасан ажил гүйлгээний нийт ашгийн түвшинтэй харьцуулан тухайн хяналтад байгаа ажил гүйлгээний нөхцөл, үнийг тодорхойлохыг;

6.1.18.“татварын схем” гэж татварын ашиг хүртэх үндсэн зорилгоор хэрэгжүүлэх татвараас зайлсхийх үйл ажиллагааг;

6.1.19.“суутган төлөгч” гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг;

6.1.20.“татвар төлөгч” гэж татварын хууль тогтоомжийн дагуу татвар төлөх үүрэг бүхий этгээд, эсхүл суутган төлөгчийг;

6.1.21.“татвар төлөгчийн гэрчилгээ” гэж татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангаас татвар төлөгчид олгосон, татвар төлөгчийн дугаартай, татварын төрлийн мэдээллийг тусгасан тусгай нууцлалын кодоор баталгаажсан, цахим болон цаасан баримт бичгийг;

6.1.22.“татвар төлөгчийн дугаар” гэж татварын албанаас татвар төлөгчид олгосон татвар төлөгчийн бүртгэлийн нэгдсэн системийн дахин давтагдашгүй дугаарыг;

6.1.23.“татвар төлөхөөс зугтах" гэж татвар төлөгч татвар төлөхгүй байх, төлөх татварын хэмжээг бууруулах, эсхүл нуух зорилгоор татварын хууль тогтоомж зөрчих үйлдэл, эс үйлдэхүйг;

6.1.24.“татвараас зайлсхийх” гэж татварын ногдлыг бууруулах, татварын суурь багасгах, эсхүл алдагдлыг нэмэгдүүлэх үндсэн зорилготой энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан нөхцөлийг бүрдүүлж байгаа татвар төлөгчийн үйлдлийг;

6.1.25.“татварын алба” гэж татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтэс, сумын татварын тасаг, татварын улсын байцаагч, хураагчийг;

6.1.26.“татварын акт” гэж татварын улсын байцаагчийн үйлдсэн нөхөн ногдуулалтын акт, нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулсан акт, татварын буцаан олголтын актыг;

6.1.27."татварын буцаан олголтын акт" гэж татварын албаны үндэслэлгүйгээр илүү хураасан мөнгөн дүнд алданги тооцож олгоход үйлдэх баримт бичгийг;

6.1.28.“татварын жил” гэж тухайн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацааг;

6.1.29.“татварын тайлан” гэж татварын албанаас баталсан маягтын дагуу татвар төлөгчийн бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргасан татварын суурь, албан татвар, төлбөр, хураамжийн ногдлын хэмжээг тодорхойлж, тайлагнах хуудсыг;

6.1.30.“татварын улсын байцаагч” гэж энэ хуулийн дагуу татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлж, татвар төлөгчид үйлчлэх, татвар хураах, тайлан хүлээн авах, хяналт шалгалт хийх чиг үүрэг бүхий татварын албанд ажилладаг, эрх олгогдсон төрийн захиргааны албан хаагчийг;

6.1.31.“татварын өр хураах зардал” гэж татварын өр барагдуулах үйл ажиллагаанд хамаарах хөрөнгийн битүүмжлэл, суутгалын хүсэлт, битүүмжилсэн хөрөнгийн хадгалалт, тээвэрлэлт, дуудлага худалдаа явуулах, үнэт цаас болон биет бус хөрөнгийн эрхийг хураах, хуваарилахтай холбоотой гарсан зардлыг;

6.1.32.“татварын хялбаршуулсан горим” гэж татварын бүртгэл, ногдуулалт, хувь хэмжээ, тайлагнал, төлөлтийн тусгайлсан үйл ажиллагааны нийлбэр цогцыг;

6.1.33."татварын суурь" гэж тодорхой дүн, эсхүл хувиар татварын ногдлыг тодорхойлох орлого, хөрөнгө, бараа, ажил үйлчилгээ, тодорхой эрх, газар, түүний хэвлий, байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц, агаарын, хөрсний, усны бохирдлыг мөнгөөр илэрхийлсэн дүн, эсхүл биет нэгжийг;

6.1.34.“татварын цахим баримт бичиг” гэж татварын хууль тогтоомжийн дагуу цахим хэлбэрээр боловсруулсан, хадгалсан, илгээсэн, хүлээн авсан, цахим гарын үсгээр баталгаажсан баримт бичгийн иж бүрдлийг;

6.1.35.“тодорхой бизнесийн зорилгогүй татварын үйлдэл” гэж төлөх татварын хэмжээг багасгах, татвар төлөхөөс зайлсхийх болон татвар төлөх хугацааг хойшлуулсан ажил гүйлгээ хийх, төлөвлөн гүйцэтгэх татвар төлөгчийн үйлдлийг;

6.1.36.“төлбөр” гэж төрийн өмчийн газар, газрын хэвлий, байгалийн баялаг, ой, ургамал, рашаан, ашигт малтмал, газрын тосны нөөц, агаар, ус, хөрс ашигласны, бохирдуулсны, ан амьтан агнасны төлөө аливаа этгээдээс авч төсөвт төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгийг;

6.1.37.“харьцуулагдах байдлын шинжилгээ” гэж харилцан хамаарал бүхий этгээдүүдийн хооронд хийгдсэн ажил гүйлгээний нөхцөлийг харилцан хамааралгүй этгээдүүдийн хооронд хийсэн ажил гүйлгээний нөхцөлтэй харьцуулан ялгаатай хүчин зүйлсийн нөлөө, зөрүүг арилгаж үнэн зөв залруулга хийх шинжилгээний аргыг;

6.1.38.“харьцуулагдах бие даасан үнийн арга” гэж хяналтад байгаа ажил гүйлгээний үнэ болон үнэд нөлөөлөгч хүчин зүйлсийг түүнтэй харьцуулагдах, бие даасан ажил гүйлгээний үнэ болон үнэд нөлөөлөгч хүчин зүйлстэй харьцуулан тодорхойлохыг;

6.1.39."хураагч" гэж татварын улсын байцаагчийн нөхөн ногдуулалт хийх, хяналт шалгалт хийхээс бусад чиг үүргийг хэрэгжүүлж байгаа татварын албаны ажилтныг;

6.1.40.“хураамж” гэж төрийн байгууллагаас аливаа этгээдэд хууль тогтоомжийн дагуу үйлчилгээ үзүүлсний төлөө тэднээс тухай бүр авч төсөвт төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгийг;

6.1.41.“хүндэтгэн үзэх шалтгаан” гэж:

6.1.41.а.эмнэлгийн өвчтөний гар картад бичигдсэн бөгөөд лаборатори болон багажийн шинжилгээгээр эмчлүүлэх шаардлагатай нь нотлогдож, эмч, эмнэлгийн байгууллагын гаргасан магадлагаагаар эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа;

6.1.41.б.эмч, эмнэлгийн байгууллагын гаргасан магадлагаагаар энэ хуулийн 6.1.41.а-д заасны дагуу эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа өвчтөнийг асарсан;

6.1.41.в.хуульд заасан эрх бүхий этгээдийн зарласан нийтийг хамарсан дайчилгаанд хамрагдсан;

6.1.41.г.хуульд заасан эрх бүхий этгээдийн зарласан нийтийг хамарсан аюулт халдварт өвчний улмаас хорио цээр тогтоосон бүсэд хоригдсон;

6.1.41.д.хуульд заасан эрх бүхий этгээдээс албан ёсоор зарласныг нотолсон галын болон байгалийн гэнэтийн аюул, эсхүл давагдашгүй хүчин зүйл /усны үер, ган, зуд, аюултай цасан болон шороон шуурга, газар хөдлөлт/ зэрэг шалтгааныг;

6.1.42.“хяналтад байгаа ажил гүйлгээ” гэж харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн ажил гүйлгээг;

6.1.43.“бие даасан ажил гүйлгээ” гэж харилцан хамааралгүй этгээд хооронд хийсэн ажил гүйлгээг;

6.1.44.“цахим гарын үсэг” гэж Цахим гарын үсгийн тухай хуулийн 4.1.1, 4.1.2-т заасныг;

6.1.45.“эдийн засгийн өгөөж олох” гэж үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, зардал хэмнэх, хүлээн авагчийн үйл ажиллагааны зардал, хугацааг багасгах замаар ашиг буюу ашигт ажиллагааг дээшлүүлсэн байхыг;

6.1.46.“эсэргүүцэл үзүүлсэн” гэж татварын улсын байцаагч, хураагчийг албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан хүч хэрэглэж эсэргүүцсэн, дарамталсан, заналхийлсэн, доромжилсон, айлгасан, сүрдүүлсэн санаатай үйлдэл, эс үйлдлийг;

6.1.47.“этгээд” гэж хувь хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага болон тэдгээртэй адилтгах иргэний харилцаанд оролцогчийг;

6.1.48.“эцсийн эзэмшигч” гэж ашигт малтмал, газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, газар эзэмших, ашиглах эрх эзэмшигч этгээдийн 30 болон түүнээс дээш хувийн хувьцаа, хувь оролцоо, эсхүл саналын эрхийг өөрөө, эсхүл нэг болон түүнээс дээш үргэлжилсэн хэлхээ холбоо бүхий хуулийн этгээдээр төлөөлүүлэн эзэмшдэг, саналын эрхийг төлөөлүүлэн хэрэгжүүлдэг, эсхүл ногдол ашгийг хүлээн авах эрхтэй этгээдийг.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ
## МОНГОЛ УЛСЫН ТАТВАР

**7 дугаар зүйл.Монгол Улсын татвар**

7.1.Монгол Улсын татвар нь албан татвар, төлбөр, хураамж /цаашид “татвар” гэх/-аас бүрдэнэ.

7.2.Монгол Улсын татвар нь доор дурдсан төрөлтэй байна:

7.2.1.аж ахуйн нэгжийн орлогын албан татвар;

7.2.2.гаалийн албан татвар;

7.2.3.нэмэгдсэн өртгийн албан татвар;

7.2.4.онцгой албан татвар;

7.2.5.автобензин, дизелийн түлшний албан татвар;

7.2.6.ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр;

7.2.7.ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр;

7.2.8.агаарын бохирдлын төлбөр;

7.2.9.улсын тэмдэгтийн хураамж;

7.2.10.ус бохирдуулсны төлбөр;

7.2.11.газрын тосны нөөц ашигласны төлбөр;

7.2.12.газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр;

7.2.13.хувь хүний орлогын албан татвар;

7.2.14.үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар;

7.2.15.малын тоо толгойн албан татвар;

7.2.16.автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар;

7.2.17.ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж;

7.2.18.газрын төлбөр;

7.2.19.галт зэвсгийн албан татвар;

7.2.20.нийслэл хотын албан татвар;

7.2.21.нохойны албан татвар;

7.2.22.өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар;

7.2.23.хог хаягдлын үйлчилгээний хураамж;

7.2.24.байгалийн ургамал ашигласны төлбөр;

7.2.25.усны нөөц ашигласны төлбөр;

7.2.26.рашаан ашигласны төлбөр;

7.2.27.ойн нөөц ашигласны төлбөр;

7.2.28.ан амьтны нөөц ашигласны төлбөр;

7.2.29.түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр.

7.3.Тодорхой төрлийн татварын харилцааг энэ хууль болон тухайн төрлийн татварын хуулиар зохицуулна.

**8 дугаар зүйл.Татварын хувь, хэмжээг тогтоох**

8.1.Татварын хувь, хэмжээг Улсын Их Хурал, түүний эрх олгосноор Засгийн газар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хууль тогтоомжийн дагуу тус тус тогтооно.

8.2.Энэ хуулийн 7.2.2, 7.2.3, 7.2.4, 7.2.6, 7.2.8, 7.2.10, 7.2.11, 7.2.18, 7.2.25, 7.2.27-д заасан татварын хувь, хэмжээг тухайн татварын харилцааг зохицуулсан хуульд Улсын Их Хурлаас тусгайлан эрх олгосон тохиолдолд тогтоосон хязгаарт багтаан Засгийн газар тогтоож болно.

8.3.Энэ хуулийн 7.2.13, 7.2.14, 7.2.15, 7.2.16, 7.2.17, 7.2.20, 7.2.21, 7.2.24, 7.2.26, 7.2.28, 7.2.29-д заасан татварын хувь, хэмжээг тухайн татварын харилцааг зохицуулсан хуульд Улсын Их Хурлаас тусгайлан эрх олгосон тохиолдолд тогтоосон хязгаарт багтаан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоож болно.

8.4.Энэ хуулийн 7.2.23-т заасан татварын хувь, хэмжээг Улсын Их Хурлаас тусгайлан эрх олгосон тохиолдолд тогтоосон хязгаарт багтаан сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоож болно.

8.5.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6.2-т заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг Засгийн газар, мөн хуулийн 6.3-т заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тус тус тогтооно.

**9 дүгээр зүйл.Татвар ногдох зүйл**

9.1.Татвар ногдох зүйлд орлого, хөрөнгө, бараа, ажил үйлчилгээ, тодорхой эрх, газар, түүний хэвлий, байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц, агаарын, хөрсний, усны бохирдол зэрэг зүйл хамаарна.

9.2.Татвар ногдох зүйлийг тухайн төрлийн татварын хуулиар нарийвчлан тогтооно.

**10 дугаар зүйл.Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт**

10.1.Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт дараах хэлбэртэй байна.

10.1.1.ногдуулсан татварыг хорогдуулах;

10.1.2.татварын хувь, хэмжээг бууруулах;

10.1.3.тогтоосон доод хэмжээнд хүрээгүй орлого, хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээг татвараас чөлөөлөх;

10.1.4.татвар төлөгчийг татвараас чөлөөлөх;

10.1.5.татвар ногдох зүйлийн зохих хэсгийг татвараас чөлөөлөх;

10.1.6.татварын хууль тогтоомжид заасан бусад.

10.2.Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх асуудлыг тухайн төрлийн татварын хуулиар нарийвчлан зохицуулах бөгөөд хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх үйл ажиллагааны журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

**11 дүгээр зүйл.Татварын хялбаршуулсан горим**

11.1.Татварын алба, татвар төлөгч татварын хялбаршуулсан горимыг ашиглаж болно.

11.2.Татварын хялбаршуулсан горим ашиглах татвар төлөгч нь татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд холбогдсон байна.

11.3.Хуульд өөрөөр заагаагүй бол татварын хялбаршуулсан горимыг зөвхөн татварын жилээр тооцох бөгөөд тухайн татварын жилийн дундуур уг горимоос шилжихийг хориглоно.

11.4.Татварын хялбаршуулсан горимыг хэрэгжүүлэх журмыг тухайн төрлийн татварын хуулиар нарийвчлан тогтооно.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ
## ТАТВАР ТӨЛӨГЧ

**12 дугаар зүйл.Татвар төлөгчийн эрх**

12.1.Татвар төлөгч дараах эрх эдэлнэ:

12.1.1.татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, татвар төлөгчийн эрхээ эдэлж, үүргээ биелүүлэхтэй холбогдсон мэдээлэл, зөвлөгөө, чиглэл, татвар ногдуулах, төлөх, тайлагнах журам, аргачлал, маягтыг татварын алба, татварын улсын байцаагчаас авах;

12.1.2.татварын хууль тогтоомжид заасан хөнгөлөлт эдлэх, татвараас чөлөөлөгдөх;

12.1.3.хууль тогтоомжийн дагуу татвар төлөх хугацааг сунгуулах;

12.1.4.илүү төлсөн татварыг буцаан авах, суутган тооцуулах, алданги тооцон нэхэмжлэн авах;

12.1.5.эрх, хууль ёсны ашиг сонирхлоо биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгч, мэргэшсэн зөвлөхөөрөө дамжуулан хамгаалах, төлөөлүүлэх, татварын хяналт шалгалтад биечлэн байлцах;

12.1.6.татварын албанаас гаргасан татварын акт, бусад баримт бичигтэй танилцах, үндэслэлгүй буюу хуульд нийцээгүй гэж үзвэл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор захиргааны болон шүүхийн журмаар гомдол гаргах;

12.1.7.татвар ногдуулалт, төлөлт, хяналт шалгалтын дүнгийн талаар тайлбар авах буюу өгөх;

12.1.8.татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөхийг татварын алба, татварын улсын байцаагчаас шаардах, татварын албаны хууль бус шийдвэр, үйлдлийн улмаас учирсан хохирлыг хуульд заасан журмын дагуу нөхөн төлүүлэх;

12.1.9.татварын алба, татварын улсын байцаагчийн хууль бус ажиллагаа болон шийдвэрт холбогдох гомдлыг түүнийг шууд захирдаг болон дээд шатны албан тушаалтанд, түүнчлэн шүүхэд гаргах. Ийнхүү гомдол гаргасан нь ногдуулсан татвар, торгууль, алдангийг төлөхийг зогсоох үндэслэл болохгүй;

12.1.10.татварын хууль тогтоомжоор ногдсон үүргээ биелүүлэх, эрхээ эдлэх талаар хуулиар зөвшөөрөгдсөн итгэмжлэгдсэн нягтлан бодогч, татварын зөвлөхийн туслалцаа, зөвлөгөө авах;

12.1.11.хөрөнгө оруулалтын хууль тогтоомжид заасны дагуу тогтворжуулах гэрчилгээ авсан бол уг гэрчилгээ хүчинтэй байх хугацаанд хувь, хэмжээг нь тогтворжуулсан татварыг тогтворжуулсан хувь, хэмжээнээс илүү хэмжээгээр төлөхгүй байх;

12.1.12.хууль тогтоомжид заасан бусад эрх.

12.2.Татварын алба энэ хуулийн 12.1.1-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор хяналт шалгалтад хамруулах эрсдэлийн үнэлгээний нарийвчилсан үзүүлэлтийг татвар төлөгчид мэдээлэхгүй.

**13 дугаар зүйл.Нууцлалын баталгаа**

13.1.Татварын алба нь энэ хуульд зааснаас бусад үндэслэлээр татвар төлөгчийн мэдээллийг бусдад өгөх, эсхүл хувийн зорилгоор ашиглах байдлаар задруулахыг хориглоно.

13.2.Татварын алба, татварын улсын байцаагч, татварын албаны бусад ажилтан болон татварын албанд ажиллаж байсан этгээд, татварын албаны хэрэгжүүлэх нийтлэг үйл ажиллагаанд хөндлөнгийн гэрчээр оролцсон хүн нь албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн татвар төлөгчийн мэдээллийн нууцыг хадгалах үүрэгтэй бөгөөд доор дурдсан албан тушаалтанд татварын албаны даргын шийдвэрээр танилцуулж болно:

13.2.1.татварын хууль тогтоомжийн дагуу албан үүргээ гүйцэтгэж байгаа татварын улсын байцаагч;

13.2.2.татварын хууль тогтоомж зөрчсөн зөрчил, гэмт хэргийг бүртгэх шалгах, хянах, шийдвэрлэх үүрэг хүлээсэн хэрэг бүртгэгч, мөрдөгч, прокурор, шүүгчид зөвхөн уг зөрчил, гэмт хэрэгт холбогдох асуудлаар;

13.2.3.олон улсын гэрээний дагуу харилцан мэдээлэл солилцох зорилгоор томилогдсон буюу сонгогдсон эрх бүхий албан тушаалтанд гэрээтэй холбоотой мэдээлэл солилцох асуудлаар.

13.3.Татвар төлөгч зөвшөөрсөн, эсхүл хууль болон сонгон шалгаруулалтын шаардлагаар олон нийтэд мэдээлэх татвар төлөгчийн нэр, дугаар, төлсөн татварын мэдээлэл, статистикийн зорилгоор татварын албанд нэгтгэсэн нэгдсэн тайлан, мэдээ энэ хуулийн 13.1-д хамаарахгүй.

13.4.Татвар төлөгч нь татварын хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд хууль тогтоомжид заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй, нэг зөрчлийг гурав болон түүнээс дээш удаа давтан гаргасан, эсхүл эрэн сурвалжлагдаж байгаа татвар төлөгчийн талаар татварын алба татвар төлөгчийн зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлж болно.

13.5.Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн нууц мэдээллийн санд нэвтрэх эрхтэй татварын улсын байцаагчийг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын шийдвэрээр томилох бөгөөд түүний нууц мэдээллийн санд нэвтрэх, ашиглах үйлдэл бүртгэлтэй байна.

**14 дүгээр зүйл.Татвар төлөх үүрэг дуусгавар болох, бусдад шилжих**

14.1.Татвар төлөх үүрэг дараах тохиолдолд дуусгавар болно:

14.1.1.тухайн төрлийн татварын өрийг төлж дууссан;

14.1.2.бусад татварын илүү төлөлтийг тухайн төрлийн татварын өрд суутган тооцсон;

14.1.3.татвар төлөгч тухайн төрлийн татвараас хуулиар чөлөөлөгдсөн;

14.1.4.тухайн төрлийн татварын хууль хүчингүй болсон, уг хуулийн дагуу ногдуулах татварын өрийг төлж дууссан;

14.1.5.нас барсан болон нас барсанд тооцсон татвар төлөгч хувь хүн нь өв залгамжлагчгүй, эсхүл өвлүүлэх хөрөнгөгүй нь шүүхээр тогтоогдсон.

14.2.Хуулийн этгээд татан буугдсан тохиолдолд татан буулгах комисс, дампуурсан тохиолдолд хэрэг гүйцэтгэгч төлөөгүй татварыг хуулийн этгээдийн хөрөнгөөс хуульд заасан журмаар гаргуулж холбогдох төсөвт төлнө.

14.3.Хуулийн этгээдийг нэгтгэх, нийлүүлэх, өөрчлөх замаар өөрчлөн байгуулсан тохиолдолд татвар ногдуулалт, төлөлттэй холбогдсон эрх, үүрэг өөрчлөн байгуулагдсаны үр дүнд бий болсон хуулийн этгээдэд шилжинэ.

14.4.Хуулийн этгээдийг тусгаарлах, хуваах замаар өөрчлөн байгуулсан тохиолдолд татвар ногдох зүйл, хуваарилагдсан хөрөнгийн хэмжээнд хувь тэнцүүлэн татвар ногдох үүрэг тэдгээрт шилжинэ.

14.5.Татан буугдаж байгаа хуулийн этгээдийг энэ хуулийн дагуу эрсдэлтэй гэж тооцсон тохиолдолд татварын хяналт шалгалтад хамруулна.

14.6.Нас барсан болон нас барсанд тооцсон хувь хүний татвар төлөх үүрэг, түүнтэй холбогдох эрх өв залгамжлагчид нь өвлөсөн хөрөнгөд ногдох хэмжээгээр шилжих бөгөөд үүнд татварын торгууль хамаарахгүй.

**15 дугаар зүйл.Татварын хөөн хэлэлцэх хугацаа**

15.1.Татварын нөхөн ногдуулалт хийх, алданги, торгууль ногдуулах, хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх, алдагдал шилжүүлэх, нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулах хөөн хэлэлцэх хугацаа 4 жил байх бөгөөд Иргэний хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа татварын хууль тогтоомжид хамаарахгүй.

15.2.Татвар, алданги, торгуулийн өр төлөх болон энэ хуулийн 12 дугаар бүлэгт заасан татварын өр хураах журам, түүнчлэн татвар төлөгчид гаргасан хүсэлтийнх нь дагуу төлсөн татварыг буцаан олгохтой холбогдсон харилцаанд энэ хуулийн 15.1-д заасан хугацаа хамаарахгүй.

15.3.Энэ хуулийн 15.1-д заасан хугацааг дараах байдлаар тоолно:

15.3.1.тайлант жилийн эцэст нэг удаа гаргаж, татвар төлөхөөр хуульд заасан татварын төрлийн хувьд уг тайланг гарган, татвараа төлж дууссан байх ёстой өдрийн дараагийн ажлын өдрөөс;

15.3.2.тайланг сар, улирлаар гаргаж татвар төлөхөөр хуульд заасан татварын төрлийн хувьд тухайн жилийн 12 дугаар сарын буюу жилийн эцсийн тайлан гаргаж, татвараа төлж дууссан байх ёстой өдрийн дараагийн ажлын өдрөөс;

15.3.3.борлуулалт хийгдсэнээс хойш тодорхой хугацааны дотор татвар төлөхөөр хуульд заасан татварын төрөл болон суутгаж төлдөг татварын хувьд тухайн төрлийн татварын тайланг гарган, татвараа төлж дууссан байх ёстой өдрийн дараагийн ажлын өдрөөс;

15.3.4.тайлан гаргахгүй төлдөг татварын хувьд тухайн төрлийн татварын хуульд заасан татвараа төлж дууссан байх ёстой өдрийн дараагийн ажлын өдрөөс.

15.4.Татвар төлөгч татварын асуудлаар маргаан таслах зөвлөлд гомдол гаргасан бол тогтоол гарах хүртэл, шүүхэд гомдол гаргасан, эсхүл хууль хяналтын байгууллагаар хянан шалгагдаж байгаа бол эцсийн шийдвэр гарах хүртэлх хугацаагаар татварын хөөн хэлэлцэх хугацаа тасалдана.

15.5.Татварын алба үнэ шилжилтийн тохируулга хийх зорилгоор гадаад улсын татварын албанаас мэдээлэл гаргуулах хүсэлт гаргасан өдрөөс хүсэлтийн хариу ирсэн өдөр хүртэлх хугацаагаар татварын хөөн хэлэлцэх хугацааг тасалдсанд тооцно.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
## ОЛОН УЛСЫН ТАТВАРЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ТАТВАРААС ЗАЙЛСХИЙХИЙН ЭСРЭГ ЕРӨНХИЙ ДҮРЭМ

**16 дугаар зүйл.Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрэм**

16.1.Татварын хяналт шалгалтын үеэр доор дурдсан нөхцөл бүрдсэн нь тогтоогдсон боловч хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлэн татварыг нөхөн ногдуулах боломжгүй бол Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрмийг хэрэгжүүлэх эрхтэй байна:

16.1.1.татвар төлөгч нь дангаараа, эсхүл бусад этгээдтэй хамтран татварын схем зохион байгуулсан;

16.1.2.энэ хуулийн 16.1.1-д заасан татварын схемийн хүрээнд тухайн татвар төлөгч татвараас зайлсхийх замаар татварын ашиг хүртсэн.

16.2.Татвар төлөгч нь энэ хуулийн 16.1-д заасан хэлбэрээр татвараас зайлсхийж татварын ашиг хүртсэн бол татварын алба татвар төлөгчийн татварын ногдлын хэмжээг дээр дурдсан татварын схемийг ашиглаагүй, эсхүл татварын ашиг хүртээгүй байх нөхцөлөөр дахин тодорхойлж татварын ногдолд залруулга хийнэ.

16.3.Татвар төлөгч энэ хуулийн 16.1.1, 16.1.2-т заасан үйлдлийг бусад этгээдтэй хамтран хэрэгжүүлсэн бол уг хамтарсан этгээдийн татварын ногдлыг уг нөхцөлөөр дахин тодорхойлж, залруулга хийнэ.

16.4.Татварын алба энэ хуульд заасны дагуу залруулга хийсэн бол холбогдох татварыг нөхөн ногдуулна.

16.5.Нөхөн ногдуулалтыг энэ хуулийн 15.1-д заасан хөөн хэлэлцэх хугацаанд багтаан эхлүүлэх бөгөөд нөхөн ногдуулалтын хамрах хугацаа нь энэ хуулийн 16.3, 16.4-т зааснаар татварын ногдлыг тодорхойлсноос өмнөх 4 жилийг хамаарна.

16.6.Энэ хуулийн 16.1.1-д заасан татварын схемийг ашиглан дараах үр дүнд хүрсэн бол энэ хуулийн 16.1.2-т заасан татварын ашиг хүртсэнд тооцно:

16.6.1.татварын суурийг бууруулах буюу татвараас чөлөөлөгдөх орлого, татварын хөнгөлөлт, суутган тооцоолол, татвар ногдох орлогоос хасагдах зардлыг бүртгэлийн аргаар өөрчлөх;

16.6.2.татвар төлөх үүргийг хойшлуулах;

16.6.3.татвар төлөх үүргийг хойшлуулснаар үүсэх давуу байдал олж авах;

16.6.4.чөлөөлөгдөх орлого, эсхүл татвар ногдохгүй орлогын хэмжээг нэмэгдүүлэх замаар татвар ногдох орлогыг бууруулах;

16.6.5.татвар ногдох орлогод татвар ногдуулахгүй байх.

16.7.Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрмийг хэрэгжүүлэх эсэхийг Эрсдэлийн удирдлагын хороо шийдвэрлэх бөгөөд хэрэгжүүлэх журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Тайлбар:“Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрэм” гэж олон улсын татварын харилцаанд нийтлэг ашиглагддаг “General Anti-Avoidance Rule”-ийг ойлгоно.

**17 дугаар зүйл.Харилцан тохирох журам**

17.1.Монгол Улсаас бусад улстай байгуулсан Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээрийн харилцан тохирох журмыг хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлнэ.

17.2.Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улстай харилцан тохирох журмын асуудлаар олон улсын гэрээ байгуулаагүй гадаад улсын татвар төлөгчид энэ хуулийн 17.1 дэх хэсэг хамаарахгүй.

17.3.Татварын харилцан тохирох журмыг Монгол Улсаас бусад улстай байгуулсан олон улсын гэрээ, нэгдэн орсон олон улсын байгууллагаас тавигдах шаардлагад нийцүүлэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

**18 дугаар зүйл.Гадаад улсын эрх бүхий байгууллагатай харилцан мэдээлэл солилцох журам**

18.1.Энэ зүйлд заасан дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

18.1.1.“мэдээллийг автоматаар солилцох” гэж энэ хуулийн 18.1.5-д заасан хэлэлцээрийн хүрээнд гадаад улсын оршин суугч этгээдийн талаарх хэлэлцэн тохирсон мэдээллийг аливаа урьдчилсан хүсэлтгүйгээр тогтмол, тодорхой хугацааны давтамжтай хэлэлцэн тохирогч талууд хоорондоо солилцохыг;

18.1.2.“мэдээлэл” гэж энэ хуулийн 18.1.5-д заасан хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор доор дурдсаны аль нэг, эсхүл бүгдийг нь агуулсан үйл баримт, тайлан, баримт, бүртгэл, дансны мэдээллийг;

18.1.2.а.банк, санхүүгийн байгууллага, тэдгээрээс томилогдсон этгээд, хөрөнгө итгэмжилсэн этгээд, зуучлагч болон батлан даах чадвар бүхий этгээдийн мэдэлд байгаа баримт, тайлан, бүртгэл, дансны мэдээллийг;

18.1.2.б.хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч, нөхөрлөл болон бусад этгээдэд хамааралтай үйл баримт, тайлан, баримт, бүртгэл, дансны мэдээллийг;

18.1.2.в.хамтын хөрөнгө оруулалтын сангийн хувьд хувьцаа, хувь оролцоо, нэгж эрх болон бусад ашиг сонирхлын тухай мэдээллийг, итгэлцлийн сангийн хувьд төлбөр тооцоо гүйцэтгэгч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, болон өгөөж хүртэж байгаа этгээдийн талаарх мэдээллийг.

18.1.3.“санхүүгийн байгууллага” гэж энэ хуулийн 18.1.5-д заасан хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор тодорхойлсон банк, банк бус санхүүгийн, кастодиан, хадгаламж, хөрөнгө оруулалтын болон даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг хувь хүнээс бусад этгээдийг;

18.1.4.“тал” гэж Хэлэлцээрт оролцогч талыг;

18.1.5.“хэлэлцээр” гэж Монгол Улсаас бусад улстай байгуулсан татварын зорилгоор мэдээлэл солилцох, түүний дотор автоматаар мэдээлэл солилцох олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенцыг;

18.1.6.“хүсэлт” гэж энэ хуулийн 18.1.5-д заасан хэлэлцээрийн хүрээнд аль нэг тал нөгөө талдаа гаргасан өргөдлийг;

18.1.7.“хүсэлт гаргагч улс” гэж энэ хуулийн 18.1.5-д заасан хэлэлцээрийн хүрээнд мэдээлэл авах хүсэлт гаргаж байгаа улсыг;

18.1.8.“цахим мэдээлэл" гэж энэ хуулийн 18.13-т заасан цахим аргаар боловсруулж хадгалсан бичлэгийг;

18.1.9.“эрх бүхий этгээд” гэж Монгол Улсын хувьд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, эсхүл түүний томилсон эрх бүхий этгээд, гадаад улсын хувьд хэлэлцээрийн хүрээнд тодорхойлсон хэлэлцэн тохирогч талын томилсон эрх бүхий этгээдийг;

18.1.10.“эрх бүхий этгээд хоорондын хэлэлцээр” гэж энэ хуулийн 18.1.5-д заасан хэлэлцээрийг хэрэгжүүлэх, хэлэлцээрийн зүйл, заалтыг тайлбарлах, тодруулах зорилгоор хэлэлцэн тохирогч талуудын томилсон эрх бүхий этгээд хооронд байгуулсан хоёр талт болон олон талт гэрээ, хэлэлцээрийг.

18.2.Монгол Улсаас бусад улстай байгуулсан хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор эрх бүхий этгээд нь гадаад улсын эрх бүхий этгээдтэй зөвхөн татварын асуудлаар энэ хуулийн 18.1.2-т заасан мэдээлэл харилцан солилцоно.

18.3.Энэ хуулийн 18.1.9-д заасан эрх бүхий этгээд нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

18.3.1.энэ хуулийн 18.1.6-д заасан хүсэлтийг биелүүлэх зорилгоор дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж болно:

18.3.1.а.аливаа этгээдээс тайлан, дансны мэдээллийг авах;

18.3.1.б.энэ хуулийн 18 дугаар зүйл болон хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор мэдээлэл хүсэх этгээдэд холбогдох мэдээлэл болон нотлох баримтыг цуглуулан авч, хүргүүлэх;

18.3.1.в.баримт материалыг хүргүүлэх;

18.3.1.г.энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан мэдээлэл харилцан солилцох болон гэрээнд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор эрх бүхий этгээд нь энэ хуулийн 19, 20, 21, 22, 23, 24 дүгээр зүйлд заасан нийтлэг ажиллагааг хэрэгжүүлэх;

18.3.1.д.шаардлагатай бусад арга хэмжээ.

18.3.2.энэ хуулийн 18.1.5-д заасан хэлэлцээрийн дагуу хэлэлцэн тохирогч талуудтай татварын зорилгоор энэ хуулийн 18.1.2-т заасан мэдээлэл солилцох, мэдээлэл автоматаар солилцох, эрх бүхий этгээд хооронд байгуулсан хэлэлцээрийг хэрэгжүүлэх;

18.3.3.энэ хуулийн 18.1.5-д заасан хэлэлцээрийн хүрээнд үүсэж болох зардлыг тодорхойлж, аливаа хүсэлттэй холбогдуулан гарах зардлыг тооцоолж тэнцвэртэй хуваарилах;

18.3.4.энэ хуулийн 18.1.5-д заасан хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах зорилгоор бусад улсын эрх бүхий этгээдтэй эрх бүхий этгээд хоорондын хэлэлцээрийг байгуулж, тэдгээртэй хамтран ажиллах журмыг батлах;

18.3.5.энэ зүйлд заасан бусад чиг үүрэг.

18.4.Эрх бүхий этгээд нь тухайн улстай байгуулсан хэлэлцээрийн нөхцөлийн дагуу хүсэлт гаргагч улсад туслалцаа үзүүлж ажиллана.

18.5.Энэ хуулийн 18.1.6-д заасан хүсэлтийг хүлээн авсны дараа эрх бүхий этгээд энэ зүйл болон холбогдох хэлэлцээрт нийцүүлэн хүсэлтийг биелүүлнэ.

18.6.Эрх бүхий этгээд шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 18.1.7-д заасан хүсэлт гаргагч улсаас хүсэлтийн талаар нэмэлт мэдээлэл шаардаж болно.

18.7.Эрх бүхий этгээд нь хэлэлцэн тохирогч талын хүсэлтээр энэ хуулийн 18.1.2-т заасан мэдээлэл болон аливаа этгээд, санхүүгийн байгууллагын эзэмшил, хяналтад байгаа шаардлагатай бусад мэдээллийг татварын зорилгоор ашиглах эсэхээс үл хамаарч энэ хуульд заасан мэдэгдэл хүргүүлсний үндсэн дээр санхүүгийн байгууллагаас авч, хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.

18.8.Энэ хуулийн 18.7-д заасан мэдэгдэлд дараах мэдээллийг тусгаж болно:

18.8.1.мэдээлэл ирүүлэх хугацаа;

18.8.2.баримтын эх хувь, эсхүл түүний хуулбарыг авах эсэх талаар эрх бүхий этгээдээс шаардсан хэлбэр;

18.8.3.баримтыг албан ёсоор баталгаажуулах эсэх.

18.9.Эрх бүхий этгээдийн хүсэлтийг үндэслэн энэ хуулийн 18.1.2-т заасан мэдээллийг гэрчийн мэдүүлэг хэлбэрээр авч болно.

18.10.Энэ хуулийн 18.8.1-д заасан хугацаа хуанлийн 14 хоногоос хэтрэхгүй бөгөөд шаардлагатай гэж үзвэл эрх бүхий этгээд уг хугацааг өөрөөр тогтоож болно.

18.11.Эрх бүхий этгээд нь энэ хуулийн 18.7-д заасан мэдээллийг хадгалж, хувилж, хуулбарлаж болно.

18.12.Хууль зүйн давуу байдлаар олж авсан мэдээллийг энэ хуулийн 18.7-д заасан мэдэгдлээр гаргуулахыг хориглоно.

18.13.Мэдэгдлийн хүрээнд авсан мэдээлэл цахим хэлбэрээр хадгалагдаж байгаа бол түүний агуулгыг өөрчлөлгүйгээр бичгэн хэлбэрт оруулж дахин боловсруулна.

18.14.Эрх бүхий этгээд ирүүлсэн хүсэлтийг холбогдох хэлэлцээрт нийцэхгүй болохыг тогтоосон бол хүсэлтээс татгалзаж, энэ талаар хүсэлт гаргагч улсад нэн даруй мэдэгдэнэ.

18.15.Хүсэлтээс татгалзсан бол эрх бүхий этгээд болон хүсэлт гаргагч улсын зүгээс холбогдох хэлэлцээрт заасны дагуу асуудлыг шийдвэрлэнэ.

18.16.Баримт бичиг болон мэдэгдлийг холбогдох этгээдэд биечлэн, шуудангаар, эсхүл санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тогтоосон хэлбэрээр хүргүүлж болно.

18.17.Эрх бүхий этгээд хоорондын хэлэлцээрийн хүрээнд мэдээлэл автоматаар солилцох зорилгоор эрх бүхий этгээд нь шаардлагатай мэдээллийг тогтоосон хугацаанд, тодорхой хэлбэрт нийцүүлж ирүүлэхийг энэ хуулийн 18.1.3-т заасан байгууллагаас шаардаж болно.

18.18.Энэ хуулийн 18.17-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор санхүү, төсвийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран дараах журмыг баталж, мөрдүүлж болно:

18.18.1.тайлан, мэдээлэл ирүүлэх шаардлагатай санхүүгийн байгууллагуудыг тодорхойлох;

18.18.2.тайлагнах шаардлагатай мэдээлэл, цахим мэдээллийн агуулга, загвар;

18.18.3.тайлагнах мэдээллийн иж бүрдэл, нарийвчлал зэргийг заасан стандарт;

18.18.4.мэдээлэл харилцан солилцох хэлэлцээрийг хэрэгжүүлэх журам;

18.18.5.мэдээллийн нууцлал, хадгалах үйл ажиллагааг зохицуулсан журам;

18.18.6.энэ хуулийн 18.15-д заасныг болон автоматаар мэдээлэл харилцан солилцохтой холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж үзсэн журам.

18.19.Татварын албаны мэдээллийн нууцлалтай холбоотой харилцаанд энэ хуулийн 13 дугаар зүйлд заасныг баримтална.

18.20.Энэ хуулийг хэрэгжүүлэх үүрэгтэй эсхүл хэрэгжүүлж байсан этгээд нь энэ хуулийн 18 дугаар зүйл болон хэлэлцээрийн хүрээнд олж авсан мэдээллийг нууцлах үүрэгтэй бөгөөд зөвхөн энэ хууль болон хэлэлцээрээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх зорилгоор мэдээллийг ашиглаж болно.

18.21.Татварын алба нь татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор эрх бүхий этгээдийн олж авсан мэдээллийг ашиглаж болно.

18.22.Энэ хуульд заасны дагуу мэдээллийг хүсэлтээр болон автоматаар солилцох зорилгоор нууц мэдээллийг эрх бүхий этгээдэд хүргүүлсэн бол уг үйлдэлтэй холбогдуулж мэдээлэл задруулсан үндэслэлээр бусад хуулиар хариуцлага хүлээлгэхгүй.

18.23.Энэ хуулийн 18.22-т заасны дагуу мэдээлэл өгч байгаа этгээдийн үйлдэл нь уг асуудлаар бусад этгээдтэй байгуулсан нууцлалын баталгааг зөрчсөн үйлдэл болохгүй бөгөөд энэ үйлдэлд тухайн этгээд болон түүний ажил олгогчид хариуцлага хүлээлгэхгүй.

18.24.Аливаа этгээд нь хууль зүйн давуу байдлаар олж авсан мэдээллээ бусдад задруулж иргэний болон эрүүгийн хэрэгт холбогдсон бол энэ хуулийн 18.22-т заасан хамгаалалтад хамаарахгүй.

18.25.Эрх бүхий этгээд, эсхүл түүний эрх олгосон этгээд нь энэ хуульд заасан албан үүргээ зохих журмын дагуу гүйцэтгэх явцад хийсэн үйлдэл, эс үйлдлийн улмаас хохирол учруулсан нь уг этгээдэд иргэний болон эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй.

18.26.Энэ зүйлийн заалтууд нь бусад хууль тогтоомжоор зохицуулж байгаа мэдээллийн нууцлалтай холбоотой хязгаарлалтаас үл хамааран давуу эрхтэй үйлчилнэ.

18.27.Энэ хууль болон хэлэлцээрийн заалтууд нь бусад хууль тогтоомжийн заалттай зөрчилдөж байгаа тохиолдолд энэ хууль болон хэлэлцээрийн заалтууд давуу эрхтэй үйлчилнэ.

## ТАВДУГААР БҮЛЭГ
## ТАТВАРЫН НОГДЛЫГ ТОДОРХОЙЛОХ, ТАТВАР ХУРААХ ЗОРИЛГООР ХЭРЭГЖҮҮЛЭХ НИЙТЛЭГ АЖИЛЛАГАА

### 19 дүгээр зүйл.Татварын ногдлыг тодорхойлох, татвар хураах зорилгоор хэрэгжүүлэх нийтлэг ажиллагаа

19.1.Татварын улсын байцаагч татварын ногдлыг тодорхойлох болон татвар хураах зорилгоор татвар төлөгчийн байр агуулахад нэвтрэн орж мэдээ, мэдээлэл, баримт цуглуулах, үзлэг хийх, тооллого явуулах, ажлын зураг авалт хийх зэрэг нийтлэг ажиллагааг хэрэгжүүлэх эрхтэй.

19.2.Татварын улсын байцаагч энэ хуулийн 19.1-д заасан нийтлэг ажиллагааг хэрэгжүүлэхдээ татварын улсын байцаагчийн үнэмлэхээ үзүүлж, үйл ажиллагааны зорилгыг тайлбарлана.

19.3.Энэ зүйлд заасан татварын улсын байцаагчийн хэрэгжүүлэх нийтлэг үйл ажиллагаанд татвар төлөгч хүч хэрэглэж, эсхүл зохион байгуулалттайгаар эсэргүүцэл үзүүлсэн тохиолдолд цагдаагийн байгууллага Цагдаагийн албаны тухай хуулийн 15.1.7-д заасны дагуу дэмжлэг үзүүлнэ.

19.4.Энэ хуулийн 19.1-д заасан байр агуулахад нэвтрэн орж мэдээ, мэдээлэл, баримт цуглуулах, үзлэг хийх, тооллого явуулах, ажлын зураг авалт хийхтэй холбогдсон журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

19.5.Энэ хуулийн 19.3-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх журмыг санхүү, төсвийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

### 20 дугаар зүйл.Байр, агуулахад нэвтрэн орох

20.1.Татварын улсын байцаагч нь татвар төлөгчийн орлого олох зориулалтаар ашиглаж байгаа, эсхүл татвар ногдох зүйл болон татвартай холбогдолтой мэдээ, судалгаа, бусад баримтыг хадгалж байгаа, нэвтрэн орохыг хуулиар хориглоогүй үйлдвэрлэл, үйлчилгээний газар, албан байр, агуулах, зооринд нэвтрэн орж, ажлын зураг авалт, үзлэг хийх, тооллого явуулах, баримт бичиг, эд хөрөнгийг түр хугацаагаар хураах, хяналт шалгалтын ажил хийх эрхтэй.

20.2.Татварын улсын байцаагч мэдээ, мэдээлэл, баримт цуглуулах зорилгоор байр, агуулахаас гадна татвар төлөгчийн орлого, зарлага, ажил гүйлгээний мэдээлэл бүхий компьютер, техник хэрэгсэл, программ хангамжид нэвтрэн орох эрхтэй.

20.3.Энэ хуулийн 20.1-д заасан үйл ажиллагааг татвар төлөгчийн аль байр, агуулахад хийхийг удирдамжид тодорхой тусгаж харьяалах татварын албаны албан томилолтоор гүйцэтгэнэ.

20.4.Гадаад орны дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын байр, дархан эрх, эрх ямба бүхий албан тушаалтны ажлын байранд энэ хуулийн 20.1-д заасан ажиллагаа явуулахыг хориглоно.

**21 дүгээр зүйл.Мэдээ, мэдээлэл, баримт цуглуулах**

21.1.Татварын алба мэдээ, мэдээлэл, баримт цуглуулахад дараах журмыг баримтална:

21.1.1.татварын албаны шаардсан мэдээ, мэдээлэл, баримтыг эх хувиар түр хугацаагаар гаргуулахдаа тэмдэглэл үйлдэж, гарын үсэг зуруулах;

21.1.2.шаардлагатай тохиолдолд мэдээ, мэдээлэл, баримтыг хуулбарлах, гэрэл зураг, дүрс, дууны болон бусад бичлэгээр баримтжуулах;

21.1.3.тайлбар, лавлагааг бичгээр гаргуулах, эсхүл ярилцлага хийсэн бол тэмдэглэл үйлдэж, холбогдох этгээдээр гарын үсэг зуруулах;

21.1.4.энэ хуулийн 21.1.1, 21.1.2, 21.1.3-т заасантай адилтгах бусад мэдээ, мэдээлэл, баримт гаргуулах.

21.2.Татварын алба татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай магадлагаа, баримтын хуулбар, мэдээ, судалгаа, дансны хуулга, холбогдох бусад баримт бичиг, мэдээллийг татвар төлөгч, түүнтэй харилцагч аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн, санхүүгийн байгууллагаас үнэ төлбөргүй гаргуулан авна.

21.3.Энэ хуулийн 21.2-т заасан мэдээ, мэдээлэл, баримтыг хуулбарлах, баримтжуулахад бусдын техник хэрэгслийг ашигласан бол хөлсийг нь зах зээлийн, эсхүл харилцан тохиролцсон үнээр татварын алба төлнө.

21.4.Татварын алба татвар төлөгчийн борлуулалт, худалдан авалт, хүний нөөц, техникийн үйлчилгээ, хоршсон үйлдвэрлэл, үйл ажиллагаанд ашигласан үнэ, төлбөр, хураамж, гэрээ хэлцэл зэрэг мэдээ, мэдээлэл, баримтыг гаргуулахаар татвар төлөгч болон түүнтэй хамтран үйл ажиллагаа явуулсан гуравдагч этгээдээс шаардах эрхтэй.

21.5.Татварын алба мэдээ, мэдээлэл баримт цуглуулах зорилгоор татвар төлөгчтэй харилцаа бүхий гуравдагч этгээдээс дараах журмаар мэдээлэл гаргуулж болно:

21.5.1.мэдээлэл агуулж байгаа байр агуулах, баримт материал, компьютер зэрэгт бүрэн нэвтрэх;

21.5.2.мэдээлэл болон баримт бичгийг шаардах;

21.5.3.тодорхой газар болон хугацаанд мэдээлэл авахаар дуудан ирүүлэх.

**22 дугаар зүйл.Үзлэг хийх**

22.1.Татварын алба үзлэг хийхэд дараах журмыг баримтална:

22.1.1.эрх зүйн бүрэн чадамжтай, 18 насанд хүрсэн, ашиг сонирхлын зөрчилгүй, татвар төлөгч, татварын алба, татварын улсын байцаагчтай захирах, захирагдах ёсны харилцаагүй хөндлөнгийн гэрчийг байлцуулах;

22.1.2.үзлэгт хамрагдаж байгаа бичиг баримт, эд хөрөнгийн эзэмшигч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, хэрэв боломжгүй бол тухайн нутгийн захиргааны байгууллагын төлөөлөгчийг байлцуулах;

22.1.3.үзлэг явуулсан тухай тэмдэглэл үйлдэж оролцсон болон байлцсан хүмүүсээр гарын үсэг зуруулах, хэрэв гарын үсэг зурахаас татгалзвал шалтгааныг нь тайлбарлах бололцоо олгож, тайлбарыг тэмдэглэлд хавсаргах.

22.2.Үзлэгт хамрагдах зүйлийн өмчлөл, эзэмшлийн ялгааг үл харгалзан Татварын алба, татварын улсын байцаагч нь үзлэг хийх эрхтэй.

22.3.Татварын алба үзлэг хийх явцад татвар хураалт, хяналт шалгалтад ашиглах мэдээ, мэдээлэл, баримт цуглуулах эрхтэй.

**23 дугаар зүйл.Тооллого явуулах**

23.1.Татварын алба тооллого явуулахад дараах журмыг баримтална:

23.1.1.бараа, эд хөрөнгө, бэлэн мөнгөний тооллого хийхдээ татвар төлөгч болон түүний хууль ёсны төлөөлөгч, нягтлан бодогч, эсхүл тухайн нутгийн захиргааны байгууллагын төлөөлөгчийг байлцуулж, тооллогын бүртгэл, тэмдэглэл үйлдэх;

23.1.2.тооллогын бүртгэл, тэмдэглэлд тооллого хийсэн татварын улсын байцаагч болон тооллого явуулахад байлцсан бусад хүмүүс гарын үсэг зурах бөгөөд гарын үсэг зурахаас татгалзвал шалтгааныг нь тайлбарлах бололцоо олгож, тайлбарыг тэмдэглэлд хавсаргах.

23.2.Татварын алба тооллого хийх явцад татвар хураалт, хяналт шалгалтад ашиглах мэдээ, мэдээлэл, баримт цуглуулах эрхтэй.

**24 дүгээр зүйл.Ажлын зураг авалт хийх**

24.1.Татварын алба ажлын зураг авалт хийхэд дараах журмыг баримтална:

24.1.1.татвар төлөгчийн төлбөл зохих татварын хэмжээг тодорхойлох, үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ, орлого, зардлыг тогтоох зорилгоор ажлын зураг авалтыг урьдчилан мэдэгдэж, эсхүл мэдэгдэхгүйгээр хийх;

24.1.2.ажлын зураг авалтад холбогдох мэргэжилтэн оролцуулж, шаардлагатай хэмжих хэрэгсэл ашиглах;

24.1.3.ажлын зураг авалтын тооцоо дүгнэлт хийж, тэмдэглэл үйлдэх, уг тэмдэглэлд байлцсан хүмүүсээр гарын үсэг зуруулах, гарын үсэг зурахаас татгалзвал шалтгааныг нь тайлбарлах бололцоо олгож, тайлбарыг тэмдэглэлд хавсаргах.

II ХЭСЭГ

ТАТВАРЫН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТ

**ЗУРГАДУГААР БҮЛЭГ**

## ТАТВАР ТӨЛӨГЧИЙГ БҮРТГЭХ, ТАТВАР НОГДУУЛАХ, ТӨЛӨХ, ТАЙЛАГНАХ

**25 дугаар зүйл.Татвар төлөгчийн бүртгэл**

25.1.Татварын хуулиар татвар төлөх, эсхүл татвар суутгах үүрэг бүхий этгээд нь татвар төлөгчөөр бүртгүүлнэ.

25.2.Дараах хувь хүнийг татвар төлөгчөөр бүртгэж татвар төлөгчийн дугаар олгоно:

25.2.1.Монгол Улсын иргэн;

25.2.2.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 5.1.5-д заасан гадаадын иргэн.

25.3.Татвар төлөгчийг бүртгэхдээ энэ хуулийн 26 дугаар зүйлд заасан нийтлэг журмыг баримтална.

25.4.Татвар төлөгчийг бүртгэх журмыг тухайн төрлийн татварын хуулиар нарийвчлан зохицуулна.

25.5.Оршин суугч бус этгээдийг түүний оршин суугчийн гэрчилгээг үндэслэн бүртгэнэ.

**26 дугаар зүйл.Татвар төлөгчийг бүртгэх нийтлэг журам**

26.1.Энэ хуулийн 25.1-д заасан татвар төлөх үүрэг бүхий этгээдийг татварын алба татвар төлөгчөөр татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

26.2.Татварын алба бүртгэх эрх бүхий байгууллагын мэдээллийг үндэслэн шинээр байгуулагдсан, бүртгэгдсэн этгээдийг бүртгэн, татвар төлөгчийн дугаар, гэрчилгээ олгож хувийн хэргийг үүсгэнэ.

26.3.Татвар ногдох зүйлийг өмчлөгч, эзэмшигч, ашиглагч, эсхүл татвар ногдох зүйл бүхий этгээд, татвар төлөгчид олгосон болон өмчлөл, эзэмшил, ашиглалтад шилжүүлсэн тусгай зөвшөөрлийн мэдээллийг бүртгэх эрх бүхий байгууллагын мэдээлэл, эсхүл татвар төлөгчийн хүсэлтийг үндэслэн татварын алба тухай бүр татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

26.4.Татвар төлөгч нь татвар төлөгчийн бүртгэлийн мэдээлэл, түүний өөрчлөлт, энэ хуулийн 26.2, 26.3-т заасан мэдээллийг 7 хоногийн дотор татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд өөрөө бүртгүүлэх, эсхүл татварын албанаас мэдэгдсэнээр мөн хугацаанд баталгаажуулах үүргийг хүлээж, татвар төлөгчийн гэрчилгээнд тэмдэглүүлнэ.

26.5.Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд байгаа татвар төлөгчийн мэдээлэл тухайн татвар төлөгчид нээлттэй байх ба мэдээллийн үнэн зөвийг татвар төлөгч хариуцна.

26.6.Энэ хуулийн 26.3, 26.4-т заасан мэдээллийг татварын алба бусад хөндлөнгийн мэдээлэлд үндэслэн өөрчлөх шаардлагатай гэж үзвэл татвар төлөгчид мэдэгдэх бөгөөд татвар төлөгч энэ хуулийн 26.4-т заасан хугацаанд баталгаажуулна. Татвар төлөгч баталгаажуулаагүй тохиолдолд эрсдэлтэй гэж үзэн хувийн хэрэгт бүртгэх бөгөөд хяналт шалгалт хийх үндэслэл болно.

26.7.Татвар төлөгчийн бүртгэлийн журмыг татварын болон улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга хамтран батална.

26.8.Монгол Улсын хуулийн этгээд нь гадаад улсад байгуулсан салбар, төлөөлөгчийн болон төлөөний газрыг татварын албанд бүртгүүлэх үүрэгтэй.

26.9.Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгч Монгол Улсын иргэн нь гадаад улсад байгуулсан хуулийн этгээдийн нэр, хаягийг тухайн татварын жилд багтаан татварын албанд мэдэгдэх үүрэгтэй.

26.10.Ашигт малтмал, газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, газар эзэмших, ашиглах эрх эзэмшигч этгээд өөрийн эцсийн эзэмшигчийн талаарх мэдээллийг татварын албанд бүртгүүлнэ.

26.11.Ашигт малтмал, газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, газар эзэмших, ашиглах эрх эзэмшигч өөрийн эцсийн эзэмшигчийн өөрчлөлтийн тухай мэдээллийг шийдвэр гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор харьяалах татварын албанд бүртгүүлнэ.

26.12.Энэ хуулийн 26.11-д заасныг үл харгалзан, өөрийн болон эцсийн эзэмшигчийн хувьцаа гадаад, дотоодын хөрөнгийн биржид нээлттэй арилжаалагддаг бол ашигт малтмал, газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, газар эзэмших, ашиглах эрх эзэмшигч өөрийн эцсийн эзэмшигчийн өөрчлөлтийн тухай мэдээллийг татварын албанаас баталсан маягтын дагуу тухайн жилийн 07 дугаар сарын 20-ны өдөрт багтаан, жилийн эцсийн мэдээллийг дараагийн татварын жилийн 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор харьяалах татварын албанд бүртгүүлнэ.

**27 дугаар зүйл.Харилцан хамааралтай этгээд**

27.1.Нэг этгээд нөгөө этгээдийн, эсхүл уг этгээдүүд нь хоёр болон түүнээс дээш хуулийн этгээдийн хөрөнгө, хяналт, удирдлагын үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар оролцох замаар хоорондоо хийх ажил гүйлгээний нөхцөл, эдийн засгийн үр дүнд нөлөөлөх боломжтой доор дурдсан этгээдийг хоорондоо харилцан хамааралтай этгээд гэж үзнэ:

27.1.1.татвар төлөгчийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, хүүхэд, өвөг эцэг, эмэг эх, ач, зээ болон эхнэр /нөхөр/, хамтран амьдрагч, тэдгээрийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү;

27.1.2.энэ хуулийн 6.1.8-д заасан группт хамаарах этгээд;

27.1.3.хувьцаа, хувь оролцоо, эсхүл саналын эрхийн 20 ба түүнээс доошгүй хувийг шууд болон шууд бусаар эзэмшдэг этгээд;

27.1.4.ашиг, эсхүл татан буугдсаны дараах үлдэгдэл хөрөнгөөс 20 ба түүнээс доошгүй хувийг шууд болон шууд бусаар хүртэх эрхтэй этгээд;

27.1.5.хувьцаа, хувь оролцоо, эсхүл саналын эрхийн 20 ба түүнээс доошгүй хувийг гуравдагч этгээд шууд болон шууд бусаар эзэмшдэг аж ахуйн нэгж;

27.1.6.ашиг, эсхүл татан буугдсаны дараах үлдэгдэл хөрөнгөөс 20 ба түүнээс доошгүй хувийг гуравдагч этгээд шууд болон шууд бусаар хүртэх эрхтэй аж ахуйн нэгж;

27.1.7.энэ хуулийн 27.1.1-д заасан этгээдийн шууд болон шууд бус эзэмшил дэх энэ хуулийн 27.1.3, 27.1.4, 27.1.5, 27.1.6-д заасан харилцаа бүхий этгээд;

27.1.8.энэ хуулийн 27.1-д заасан этгээд, тэдгээрийг томилох эрхтэй этгээд, тэдгээрийн эрх, үүргийг шилжүүлэн хүлээж авсан этгээд, эсхүл тэдгээрийг төлөөлөхөөр сонгогдсон этгээд;

27.1.9.энэ хуулийн 27.1-д заасан этгээд болон харилцан хамаарал бүхий аж ахуйн нэгжийн салбар, төлөөний газар зэрэг;

27.1.10.Монгол Улсад оршин суугч татвар төлөгчийн татвар ногдуулах орлогыг бууруулах, алдагдлыг өсгөх үндсэн зорилгоор харилцаа тогтоосон этгээд;

27.1.11.энэ хуулийн 27.1-д заасантай адилтгах бусад этгээд.

27.2.Хувь нийлүүлэгчид шууд болон шууд бусаар аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны шийдвэр гаргахад нэгдмэл байр суурьтай оролцохоор хэлцэл байгуулж, уг хэлцлийн үндсэн дээр шийдвэр гаргадаг бол тухайн хувь нийлүүлэгч этгээдийг энэ хуулийн 27.1.3, 27.1.4, 27.1.5, 27.1.6-д заасан хувь, оролцооны хувьд нэг этгээд гэж үзнэ.

27.3.Шууд бус оролцоог тодорхойлохдоо шууд оролцооны хувиудын үржвэрээр тодорхойлно. Шууд оролцоо нь 50 хувиас дээш байвал 100 хувийн оролцоотой гэж үзнэ.

**28 дугаар зүйл.Татвар ногдуулалт, төлөлт**

28.1.Татвар төлөгч холбогдох татварын хуулиар төлбөл зохих татварын ногдлоо өөрөө тодорхойлж, хуулиар тогтоосон хугацаанд төсөвт төлнө.

28.2.Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.

28.3.Татвар төлөгч анхан шатны баримт бүрдүүлээгүй болон нягтлан бодох бүртгэл хөтлөөгүй, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн системд холбогдоогүйгээс орлого, зарлагыг нь тодорхойлох боломжгүй, эсхүл татвар ногдуулах орлого, татвар ногдох орлогоос хасагдах зардлыг тодорхойлохдоо бодит бус үнэ хэрэглэсэн тохиолдолд татварын алба татварын ногдлыг жишиг үнийн, эсхүл үнэ шилжилтийн тохируулга хийх аргаар тодорхойлж, холбогдох татварыг ногдуулна.

28.4.Татвар төлөгч татвар ногдох эд хөрөнгө, эрхийг бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтад шилжүүлсэн болон шилжүүлж авсан тухай баримтыг шилжүүлсэн тухай бүрд татварын албанд гаргаж өгөх үүрэгтэй.

28.5.Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй.

28.6.Татвар ногдуулах, суутган авах, төсөвт төлөх үүргийг хуулиар хүлээсэн этгээдэд үүргээ гүйцэтгэснийх нь төлөө хөлс төлөхгүй.

28.7.Суутган төлөгч нь татварын хууль тогтоомжийн дагуу тухайн төрлийн татвар төлөх үүрэг бүхий этгээдээс албан татварыг ногдуулан суутгана.

28.8.Татварыг Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр бүртгэж, ногдуулж, тайлагнаж, төлнө.

28.9.Татвар ногдуулалт, төлөлттэй холбогдсон харилцааг тухайн төрлийн татварын хуулиар нарийвчлан зохицуулна.

28.10.Татвар төлөгч нь хууль тогтоомж болон татварын албанаас баталсан заавар, аргачлал, маягт, дүрэм, журмыг дагаж мөрдөх үүрэгтэй.

**29 дүгээр зүйл.Татварын тайлан үйлдэх, тушаах**

29.1.Татвар төлөгч татварын тайланг хуулиар тогтоосон хугацаанд, батлагдсан загвар, зааврын дагуу цахим, эсхүл цаасан хэлбэрээр үйлдэж, харьяа татварын албанд тушаана. Татвар төлөгч дараах үүргийг хүлээнэ:

29.1.1.анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх;

29.1.2.татвар ногдуулах, төлөхтэй холбогдсон тооцоо, мэдээ гаргаж, тогтоосон хугацаанд татварын албанд хүргүүлэх;

29.1.3.суутгасан татварыг хуульд заасан хугацаанд харьяа татварын албанд үнэн зөв тайлагнах;

29.1.4.татварын тайлантай холбоотой баримт, мэдээллийг гадаад хэл дээр үйлдсэн бол монгол хэл дээр орчуулах бөгөөд ийнхүү орчуулахтай холбогдсон зардлыг татвар төлөгч өөрөө хариуцах;

29.1.5.татвар төлөгч болон түүний баримтыг бүрдүүлэх, бүртгэл хөтлөх үүрэг хүлээсэн этгээд нь уг баримт, бүртгэлийг татвар төлөх хөөн хэлэлцэх хугацаа дуустал Монгол Улсын нутаг дэвсгэрт хадгалах;

29.1.6.татварын тайланд тусгах, бүртгэх төлбөр тооцоо гадаад валютаар хийгдсэн тохиолдолд тухайн гүйлгээ хийсэн өдрийн Монголбанкны албан ханшаар тооцож төгрөгөөр илэрхийлэх.

29.2.Татварын тайлан тушаах, татвар төлөх хугацааг тухайн төрлийн татварын хуулиар тогтоох бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол татвар төлөх, тайлагнах хугацаа адил байна.

29.3.Татвар төлөх, тайлагнах эцсийн хугацаа долоо хоног бүрийн Бямба, Ням гараг, нийтээр тэмдэглэх баярын өдөртэй давхацсан тохиолдолд түүний өмнөх ажлын өдөр нь татвар төлөх, тайлагнах эцсийн өдөр байна.

29.4.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга шаардлагатай тохиолдолд тайлан хүлээн авах хугацааг 7 хоног хүртэлх хугацаагаар сунгаж болох бөгөөд энэ тухайгаа олон нийтэд урьдчилан мэдэгдэнэ.

29.5.Хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдах татвар төлөгч татварын тайлан тушаах үүргээс чөлөөлөгдөхгүй бөгөөд уг татварын тайлан нь түүнийг тухайн төрлийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах үндсэн баримт болно.

29.6.Татварын тайланд эрх бүхий албан тушаалтан, татвар төлөгч хувь хүн, эсхүл түүний хууль ёсны болон итгэмжлэгдсэн төлөөлөгч, уг тайланг гаргасан буюу гаргахад оролцсон этгээд гарын үсэг зурна.

29.7.Цахим хэлбэрээр татварын албанд илгээсэн татварын тайланг цахим гарын үсгээр баталгаажуулсан байх бөгөөд баталгаажуулаагүй тохиолдолд цаасан хэлбэрээр тушаана.

29.8.Цахим баримтыг тодорхойлох, түүнд тавих шаардлагыг тогтоох, цахим баримтыг хадгалах журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

**30 дугаар зүйл.Татварын тайлан хүлээн авах, тайлангийн боловсруулалт хийх**

30.1.Татварын алба татвар төлөгч татварын тайлангаа хуулиар тогтоосон хугацаанд тушааж, татвараа үнэн зөв ногдуулж, төлж байгаа эсэхэд хяналт тавина.

30.2.Татварын алба тайланг хүлээн авахдаа татвар төлөгч татварын ногдуулалт, төлөлтийг үнэн зөв тодорхойлсон эсэхийг дараах байдлаар хянан, боловсруулалт хийнэ:

30.2.1.тайланг батлагдсан маягт, зааврын дагуу засваргүй үйлдэж, татвар төлөгч болон холбогдох бусад этгээд гарын үсэг болон тамга, тэмдэг дарж баталгаажуулсан, эсхүл цахимаар холбогдох журмын дагуу илгээсэн эсэх;

30.2.2.тайланг хуулиар тогтоосон хугацаанд тушаасан эсэх;

30.2.3.тайлангийн хавсралт баримт мэдээлэл бүрэн эсэх;

30.2.4.хуулийн этгээдийн хувьд нягтлан бодох бүртгэл, хувь хүний хувьд орлого, татварын бүртгэлийн дэвтэр болон холбогдох бусад баримтыг үндэслэн тайлангаа гаргасан эсэх;

30.2.5.нягтлан бодох бүртгэл болон татварын тайлангийн үзүүлэлтүүд хоорондоо тохирч байгаа эсэх;

30.2.6.татварын тайлан хоорондын үзүүлэлтийн дүн болон тайланд хавсаргасан баримт, мэдээллийн дүн тайлагнасан дүнтэй тохирч байгаа эсэх, тооцооны алдаа байгаа эсэх;

30.2.7.тайланд тусгасан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хууль тогтоомжид нийцүүлэн тооцож, тодорхойлсон эсэх;

30.2.8.тайланд тусгасан татварын тооцооны үлдэгдэл болон тухайн тайлангийн хугацаанд төлсөн татварын дүн татварын албаны бүртгэлтэй тохирч байгаа эсэх;

30.2.9.тухайн тайлангийн хугацаанд хамаарах татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн хөндлөнгийн мэдээлэл татварын тайлангийн мэдээлэлтэй тохирч байгаа эсэх.

30.3.Татварын алба энэ хуулийн 30.2-т заасны дагуу тайланг хянах бөгөөд мэдээлэл зөрүүгүй тохиолдолд тайланг хүлээж авах бөгөөд шаардлагатай тохиолдолд анхан шатны болон холбогдох бусад баримтыг шаардаж болно.

30.4.Татварын алба энэ хуулийн 30.2-т заасны дагуу тайланг хянаж мэдээллийн зөрүү илэрвэл илрүүлснээс хойш ажлын 3 өдрийн дотор мэдээллийн зөрүүг залруулах шаардлагыг татвар төлөгчид хүргүүлнэ.

30.5.Татвар төлөгч энэ хуулийн 30.4-т заасан шаардлагыг хүлээн авснаас хойш ажлын 3 өдөрт багтаан шаардлагад заасан зөрүүг арилгаж, залруулсан тайланг тушаах үүрэгтэй бөгөөд татварын алба тайланг хүлээн авна.

30.6.Татвар төлөгч шаардлагыг үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай тайлбараа цахимаар, эсхүл бичгээр гаргаж, энэ хуулийн 30.5-д заасан хугацаанд багтаан татварын албанд ирүүлнэ.

30.7.Энэ хуулийн 30.6-д заасны дагуу татвар төлөгчөөс ирүүлсэн тайлбарыг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан тайланг хүлээн авна.

30.8.Энэ хуулийн 30.6-д заасан тайлбарыг хугацаанд нь ирүүлээгүй, эсхүл ирүүлсэн тайлбар нь үндэслэлгүй гэж үзвэл татварын алба холбогдох мэдээллийг татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэх бөгөөд энэ нь тайлангийн хугацаанд хамаарах татвар ногдуулалт, төлөлттэй холбоотой асуудалд татварын хяналт шалгалт хийж тайлангийн ногдлыг тодорхойлох үндэслэл болно.

30.9.Тайлангийн боловсруулалт хийх хугацаанд тайланг хүлээн аваагүй нь алданги тооцохгүй байх үндэслэл болохгүй.

30.10.Татварын тайлан үйлдэх, тушаах, хүлээн авах, боловсруулах, тайланд залруулга хийх журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

30.11.Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам, тайлангийн маягт, тайлан нөхөх заавар, зөрүүг зохицуулах, нягтлан бодох бүртгэлд бүртгэх аргачлалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

**31 дүгээр зүйл.Татварын тайланд залруулга хийх**

31.1.Татвар төлөгч татварын тайланг дараагийн татварын жилд багтаан залруулж болно.

31.2.Хэрэв татвар төлөгч татварын тайлангийн ногдлыг бууруулах залруулга хийх бол уг залруулгыг нотлох анхан шатны болон холбогдох бичиг баримтын хамт залруулсан тайланг ирүүлнэ.

31.3.Татварын алба залруулсан тайланг хүлээн авахдаа энэ хуулийн 30 дугаар зүйлд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

31.4.Татварын хяналт шалгалт хийхээр татвар төлөгчид мэдэгдсэнээс хойш энэ хуулийн 31.1-д заасан тайлангийн залруулгыг хийхгүй.

31.5.Татвар төлөгчийн хүсэлтээр тайланд залруулга хийсэн нь хуульд заасан хугацаанд төлөөгүй татварын алдангиас чөлөөлөх үндэслэл болохгүй.

31.6.Тайлангийн ногдлыг бууруулах залруулга хийсэн нь түүнийг хийхээс өмнө тооцсон алдангийн хэмжээг өөрчлөх үндэслэл болохгүй.

## ДОЛДУГААР БҮЛЭГ
## ТАТВАРЫН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

**32 дугаар зүйл.Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан**

32.1.Татварын алба татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сантай байна. Татварын алба чиг үүргээ хэрэгжүүлэх, мэдээлэл солилцох зорилгоор мэдээллийн систем, технологийг ашиглах бөгөөд тэдгээрийн нууцлал, найдвартай байдлыг бүрэн хангаж ажиллана.

32.2.Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан дараах зориулалттай байна:

32.2.1.татвар төлөгч болон татварын тайлан, ногдуулалт, төлөлт, татварын өрийг бүртгэх, хяналт тавих;

32.2.2.татварын хяналт шалгалтыг эрсдэлд үндэслэх;

32.2.3.татварын хууль тогтоомжийг улсын хэмжээнд нэг мөр дагаж мөрдүүлэх;

32.2.4.татварын албаны үйл ажиллагааны ил тод байдлыг хангах;

32.2.5.татвар төлөгчдөд үзүүлэх бүх төрлийн үйлчилгээг шуурхай зохион байгуулах;

32.2.6.татварын албаны үйл ажиллагаанд болон татвар төлөгчид учирч болох эрсдэлийг тодорхойлох;

32.2.7.татварын удирдлага, түүний дотор мэдээллийн удирдлагын зардлыг багасгах, хөнгөн шуурхай, үр ашигтай, ил тод тайлагналыг хангах.

32.3.Татварын алба холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төрийн бусад байгууллагын болон гадаад, дотоод мэдээллийн эх үүсвэрийг ашиглаж болно.

32.4.Татварын алба татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг бүртгэх, баяжуулах, түүний аюулгүй байдал, мэдээлэл ашиглалтад хяналт тавьж ажиллана.

**33 дугаар зүйл.Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг хөтлөх**

33.1.Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд дараах мэдээлэл хамаарна:

33.1.1.татвар төлөгчийн бүртгэл, түүний өөрчлөлтийн мэдээлэл;

33.1.2.татвар, алданги, торгуулийн бүртгэл;

33.1.3.татварын тайлан, мэдээ, цахим төлбөрийн баримтын системийн мэдээлэл;

33.1.4.татварын улсын байцаагчийн үйлдсэн баримт бичиг, түүний биелэлтийн мэдээлэл;

33.1.5.татварын Маргаан таслах зөвлөлийн шийдвэрийн мэдээлэл;

33.1.6.татварын зөрчил, маргааныг хянаж шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн мэдээлэл;

33.1.7.холбогдох байгууллагаас ирүүлсэн мэдээлэл;

33.1.8.хууль, журмын дагуу төрийн мэдээллийн нэгдсэн сангаас авсан мэдээлэл;

33.1.9.хөндлөнгийн мэдээлэл;

33.1.10.татварын хууль тогтоомж, эрх зүйн бусад баримт бичиг;

33.1.11.татварын албаны хүний нөөц, төсөв, хөрөнгийн мэдээлэл;

33.1.12.татварын өр, өр барагдуулалт, хураалтын үйл ажиллагааны мэдээлэл.

33.2.Татварын алба нь энэ хуулийн 33.1.2-т заасан бүртгэлийг хууль тогтоомжид нийцүүлэн хөтлөх бөгөөд татвар төлөгч бүрийн төлбөл зохих татварын ногдол, хөнгөлөлт, чөлөөлөлт, алданги, торгууль, тэдгээрийн төлөлт, өрийг анхан шатны баримтад үндэслэн татварын бүртгэлд бүрэн тусгана.

33.3.Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, сангийн мэдээллийг хадгалах, хамгаалах, ашиглах, ашиглалтад хяналт тавих журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

**34 дүгээр зүйл.Бусад байгууллагаас мэдээлэл гаргуулах, хамтран ажиллах**

34.1.Татварын алба татвар төлөгчийн талаар хөндлөнгийн мэдээлэл цуглуулж, хөндлөнгийн мэдээллийн санг бүрдүүлж, мэдээллийг татварын хяналт шалгалт, татвар ногдуулалт, хураалт болон татвар төлөгчийн эрсдэл, бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглах бөгөөд энэ хуулийн 34.3, 34.4, 34.5, 34.6, 34.7, 34.8, 34.9, 34.10, 34.11, 34.12, 34.13, 34.14, 34.15, 34.16, 34.17, 34.18, 34.19, 34.20, 34.21, 34.22, 34.23, 34.24, 34.25, 34.26, 34.27-д заасан байгууллага, албан тушаалтан татварын албанд шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх, татварын зорилгоор хамтран ажиллах үүрэг хүлээнэ.

34.2.Байгууллага, албан тушаалтан татварын албаны хөндлөнгийн мэдээллийн санг бүрдүүлэх зорилгоор энэ хуулийн 34.3, 34.4, 34.5, 34.6, 34.7, 34.8, 34.9, 34.10, 34.11, 34.12, 34.13, 34.14, 34.15, 34.16, 34.17, 34.18, 34.19, 34.20, 34.21, 34.22, 34.23, 34.24, 34.25, 34.26, 34.27-д заасан мэдээллийг цахим хэлбэрээр хүргүүлэх бөгөөд хугацааг тусгайлан өөрөөр заагаагүй бол сар бүрийн 10-ны өдрийн дотор татварын албанд тогтмол мэдээлэх үүрэг хүлээнэ.

34.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага татвар төлөгчид хамааралтай санхүүгийн тайлангийн мэдээлэл, гадаадын санхүүжилттэй төсөл арга хэмжээ, төрийн сангийн зарцуулалтын мэдээлэл, тусгай зөвшөөрлийн мэдээллийг тухай бүр татварын албанд хүргүүлнэ.

34.4.Арилжааны банк болон банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо болон бусад санхүүгийн эрх бүхий байгууллага дараах мэдээллийг гаргаж, татварын албанд хүргүүлнэ:

34.4.1.татвар төлөгчийн дансны мэдээлэл болон уг данстай холбоотой эзэмшигчийн талаарх мэдээллийг татварын албаны шаардсанаар тухай бүр;

34.4.2.татвар төлөгч нь банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо болон бусад санхүүгийн эрх бүхий байгууллагад шинээр төлбөр тооцоо, хадгаламжийн болон бусад төрлийн данс нээсэн, эсхүл өмнө нээсэн дансанд өөрчлөлт, хөдөлгөөн хийлгэсэн бол энэ тухай мэдээллийг тухай бүр;

34.4.3.татвар төлөгчийн дансны гүйлгээний мэдээллийг татварын албанаас албан бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн.

34.5.Цагдаагийн байгууллага дараах мэдээллийг гаргаж, татварын албанд хүргүүлнэ:

34.5.1.Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг татвар төлөгчөөр бүртгэх, хаягийг нь тодруулахтай холбогдсон өөрт байгаа хувь хүний нууцад үл хамаарах мэдээ, судалгааг татварын албаны хүсэлтээр;

34.5.2.галт зэвсэг эзэмшигчийн болон галт зэвсгийн шилжилт хөдөлгөөн, хасалтын талаарх мэдээлэл, галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг худалдан авах, улсын хилээр нэвтрүүлэх, зөвшөөрөлтэй хувь хүн, хуулийн этгээдийн мэдээллийг;

34.5.3.гэрээт харуул хамгаалалтын тусгай зөвшөөрлийн мэдээллийг;

34.5.4.жолооч бэлтгэх авто сургууль, курсын болон жолоодох эрхийн бүртгэлийн мэдээллийг;

34.5.5.татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг, шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг.

34.6.Цагдаагийн байгууллага татвар төлөхөөс зугтаж, оргон зайлсан татвар төлөгчийн хаягийг тогтоох, эрэн сурвалжлахад татварын албатай хамтарч ажиллана.

34.7.Гаалийн байгууллага нь татвар төлөгчийн дугаарыг гаалийн мэдүүлэгт тусгуулж, тухайн татвар төлөгчийн экспорт, импортын үйл ажиллагаатай холбогдох мэдээллийг татварын албанд тухай бүр хүргүүлнэ.

34.8.Улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах мэдээллийг гаргаж, татварын албанд хүргүүлнэ:

34.8.1.Монгол Улсын иргэний улсын бүртгэлийн дэлгэрэнгүй мэдээлэл;

34.8.2.Монгол Улсад бүртгэлтэй эд хөрөнгийн эрхийн улсын дэлгэрэнгүй бүртгэл, өөрчлөлттэй холбоотой мэдээлэл;

34.8.3.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дэлгэрэнгүй мэдээлэл, өөрчлөлттэй холбоотой мэдээлэл.

34.9.Оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар зохиогч болон патент, гэрчилгээ эзэмшигчийн дэлгэрэнгүй мэдээллийг тухай бүр гаргаж, татварын албанд хүргүүлнэ.

34.10.Гадаадын иргэн, харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах мэдээллийг тухай бүр гаргаж, татварын албанд хүргүүлнэ:

34.10.1.гадаадын иргэн, харьяалалгүй хүний оршин суугаа хаяг, Монгол Улсын хилээр орсон, гарсан хугацааны болон түүнийг урьсан этгээдийн мэдээлэл, мөн хөрөнгийн баталгааны мэдээллийг;

34.10.2.гадаадын хөрөнгө оруулалттай төрийн бус байгууллагын бүртгэл, өөрчлөлтийн талаарх мэдээллийг.

34.11.Төрийн захиргааны төв, орон нутгийн бусад байгууллага, тэдгээрийн удирдах албан тушаалтан дараах үүрэг хүлээнэ:

34.11.1.татварын нийгэм, эдийн засгийн ач холбогдлыг тайлбарлан таниулж, татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх;

34.11.2.хяналт шалгалт хариуцсан төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан нь албан үүргээ биелүүлэх явцад татварын хууль тогтоомжийг зөрчсөн тухай мэдээлэл олж мэдсэн, илрүүлсэн бол уг мэдээллийг татварын албанд тухай бүр хүргүүлэх;

34.11.3.тусгай зөвшөөрлийн бүртгэл, өөрчлөлтийн мэдээлэл, нөөц хөрөнгө болон сангуудаас олгосон санхүүжилтийн мэдээллийг татварын албанд тухай бүр хүргүүлэх;

34.11.4.татварын хяналт шалгалтын үйл ажиллагаанд туслалцаа үзүүлж, шаардлагатай бусад мэдээллээр татварын албыг хангаж, хамтран ажиллах.

34.12.Хөрөнгийн бирж дараах мэдээллийг тухай бүр гаргаж, татварын албанд хүргүүлнэ:

34.12.1.хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчийн тархалтын тухай мэдээлэл;

34.12.2.хувьцаат компанийн хувьцааны борлуулалтын талаарх мэдээлэл.

34.13.Санхүүгийн зохицуулах хороо дараах мэдээллийг гаргаж, татварын албанд хүргүүлнэ:

34.13.1.тус хорооноос олгож байгаа тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн бүртгэл, өөрчлөлттэй холбоотой мэдээллийг тухай бүр;

34.13.2.үнэт цаасны арилжааны мэдээллийг тухай бүр;

34.13.3.тус хороонд бүртгэлтэй санхүүгийн зах зээлд ажиллах эрх бүхий иргэний бүртгэл, дэлгэрэнгүй мэдээлэл.

34.14.Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дараах мэдээллийг тухай бүр гаргаж, татварын албанд хүргүүлнэ:

34.14.1.үнэт цаасны бүртгэл, өөрчлөлтийн болон төлбөр тооцооны мэдээлэл;

34.14.2.төвлөрсөн хадгаламжийн дансны өөрчлөлтийн мэдээлэл;

34.14.3.хувьцаат компаниудын ногдол ашгийн олголтын мэдээлэл.

34.15.Ашигт малтмал, газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах мэдээллийг тухай бүр гаргаж, татварын албанд хүргүүлнэ:

34.15.1.ашигт малтмал болон газрын тосны чиглэлээр холбогдох мэдээлэл;

34.15.2.тусгай зөвшөөрөл эзэмшигч, уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгчтэй холбоотой болон стратегийн ач холбогдол бүхий ордын мэдээлэл.

34.16.Улсын хил хамгаалах байгууллага татварын албаны хүсэлтийн дагуу Монгол Улсын хилээр нэвтэрсэн иргэний талаарх мэдээллийг гаргаж, хүргүүлнэ.

34.17.Авто тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Монгол Улсын автотээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч, түүний өөрчлөлтийн талаарх мэдээллийг гаргаж, татварын албанд хүргүүлнэ.

34.18.Автотээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага татварын албаны автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр хураах ажилд дэмжлэг үзүүлж, хамтарсан хяналт шалгалтыг зохион байгуулна.

34.19.Монголбанк дараах мэдээллийг гаргаж, татварын албанд хүргүүлнэ:

34.19.1.алт тушаалтын мэдээлэл, зээлийн мэдээллийн сангийн мэдээллийг тухай бүр;

34.19.2.мөнгө угаах гэмт хэрэг, түүнтэй холбогдох татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг, татварын хууль тогтоомж зөрчихтэй холбоотойгоор Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-д заасан этгээдийн 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг татварын албатай байгуулах мэдээлэл харилцан солилцох, хамтран ажиллах гэрээний дагуу.

34.20.Сорьцын улсын хяналтын алба алт тушаалт болон бусад шаардлагатай мэдээллийг тухай бүр гаргаж хүргүүлнэ.

34.21.Нотариат болон гэрээ, хэлцлийг бүртгэх чиг үүрэг бүхий бусад этгээд татвар ногдох зүйлтэй холбоотой гэрээ, хэлцэл, гүйлгээ хийгдсэн талаарх мэдээллийг гаргаж татварын албанд хүргүүлнэ.

34.22.Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага газрын төлбөр төлөгчийн, газраас авах үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгчийн бүртгэл, газрын төлбөрийн ногдуулалт, төлөлтийн болон газраас авах үл хөдлөх эд хөрөнгийн татвар ногдуулалттай холбоотой мэдээллийг тухай бүр гаргаж, татварын албатай харилцан мэдээлэл солилцоно.

34.23.Эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөгч хувь хүн, хуулийн этгээдийн дэлгэрэнгүй мэдээллийг татварын албанд тухай бүр цахим хэлбэрээр хүргүүлнэ.

34.24.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нийгмийн даатгалын шимтгэл төлөгч хувь хүн, хуулийн этгээдийн дэлгэрэнгүй мэдээллийг татварын албанд тухай бүр цахим хэлбэрээр хүргүүлнэ.

34.25.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах мэдээллийг тухай бүр гаргаж, татварын албанд хүргүүлнэ:

34.25.1.хуульд заасан чиг үүргийн хүрээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэл, худалдан авах ажиллагаанд оролцсон хувь хүн, хуулийн этгээдийн мэдээлэл, төсөвт өртөг, гэрээ байгуулсан хувь хүн, хуулийн этгээдийн дэлгэрэнгүй мэдээлэл;

34.25.2.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл.

34.26.Барилга хот байгуулалт, газар, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тусгай зөвшөөрөл эзэмшигч хувь хүн, хуулийн этгээдийн мэдээллийг тухай бүр гаргаж, татварын албанд хүргүүлнэ.

34.27.Төрийн байгууллага, төр, орон нутгийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд шаардлагатай мэдээллийг татварын албаны шаардсан даруйд гаргаж, хүргүүлнэ.

## НАЙМДУГААР БҮЛЭГ
## ТАТВАРЫН АЛБАНЫ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

**35 дугаар зүйл.Татварын албаны эрсдэлийн удирдлага**

35.1.Татварын алба нь татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад татварын харилцаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, удирдах, хянах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

35.2.Татварын алба нь эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална:

35.2.1.Монгол Улсын хүчин төгөлдөр хууль тогтоомжийн хүрээнд татварын алба өмнөө тавьсан зорилгодоо хүрэх, түүний хэрэгжилтийг хангахад хамгийн бага эрсдэлтэй байхад чиглэх;

35.2.2.эрсдэлийн удирдлага нь нэгдмэл, тасралтгүй байх;

35.2.3.эрсдэлийн удирдлага нь байгууллагын төлөвлөлт, шийдвэр гаргалтын нэг хэсэг болох;

35.2.4.эрсдэлийн удирдлага нь байгууллагын нөөцийн үр ашигтай зөв хуваарилалт, хэмнэлттэй байдлыг бий болгоход чиглэх.

35.3.Татварын албаны эрсдэлийн удирдлага гэж татварын харилцаанд оролцогчийн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх үйлдэл, эс үйлдэл, нөхцөл байдлыг урьдчилан тодорхойлон шинжлэх, шалтгаан нөхцөлийг нь тогтоох, үнэлэх, улмаар шийдвэрлэх оновчтой арга замыг сонгох, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулахад чиглэсэн тасралтгүй, цогц үйл ажиллагааг хэлнэ.

35.4.Татварын алба нь эрсдэлийн удирдлагын арга хэмжээг дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

35.4.1.нөхцөл байдлыг тодорхойлох;

35.4.2.эрсдэлийг тодорхойлж, бүртгэх;

35.4.3.эрсдэлийг үнэлэх, шинжлэх;

35.4.4.эрсдэлийг удирдах ба хяналтын арга хэмжээг тодорхойлох;

35.4.5.эрсдэлийн удирдлагын үйл явцыг хянах.

35.5.Татварын албаны эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь татварын хууль тогтоомжийн хүрээнд татварын албаны удирдлага, мэргэжил арга зүйн үйл ажиллагаанд ашиглагдах тооцооллын цахим системд тулгуурласан үйл ажиллагааны иж бүрдэл юм.

35.6.Энэ хуулийн 35.4.3-т заасан эрсдэлийн үнэлгээ, шинжилгээг татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэлд үндэслэн хийнэ.

35.7.Эрсдэл тооцох шалгуур үзүүлэлтийг шинэчлэх, өөрчлөх, хүчингүй болгох талаар хэлэлцэх, татварын албаны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг удирдах, бууруулах, хэрэгжилтийг нь хянах, эрсдэлийн шинжилгээний үр дүнтэй танилцах ажлыг хэрэгжүүлэх, энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрмийг хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлэх чиг үүрэг бүхий Эрсдэлийн удирдлагын хороо ажиллана.

35.8.Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүдийг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны даргын тушаалаар томилж, чөлөөлөх бөгөөд уг хороонд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөллийг оролцуулна.

35.9.Эрсдэлийн үнэлгээ, шинжилгээнд ашиглагдах шалгуур үзүүлэлтийг татварын хууль тогтоомжид нийцүүлэн тогтоох бөгөөд Эрсдэлийн удирдлагын хороогоор хэлэлцүүлсний үндсэн дээр, татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

35.10.Энэ хуулийн 35.4.3-т заасан эрсдэлийн үнэлгээ, шинжилгээний үр дүнг үндэслэн татварын хяналт, шалгалтад хамруулах татвар төлөгчийг сонгоно.

35.11.Татварын албаны эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, хорооны журмыг эрсдэлийн удирдлагын стандартад нийцүүлэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

**36 дугаар зүйл.Татварын ногдлыг тодорхойлох боломжгүй байх**

36.1.Татвар төлөгчийн татварын ногдлыг үнэн зөв тодорхойлох боломжгүй тохиолдолд татварын алба татвар төлөгчийн татварын ногдлыг жишиг үнийн аргаар тооцоолж, нөхөн ногдуулалтын акт үйлдэнэ.

36.2.Татварын алба дараах үндэслэлээр татварын ногдлыг өөрт байгаа мэдээлэлд үндэслэн жишиг үнийн аргаар тодорхойлно:

36.2.1.татвар төлөгч хуульд заасны дагуу тайлан, бүртгэл хөтлөөгүй;

36.2.2.татвар төлөгч тайлан, бүртгэлийг дутуу буюу буруу хөтөлсөн;

36.2.3.татвар төлөгчийн тайлан, бүртгэл алдагдсан буюу устсан;

36.2.4.татвар төлөгчийн татварын тайлангийн үзүүлэлт нь санхүүгийн тайлангийн үзүүлэлттэй харьцуулахад татварын ногдол дутуу тодорхойлогдсон нь илт байгаа;

36.2.5.татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд холбогдоогүй.

36.3.Татварын ногдлыг жишиг үнийн аргаар тодорхойлох журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

**37 дугаар зүйл.Үнэ шилжилтийн ерөнхий зарчим**

37.1.Хяналтад байгаа ажил гүйлгээний нөхцөлийг бие даасан ажил гүйлгээний нөхцөлтэй харьцуулахад орлого, ашиг болон татварын суурьд нөлөөлөх үзүүлэлтүүд нь ялгаатай бөгөөд үүнээс хамаарч татварын суурь буурсан бол уг буурсан дүнгийн зөрүүгээр татварын суурийг нэмэгдүүлж, холбогдох татварыг нөхөн ногдуулна.

37.2.Хяналтад байгаа ажил гүйлгээнд хамаарах татварын суурь нь түүнтэй харьцуулагдах бие даасан ажил гүйлгээнд хамаарах татварын сууриас багагүй байна.

37.3.Энэ хуулийн 37.2-т зааснаар хяналтад байгаа ажил гүйлгээний татварын суурийг тодорхойлохдоо уг ажил гүйлгээтэй харьцуулагдаж болох бие даасан ажил гүйлгээний нөхцөлтэй нийцэж байгаа эсэхийг дараах байдлаар тогтооно:

37.3.1.ажил гүйлгээний үнэ, нөхцөл;

37.3.2.ажил гүйлгээ хийх бодит шаардлага байсан эсэх;

37.3.3.талууд харилцан хүлээсэн үүргээ биелүүлсэн, эсхүл бодит ажил гүйлгээ хийгдсэн эсэх.

37.4.Харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн гэрээний нөхцөл болон бодит гүйцэтгэлийн хооронд зөрүү үүссэн тохиолдолд гэрээний талуудын оролцоо, чиг үүрэг, гүйцэтгэл, зарцуулсан хөрөнгө, хүлээсэн эрсдэл зэрэг бодит гүйцэтгэлийг харгалзан татварын суурьт тохируулга хийнэ.

**38 дугаар зүйл.Үнэ шилжилтийн тайлан**

38.1.Үнэ шилжилтийн тайланг дараах байдлаар ангилна:

38.1.1.үнэ шилжилтийн ажил гүйлгээний жилийн тайлан;

38.1.2.дотоод үнэ шилжилтийн тайлан;

38.1.3.ерөнхий үнэ шилжилтийн тайлан;

38.1.4.улс бүрээр тайлан.

38.2.Татвар төлөгч хяналтад байгаа ажил гүйлгээний мэдээллийг хадгалах, тайлагнах үүрэг хүлээнэ.

38.3.Татвар төлөгч татварын хяналт шалгалт хийхээс өмнө болон хийгдэх үед үнэ шилжилтийн тайлантай холбогдох татварын албаны шаардсан нэмэлт мэдээллийг тухай бүр гаргаж өгнө.

38.4.Татвар төлөгч үнэ шилжилтийн ажил гүйлгээний жилийн тайланг жилийн эцсийн татварын тайлангийн хамт харьяалах татварын албанд хүргүүлнэ.

38.5.Дотоод үнэ шилжилтийн тайлан дараах мэдээллийг агуулна:

38.5.1.Монгол Улсад байрладаг татвар төлөгч, эсхүл төлөөний газрын бизнесийн үйл ажиллагаа болон бизнесийн стратеги, бодлогын талаарх мэдээлэл;

38.5.2.хяналтад байгаа ажил, гүйлгээний харьцуулагдах байдлын шинжилгээ хийхэд шаардагдах мэдээлэл, харьцуулагдах боломжтой бие даасан ажил гүйлгээний мэдээлэл, ашигласан үнэ шилжилтийн аргачлал болон холбогдох бусад мэдээлэл;

38.5.3.Монгол Улсад байрладаг татвар төлөгчтэй холбогдох ажил, гүйлгээний санхүүгийн мэдээлэл;

38.5.4.энэ хуулийн 38.9-д заасан журамд шаардагдах бусад мэдээлэл.

38.6.Ерөнхий үнэ шилжилтийн тайлан дараах мэдээллийг агуулна:

38.6.1.групп болон группийн оролцогчдын хувьцаа, хувь оролцооны шууд болон шууд бус эзэмшлийн бүтэц;

38.6.2.групп болон группийн оролцогчдын үйл ажиллагаа явуулж байгаа газар зүйн байрлал;

38.6.3.бизнесийн үндсэн үйл ажиллагаа, борлуулалт, худалдан авалт, нийлүүлэлтийн суваг, нэмүү өртөг үүсгэхэд ашиглагдаж байгаа голлох хөрөнгө, групп болон группийн оролцогчдын үйл ажиллагааны чиг үүрэг, хүлээх эрсдэл, тухайн санхүүгийн жилд гарсан бүтцийн өөрчлөлтөд нөлөөлсөн томоохон ажил гүйлгээний мэдээлэл;

38.6.4.групп болон группийн оролцогчдын эзэмшиж байгаа биет бус хөрөнгө, тэдгээрийн эзэмшлийн бүтэц, биет бус хөрөнгөтэй холбогдуулан баримталж байгаа үнэ шилжилтийн бодлого;

38.6.5.групп болон группийн оролцогчдын хооронд хийгдсэн санхүүгийн ажил гүйлгээ болон үүнтэй холбогдуулан баримталж байгаа үнэ шилжилтийн бодлого;

38.6.6.групп, түүний оролцогчид, эсхүл тухайн татвар төлөгчийн санхүүгийн болон татварын асуудлаар баримталж байгаа бодлого, бусад улсын татварын албатай байгуулсан нэг болон хоёр талт үнэ урьдчилан тохиролцох гэрээний мэдээлэл;

38.6.7.харилцан хамааралтай этгээдийн энэ хуулийн 38.6.1, 38.6.2, 38.6.3, 38.6.4, 38.6.5, 38.6.6-д заасантай адилтгах болон энэ хуулийн 38.9-д заасан журамд шаардагдах мэдээлэл.

38.7.Улс бүрээр тайлан гаргах этгээд, тайлагнах нарийвчилсан харилцааг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 27 дугаар зүйлд зааснаар зохицуулна.

38.8.Дараах татвар төлөгч энэ хуулийн 38.1.2, 38.1.3-т заасан тайланг жилийн эцсийн татварын тайлангийн хамт харьяалах татварын албанд хүргүүлнэ:

38.8.1.өмнөх татварын жилд зургаа болон түүнээс дээш тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олсон;

38.8.2.группийн нэгтгэсэн санхүүгийн тайланд үйл ажиллагаа нь тусгагддаг бөгөөд өмнөх татварын жилд нэгтгэсэн санхүүгийн тайлангаар тус групп нь зургаа болон түүнээс дээш тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олсон;

38.8.3.гадаадын хөрөнгө оруулалттай.

38.9.Энэ хуулийн 38.1-д заасан үнэ шилжилтийн тайлан тус бүрийн маягтын загвар, түүнийг нөхөх заавар, тайлагнах нарийвчилсан харилцааг зохицуулсан журмыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, жишиг баримт бичгүүдэд нийцүүлэн татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

**39 дүгээр зүйл.Үнэ шилжилтийн тохируулга хийх**

39.1.Татвар төлөгч нь үнэ шилжилтийн тайлан гаргаагүй, эсхүл татварын ногдлоо дутуу тодорхойлж тайлагнасан бол татварын алба нь үнэ шилжилтийн үндсэн тохируулга хийж, татварыг нөхөн ногдуулж, хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

39.2.Татварын алба энэ хуулийн 39.1-д заасан үндсэн тохируулгыг хийхээс гадна хувь хүний орлогын албан татвар болон аж ахуй нэгжийн орлогын албан татварын зорилгоор тохируулгын үр дүнд бий болсон үнийн зөрүүг ногдол ашиг гэж үзэж хоёрдогч тохируулгыг хийнэ.

**40 дүгээр зүйл.Үнэ шилжилтийн тохируулга хийх аргачлал**

40.1.Үнэ шилжилтийн тохируулга хийхэд дараах аргыг ашиглана:

40.1.1.харьцуулагдах бие даасан үнийн арга;

40.1.2.дамжуулан борлуулах үнийн арга;

40.1.3.өртөг дээр нэмэх арга;

40.1.4.ажил гүйлгээний цэвэр ашгийн арга;

40.1.5.ажил гүйлгээний ашиг хуваах арга;

40.1.6.энэ хуулийн 37 дугаар зүйлд заасан үнэ шилжилтийн ерөнхий зарчимд нийцсэн бусад арга.

40.2.Татварын алба энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан үнэ шилжилтийн тохируулгыг хийхдээ энэ хуулийн 40.1-д заасан аргаас хамгийн тохиромжтой гэж үзсэн аргыг ашиглах бөгөөд доор дурдсан нөхцөлийг харгалзан бодит үнэ тодорхойлох зарчимд үндэслэн тогтооно:

40.2.1.хяналтад байгаа ажил гүйлгээний онцлог;

40.2.2.энэ хуулийн 37.3-т заасан нөхцөл;

40.2.3.бие даасан гүйлгээтэй харьцуулж болохуйц бодит мэдээлэл, нөхцөл;

40.2.4.хяналтад байгаа болон бие даасан ажил гүйлгээний харьцуулагдах түвшин.

40.3.Хяналтад байгаа ажил гүйлгээнд тохируулга хийх аргыг сонгоход уг аргын давуу болон сул талыг харьцуулах замаар энэ хуулийн 40.1-д заасан аргыг дангаар, эсхүл хослуулж ашиглана.

40.4.Үнэ шилжилтийн тохируулга хийх хамгийн тохиромжтой аргыг сонгох, хэрэглэх журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

40.5.Татварын хууль тогтоомж болон энэ хуулийн 40.4-т заасан журмаар зохицуулаагүй, энэ хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан эрх зүйн баримт бичигтэй зөрчилдөөгүй тохиолдолд татварын алба үнэ шилжилтийн тохируулга хийхдээ “Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас гаргасан Үнэ шилжилтийн зөвлөмж”-ийг ашиглаж болно.

40.6.Татвар төлөгч нь үл мэдээлэгч улсын жагсаалтад байгаа улсын хуулийн этгээдтэй хяналтад байгаа ажил гүйлгээг хийж гүйцэтгэсэн, эсхүл энэ хуулийн 39.1-д заасан үүргээ биелүүлээгүй, эсхүл үнэ шилжилтийн тайланг буруу мэдээлсэн тохиолдолд татварын алба дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

40.6.1.татвар төлөгчтэй харьцуулагдах өөр бусад татвар төлөгчийн нээлттэй мэдээлэлд үндэслэн, эсхүл татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангаас сонгож харьцуулах замаар нөхөн ногдуулалт хийх;

40.6.2.татвар төлөгчийн мэдээллийг задруулахгүйгээр түүний ажил гүйлгээний үнийг харьцуулалт хийх зорилгоор авч болох бөгөөд энэ тохиолдолд уг этгээдийн мэдээллийг нууцална.

40.7.Энэ хуулийн 40.6-д заасан үл мэдээлэгч улс, бүс нутгийн жагсаалтад Монгол Улстай татварын зорилгоор мэдээлэл солилцдоггүй болон эрсдэлтэй татварын тогтолцоотой улс, бүс нутгийг хамруулах бөгөөд энэхүү жагсаалтыг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны дотор, жагсаалтад өөрчлөлт орсон бол ажлын 10 өдрийн дотор татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага албан ёсны цахим хуудсаараа нийтэд мэдээлнэ.

## ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

## ТАТВАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ

**41 дүгээр зүйл.Татварын хяналт шалгалт**

41.1.Татвар төлөгч татварын хууль тогтоомжид заасны дагуу төлбөл зохих татварын ногдлоо бүрэн гүйцэд тодорхойлж, хугацаанд нь төлсөн эсэхийг татварын алба хянан шалгана.

41.2.Татварын алба татварын хяналт шалгалтыг ерөнхий болон тусгай удирдамж, томилолттой хийх бөгөөд бүрэн, эсхүл хэсэгчилсэн хэлбэрээр олон улсын жишиг, хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлнэ.

41.3.Татвар төлөгчийн эрсдэлд үндэслэн хялбаршуулсан хяналт шалгалт хийж болно.

41.4.Татварын алба эрсдэлд, эсхүл татвар төлөгчийн хүсэлтэд үндэслэн татвар төлөгчийн хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн биелэлтийг хянан шалгана.

41.5.Татварын хяналт шалгалт хийх талаар татвар төлөгчид ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.

41.6.Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нь татвар төлөгчийн улс, орон нутгийн төсөвт оруулж байгаа орлогын хэмжээ, татварын төрөл, үйл ажиллагааны чиглэлийг харгалзан хяналт шалгалтын харьяаллыг тогтоож болно.

41.7.Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах зорилгоор татварын албанаас хэрэгжүүлэх дараах ажиллагаа энэ хуулийн 41.5-т хамаарахгүй:

41.7.1.Онцгой албан татварын тэмдгийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих;

41.7.2.татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд холбогдсон эсэхэд хяналт тавих;

41.7.3.цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, олгох, илгээх, хадгалах үйл ажиллагаанд хяналт тавих.

41.8.Татварын алба нь татварын улсын байцаагчийн мэргэжлийн ур чадвар, ажлын дадлага туршлага, ашиг сонирхлын зөрчилд өртөхгүй байх нөхцөлийг харгалзан татварын хяналт шалгалтыг зохион байгуулж, томилгоо хийж, удирдамжийг батална.

41.9.Татварын хяналт шалгалтыг хоёр болон түүнээс дээш татварын улсын байцаагчийн бүрэлдэхүүнтэй хийж гүйцэтгэнэ.

41.10.Татварын алба нь татварын хяналт шалгалт хийх зорилгоор дараах эрх хэмжээг хэрэгжүүлэх эрхтэй:

41.10.1.татвар төлөгч болон түүний харилцагч этгээдийг үндэслэл бүхий шалтгаанаар дуудан ирүүлж, тайлбар авах;

41.10.2.энэ хуулийн 5 дугаар бүлэгт заасан нийтлэг ажиллагааг хэрэгжүүлэх;

41.10.3.татварын болон нягтлан бодох бүртгэлийн тайлан, данс бүртгэл, санхүүгийн бусад баримт болон татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэлтэй холбоотой тайлбар, лавлагаа гаргуулан авах.

41.11.Татварын алба, татварын улсын байцаагч хяналт шалгалт хийхдээ дараах ажиллагааг хэрэгжүүлэхийг хориглоно:

41.11.1.энэ хуулийн 41.4-т зааснаас бусад үндэслэлээр хяналт шалгалт хийх;

41.11.2.татварын улсын байцаагч татвартай холбогдсон эрүү, захиргааны хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээчээр оролцох.

41.12.Татвар төлөгч нь татварын хяналт шалгалтад дараах эрх, үүрэгтэй байна:

41.12.1.эрх, хууль ёсны ашиг сонирхлоо биечлэн, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч, мэргэшсэн зөвлөхөөрөө дамжуулан хамгаалах, татварын хяналт шалгалтад биечлэн байлцах, нотолгоо, үндэслэл гаргах;

41.12.2.татвар ногдуулалт, төлөлт, татварын хяналт шалгалтын явц, үр дүнгийн талаар тайлбар авах буюу өгөх;

41.12.3.татварын хяналт шалгалтад шаардлагатай санхүүгийн болон бусад баримтыг шаардсаны дагуу цахим болон цаасан хэлбэрээр татварын албанд гарган өгч, татварын хяналт шалгалтад хамрагдах.

41.13.Татварын хяналт шалгалтын үйл ажиллагааны журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга баталж, мөрдүүлнэ.

**42 дугаар зүйл.Нөхөн ногдуулалтын акт**

42.1.Татварын улсын байцаагч энэ хуулийн 16.2, 16.3, 36.1, 37.1, 41.1-д заасан үндэслэлээр нөхөн ногдуулалтын акт, эсхүл илтгэх хуудас үйлдэх бөгөөд нөхөн ногдуулалтын акт нь тэмдэглэх, тогтоох хэсгээс, илтгэх хуудас нь тэмдэглэх хэсгээс бүрдэнэ.

42.2.Нөхөн ногдуулалтын актаар татвар төлөгчийн татварын ногдлыг нэмэгдүүлэх, эсхүл бууруулах өөрчлөлт хийх бөгөөд ногдол бууруулсан зөрүүг нөхөн ногдуулалтын акт үйлдсэн татварын жилийн татварын үлдэгдлийн тооцоололд оруулан тооцно.

42.3.Нөхөн ногдуулалтын акт, илтгэх хуудас нь нэгдсэн бүртгэл, дугаартай байх бөгөөд хавсралтын хамт хүчинтэй байна.

42.4.Нөхөн ногдуулалтын акт, илтгэх хуудаст хяналт шалгалт хийсэн татварын улсын байцаагч гарын үсэг зурж, хариуцсан нэгжийн дарга хянан баталгаажуулж гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

42.5.Татварын алба, татварын улсын байцаагч нь албан ёсны маягтад эцэслэн баталгаажуулаагүй нөхөн ногдуулалтын актыг татвар төлөгчид урьдчилан танилцуулахгүй.

42.6.Нөхөн ногдуулалтын акт, илтгэх хуудсыг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 7 өдрийн дотор гардуулж, гардуулсан тухай тэмдэглэл үйлдэнэ.

42.7.Татвар төлөгч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч нь нөхөн ногдуулалтын акт, илтгэх хуудсыг энэ хуулийн 42.6-д заасан хугацаанд гардуулах боломжгүй, эсхүл гардан аваагүй бол татварын алба уг хугацаа өнгөрснөөс хойш 7 хоногийн дотор татвар төлөгчийн хувийн хэрэгт бүртгүүлсэн хаягт шуудангаар илгээнэ.

42.8.Нөхөн ногдуулалтын акт, илтгэх хуудсыг энэ хуулийн 42.7-д заасны дагуу илгээсэн өдрөөс хойш Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлд заасан хугацаанд гардуулсанд тооцно.

**43 дугаар зүйл.Нөхөн ногдуулалтын актад гомдол гаргах**

43.1.Татвар төлөгч нөхөн ногдуулалтын актыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хүлээн зөвшөөрөхгүй бол нөхөн ногдуулалтын актыг гардан авснаас хойш 30 хоногийн дотор энэ хуулийн 46.1-д заасан Маргаан таслах зөвлөлд гомдол гаргаж болно.

43.2.Татвар төлөгч энэ хуульд заасан хугацаанд нөхөн ногдуулалтын актыг гардан аваагүй нь шүүхийн болон захиргааны журмаар гомдол гаргах хугацааг хуульд заасан журмын дагуу тоолохгүй байх үндэслэл болохгүй.

43.3.Татвар төлөгч энэ хуулийн 43.1-д заасны дагуу гомдол гаргасан нь ногдуулсан татвар, алданги, торгууль төлөхийг зогсоох үндэслэл болохгүй.

43.4.Татварын алба нь татварын улсын байцаагчийн үйлдсэн нөхөн ногдуулалтын акт болон шийтгэлийн хуудсын биелэлтийг хангуулахад хяналт тавин ажиллана.

**44 дүгээр зүйл.Татварын хяналт шалгалтын явцад илрүүлсэн зөрчлийг шийдвэрлэх**

44.1.Татварын хяналт шалгалтыг хийх явцад Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил илэрсэн тохиолдолд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.

**45 дугаар зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулах хяналт шалгалт**

45.1.Татвар төлөгчийн нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулах хүсэлтийг харьяа татварын алба хүлээн авч, хянаж шалган, баталгаажуулж, саналыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын том татвар төлөгч хариуцсан нэгжид шилжүүлнэ.

45.2.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын том татвар төлөгч хариуцсан нэгж нь энэ хуулийн 45.1-д заасан саналыг хүлээн авч нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг хянан шалгаж, баталгаажуулсан акт үйлдэнэ.

45.3.Татвар төлөгч энэ хуулийн 45.2-т заасан шийдвэрийг зөвшөөрөхгүй бол энэ хуулийн 46.1-д заасан Татварын маргаан таслах зөвлөлд гомдол гаргаж шийдвэрлүүлнэ.

## АРАВДУГААР БҮЛЭГ
## МАРГААН ТАСЛАХ ЗӨВЛӨЛ

**46 дугаар зүйл.Маргаан таслах зөвлөл**

46.1.Татварын албаны дэргэд татвар төлөгчөөс энэ хуулийн 6.1.26-д заасан татварын акттай холбогдуулан гаргасан гомдол, Захиргааны ерөнхий хуулийн 94.2-т заасан хүсэлтийг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий Татварын маргаан таслах зөвлөл /цаашид “Маргаан таслах зөвлөл” гэх/ ажиллана.

46.2.Маргаан таслах зөвлөл нь дарга, гишүүдээс бүрдэнэ.

46.3.Энэ хуулийн 46.1-д заасны дагуу татвар төлөгчийн гаргасан гомдлыг харьяаллын дагуу татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн Татварын албаны дэргэдэх Маргаан таслах зөвлөл тус тус шийдвэрлэнэ.

46.4.Маргаан таслах зөвлөл нь ес, эсхүл 11 хүний бүрэлдэхүүнтэй байна. Маргаан таслах зөвлөлийн ажиллах журмыг Засгийн газар батална.

46.5.Маргаан таслах зөвлөлийг тухайн байгууллагын удирдлагатай зөвшилцсөний үндсэн дээр дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулна:

46.5.1.аймаг, нийслэлийн татварын албаны дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнд нутгийн захиргааны байгууллага, татварын албаны төлөөлөл, мэргэжлийн төрийн бус байгууллагын төлөөлөл;

46.5.2.татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнд татварын болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, татварын албаны төлөөлөл, мэргэжлийн төрийн бус байгууллагын төлөөлөл.

46.6.Маргаан таслах зөвлөлийн гишүүн нь нягтлан бодогч, санхүүч, эдийн засагч, эсхүл эрх зүйч мэргэжилтэй, мэргэжлээрээ гурваас дээш жил ажилласан туршлагатай байна.

46.7.Маргаан таслах зөвлөлийн дэргэд татвар төлөгчийн гомдлыг хянан шийдвэрлэх зорилгоор татварын асуудлаар дүн шинжилгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий хараат бус магадлагч ажиллах бөгөөд магадлагч нь тухайн шатны татварын албаны дарга томилсон татварын улсын байцаагчийн эрхтэй этгээд байна.

46.8.Маргаан таслах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь татварын улсын байцаагчийн эрхтэй байх бөгөөд түүнийг Маргаан таслах зөвлөлийн даргын санал болгосноор тухайн шатны татварын албаны дарга томилно.

46.9.Аймаг, нийслэлийн татварын албаны дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүн болон даргыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга, татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүн болон даргыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус томилж, чөлөөлнө.

**47 дугаар зүйл.Маргаан таслах зөвлөлд гомдол гаргах, шийдвэрлэх**

47.1.Татвар төлөгч, эсхүл түүний эрх олгосон итгэмжлэгдсэн төлөөлөгч, мэргэшсэн зөвлөх татварын актыг гардаж авснаас хойш энэ хуулийн 43.1, 72.4-т заасан хугацаанд харьяалах Маргаан таслах зөвлөлд гомдол гаргах эрхтэй.

47.2.Гомдол нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

47.3.Нөхөн ногдуулалтын актад гомдол гаргахдаа уг актаар нөхөн ногдуулсан татварын хүлээн зөвшөөрөөгүй дүнгийн 10 хувийг урьдчилж төлөх ба уг төлөх дүн нь 100 сая төгрөгөөс хэтрэхгүй байна.

47.4.Маргаан таслах зөвлөл, шүүх татвар төлөгчийн нөхөн ногдуулалтын актад гаргасан гомдол, нэхэмжлэлийг ханган эцэслэн шийдвэрлэсний үр дүнд энэ хуулийн 47.3-т заасны дагуу урьдчилан төлсөн татварын дүнгээс татвар төлөгчид буцаан олгох асуудлыг энэ хуулийн 49 дүгээр зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

47.5.Энэ хуулийн 47.1-д заасан гомдлыг дараах харьяаллын дагуу шийдвэрлэнэ:

47.5.1.аймаг, нийслэлийн татварын албанд харьяалагдах татвар төлөгчийн гомдлыг тухайн аймаг, нийслэлийн татварын албаны дэргэдэх Маргаан таслах зөвлөл;

47.5.2.том татвар төлөгч хариуцсан нэгжид харьяалагдах татвар төлөгчийн гомдлыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Маргаан таслах зөвлөл.

47.6.Маргаан таслах зөвлөл нь холбогдох татварын акт, ирүүлсэн гомдол, хүсэлт болон бусад баримт бичиг, мэдээллийг хянаж, 3 хоногийн дотор харьяаллыг тогтоож, харьяаллын бус бол маргааныг холбогдох Маргаан таслах зөвлөлд энэ хуулийн 47.5-т заасан харьяаллын дагуу шилжүүлнэ.

47.7.Маргаан таслах зөвлөлийн хуралдаан нь бүх гишүүний гуравны хоёр нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцогдоно.

47.8.Маргаан таслах зөвлөл нь гомдлыг хуралдаанаараа хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

47.9.Маргаан таслах зөвлөл нь энэ хуулийн 46.1-д заасан гомдлыг татвар төлөгчийн гомдлын хүрээнд хянан шалгаж, шийдвэр гаргана.

47.10.Маргаан таслах зөвлөл нь татварын актаар баталгаажуулсан дүнг өөрчлөх, хүчингүй болгох, хэвээр үлдээх, түдгэлзүүлж татварын албанд буцаах шийдвэрийн аль нэгийг гаргах бөгөөд уг шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна.

47.11.Маргаан таслах зөвлөл гомдлыг хэлэлцэх явцад доор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь үүсвэл 3 хүртэл сарын хугацаагаар актыг дахин шалгуулахаар дээд шатны татварын албанд буцааж, гомдол бүхий нөхөн ногдуулалтын актыг нэг удаа түдгэлзүүлж болно:

47.11.1.илрүүлсэн татварын актын бичилтийн болон тооцооны алдаа нь тухайн татварын актын нөхөн ногдуулалт, торгууль, алдангийн нийт дүнг нэмэгдүүлэх;

47.11.2.гомдлын нөхцөл байдлыг цаашид тодруулах шаардлагатай, асуудлыг дутуу шийдвэрлэсэн бөгөөд нэмж тодруулах зүйлийн цар хүрээ нь маргаан таслах зөвлөлийн магадлан судлах боломжоос хэтэрсэн.

47.12.Татварын алба шинэ акт гаргах бол өмнө гаргасан нөхөн ногдуулалтын акт хүчингүй болох бөгөөд энэ хуулийн 47.11-д заасан хугацаанд шинэ акт гаргаагүй бол Маргаан таслах зөвлөл асуудлыг дахин хэлэлцэж шийдвэрлэнэ.

47.13.Маргаан таслах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь маргаан таслах зөвлөлийн хэлэлцсэн асуудал болон гаргасан шийдвэрийн үндэслэлийн дэлгэрэнгүй тэмдэглэлийг хөтөлж, зөвлөлийн шийдвэрийг татвар төлөгч, татварын улсын байцаагч, магадлагч зэрэг хувь хүн, хуулийн этгээдийн нэр, хувийн мэдээллийг таних боломжгүйгээр цахим хуудсаар мэдээлнэ.

47.14.Маргаан таслах зөвлөл нь маргаан үүссэн шалтгаан, түүний нөхцөлийг арилгуулах, татварын хууль тогтоомж зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор зөвлөмж гаргаж, татварын албанд хүргүүлэх эрхтэй.

47.15.Маргаан таслах зөвлөл нь татвар төлөгчийн гомдол гаргаснаас хойш 30 хоногийн дотор гомдлыг шийдвэрлэж, уг шийдвэрийг маргааны оролцогч талуудад гардуулна.

47.16.Маргаан таслах зөвлөл нь энэ хуулийн 47.15-д заасан шийдвэр гаргах хугацааг нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.

47.17.Маргаан таслах зөвлөлд гомдол гаргасан татвар төлөгч нь энэ хуулийн 47.15, 47.16-д заасан хугацаанд магадлагч татварын улсын байцаагчийн шаардсан нотлох баримтыг ирүүлээгүй бол ирүүлсэн нотлох баримтын хүрээнд гомдлыг хянан шийдвэрлэнэ.

47.18.Маргаан таслах зөвлөлийн гаргасан шийдвэрийг зөвхөн шүүхийн шийдвэрээр өөрчилнө.

47.19.Татвар төлөгч нь Маргаан таслах зөвлөлийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд шийдвэрийг гардан авснаас хойш 30 хоногийн дотор шүүхэд хандах эрхтэй.

47.20.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65.1.3-т заасантай адилтгах шалтгаанаар Маргаан таслах зөвлөл татвар төлөгчийн гомдлыг хянан шийдвэрлэх боломжгүй бол татварын актыг хэлэлцэхийг түдгэлзүүлж болно.

Тайлбар: “тооцооны алдаа” гэж татварын актад бичигдсэн тоон илэрхийллийг арифметик, оронгийн гэх мэт илт тооцооны алдаа гаргасан байхыг ойлгоно.

## АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
## ТАТВАРЫН НОГДУУЛАЛТ, ТӨЛӨЛТ, ТАТВАРЫН ӨР

**48 дугаар зүйл.Татвар ногдуулалт, төлөлтийн бүртгэл**

48.1.Татварын алба нь татвар, торгууль, алдангийн ногдуулалт, төлөлтийг татвар төлөгч бүрээр бүртгэнэ.

48.2.Татварын алба нь татвар төлөгч бүрийн төлбөл зохих татварын ногдуулалт, төлөлт, хөнгөлөлт, чөлөөлөлт, татварын өрийг татварын тайлан болон шийтгэлийн хуудас, татварын актад үндэслэн бүртгэнэ.

48.3.Татварын хяналт шалгалтын үр дүнд тайлангийн ногдол буурсан тохиолдолд татварын алба татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд холбогдох өөрчлөлтийг хийнэ.

48.4.Татварын орлого бүртгэх, орлогын данснаас татвар хооронд суутган тооцох журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

**49 дүгээр зүйл.Татварыг буцаан олгох, суутган тооцох**

49.1.Татварын алба татвар төлөгчийн илүү төлсөн татварыг доор дурдсан дарааллын дагуу шийдвэрлэнэ:

49.1.1.буцаан олгох;

49.1.2.тухайн хугацаанд төлбөл зохих бусад татварт суутган тооцох;

49.1.3.татвар төлөгч зөвшөөрвөл дараагийн хугацаанд төлөх татварт суутган тооцох.

49.2.Татвар төлөгч татварын өртэй бол энэ хуулийн 49.1-д заасан дарааллыг үл харгалзан татварын өрийг түрүүлж суутган тооцно.

49.3.Татварыг суутган тооцохдоо энэ хуулийн 52.1-д заасан дарааллыг баримтална.

49.4.Илүү төлсөн татварыг буцаан олгох харилцааг тухайн төрлийн татварын хуулиар нарийвчлан зохицуулж болно.

49.5.Илүү төлсөн татварыг суутган тооцсон бол татварын алба энэ тухай татвар төлөгчид мэдэгдэнэ.

49.6.Энэ хуулийн 49.1.1-д заасан буцаан олголт нь төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна.

49.7.Татварын алба татварын хөнгөлөлт, илүү төлөлтийг хуулийн дагуу буцаан олгох зориулалттай харилцах данстай байх бөгөөд данс хөтлөх, түүнтэй холбоотой харилцааг зохицуулах журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

**50 дугаар зүйл.Татварын өр**

50.1.Доор дурдсан хугацаанд төлөөгүй татвар, алданги, торгууль /цаашид “татварын өр” гэх/-ийг татварын өрд тооцно:

50.1.1.татвар төлөгчийн татварын тайлангаар тодорхойлсон татварын хувьд татварын хууль, тогтоомжид зааснаар татвараа төлж, тайлагнасан байх ёстой өдөр;

50.1.2.тайлан боловсруулалтаар болон татвар төлөгчийн хүсэлтээр хийсэн залруулгын тайлангаар тодорхойлсон татварын хувьд залруулгын тайлан хүлээн авсан өдөр;

50.1.3.нөхөн ногдуулалтын акт, шийтгэлийн хуудсаар тогтоосон татвар, алданги, торгуулийн хувьд уг шийдвэрийг гардуулснаас хойш ажлын 15 өдөр;

50.1.4.татварын хууль тогтоомжоор тайлагнадаггүй татварын хувьд татварын хууль тогтоомжоор татвараа төлсөн байх ёстой өдөр.

50.2.Нөхөн ногдуулалтын актыг Маргаан таслах зөвлөл, шүүхийн шийдвэрээр эцэслэн тогтоосон тохиолдолд энэ хуулийн 50.1.3-т заасан өрийн хэмжээг уг шийдвэрийг үндэслэн өөрчилнө.

**51 дүгээр зүйл.Татварын нэхэмжлэх**

51.1.Татварын алба энэ хуулийн 50 дугаар зүйлд заасан татварын өрийг төлүүлэхээр татварын нэхэмжлэх /цаашид “нэхэмжлэх” гэх/-ийг татвар төлөгчид хүргүүлэх бөгөөд түүнд дараах зүйлийг тусгана:

51.1.1.татвар төлөгчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;

51.1.2.татвар төлөгчийн бүртгэлийн дугаар;

51.1.3.нэхэмжлэх хүргүүлсэн хугацаа;

51.1.4.татвар ногдох зүйл, татварын өр төлөх үндэслэл;

51.1.5.татварын өр, алдангийн хэмжээ, татварын өр төлөх эцсийн хугацаа;

51.1.6.татварын өр төлөх газар, дансны нэр, дансны дугаар;

51.1.7.нэхэмжлэхийг татвар төлөгчид хүргүүлснээс хойш ажлын 10 хүртэл өдөрт багтаан татварын өрийг төлөх тухай шаардлага;

51.1.8.татварын албанаас зайлшгүй гэж үзсэн бусад шаардлага.

51.2.Татварын алба нэхэмжлэхийг татварын өр үүссэн хугацаанаас хойш ажлын 30 өдөрт багтаан татвар төлөгчид хүргүүлнэ.

**52 дугаар зүйл.Татварын өр төлөх дараалал**

52.1.Татварын өрийг доор дурдсан дарааллаар барагдуулна:

52.1.1.татварын үндсэн өр;

52.1.2.алданги;

52.1.3.торгууль.

**53 дугаар зүйл.Татвар төлөх хугацааны хөнгөлөлт**

53.1.Доор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь үүсэж татвар төлөгч татварын өрийг төлөх боломжгүй болох нь тогтоогдсон бол татвар төлөгчийн бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн харьяа татварын алба татвар төлөх хугацааг 1 жил хүртэлх хугацаагаар сунгаж хөнгөлөлт үзүүлж болно:

53.1.1.Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.1-д заасан гамшиг болон үер, газар хөдлөлт, гал түймэрт өртсөн;

53.1.2.энэ хуулийн 6.1.41.а, 6.1.41.б-д заасан хүндэтгэн үзэх шалтгааны улмаас татвар төлөгч хувь хүний хувьд өмнөх жилийн татвар ногдох орлогоос илүү хэмжээтэй эмчилгээний зардал гаргасан;

53.1.3.татвар төлөгч эрхэлж байгаа үйл ажиллагаагаа зогсоосон;

53.1.4.татвар төлөгчийн үйл ажиллагаанд 3 жил дараалан их хэмжээний алдагдал хүлээж, төлбөрийн чадвар муудсан.

53.2.Татвар төлөгч энэ хуулийн 53.1-д заасан хөнгөлөлтийн хугацаанд татварын өрийг төлөх боломжгүй хүндэтгэн үзэх нөхцөл үүссэн тохиолдолд татвар төлөгчийн хүсэлтийг үндэслэн харьяалах татварын алба хугацааг дахин сунгаж болно. Сунгах хугацаа нь анхны хөнгөлөлтийг оруулан нийт 2 жилээс илүүгүй байна.

53.3.Татварын өр төлөх хугацааны хөнгөлөлт үзүүлэхэд дараах зарчим баримтална:

53.3.1.татвар төлөх хугацааны хөнгөлөлтөд хамаарах татварын өрийн дүн нь 10.0 сая төгрөгөөс доош, эсхүл хөнгөлөх хугацаа нь 3 сар хүртэлх татварын өрд барьцаа хөрөнгө шаардахгүй бөгөөд бусад тохиолдолд сунгасан хугацаанд хамаарах алдангийн хэмжээг оруулсан дүнгээс багагүй хэмжээний барьцаа хөрөнгийг шаардана;

53.3.2.барьцааны зүйл нь үл хөдлөх эд хөрөнгө, Засгийн газрын үнэт цаас байх ба барьцаалах ажиллагааг Иргэний хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийг баримтлан хэрэгжүүлнэ;

53.3.3.энэ хуулийн 53.3.1-д заасан барьцааны оронд бусад этгээдийн батлан даалтыг ашиглаж болно;

53.3.4.татвар төлөгчийн бичгээр гаргасан хүсэлтэд хөрөнгийн байдал, санхүүгийн чадавхыг тэмдэглэн, түүнд үндэслэн гаргасан хөнгөлөлтийн хугацаанд татварын өр төлөх хуваарийг тусгана.

53.4.Татварын өр төлөх хугацааг хөнгөлсөн бол хөнгөлөлтийн хугацаанд тухайн татварын өрийг хураах энэ хуульд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй.

53.5.Энэ хуулийн 53.1, 53.2-т заасны дагуу татварын өр төлөх хугацааг хөнгөлсөн тохиолдолд хөнгөлөлтийн хугацаанд тооцох алдангийг 20 хувиар хөнгөлнө.

53.6.Энэ хуулийн 53.1, 53.2-т зааснаар татвар төлөгч сунгасан хугацаанд эрсдэлтэй татвар гэж үзэх нөхцөл байдал үүссэн, эсхүл хуваарийн дагуу татварын өрийг төлөөгүй, барьцааны зүйлийг өөрчлөхийг зөвшөөрөөгүй болон түүний дараа гарах нөхцөл байдлын өөрчлөлт нь хөнгөлөлтийг үргэлжлүүлэхэд зохистой бус гэж үзсэн тохиолдолд татварын албаны дарга хөнгөлөлтийг цуцалж, барьцааны зүйлээс татварын өрийг гаргуулна.

53.7.Энэ хуулийн 53.6-д заасны дагуу хөнгөлөлтийг цуцалсан тохиолдолд эхний ээлжид үл хөдлөх эд хөрөнгө, үнэт цаас зэрэг татвар төлөгчийн хөрөнгөөс татварын өрийг гаргуулах бөгөөд уг хөрөнгөөс гаргуулж хүрэлцэхгүй тохиолдолд батлан даагчаас татварын өрийг гаргуулах зарчим баримтална.

53.8.Батлан даагчаас татварын өрийг гаргуулахдаа энэ хуулийн 58.1, 58.2-т заасны дагуу мэдэгдэх хуудсыг хүргүүлнэ. Батлан даагч нь батлан даасан үүрэгт хамаарах татварыг мэдэгдэх

хуудсанд заасан хугацаанд төлөөгүй бол энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу нэхэмжлэх хүргүүлнэ. Батлан даагч тухайн нэхэмжлэхэд заасан хугацаанд татварын өрийг төлөөгүй бол татварын өр хураах ажиллагааг эхлүүлнэ.

53.9.Татварын өр төлөх хугацааны хөнгөлөлтийг зөвшөөрсөн болон цуцалсан талаар татварын албаны даргын шийдвэрийг өртэй татвар төлөгчид ажлын 10 өдрийн дотор мэдэгдэнэ.

53.10.Татварын өр төлөх хугацааг хөнгөлөх журам, энэ үйл ажиллагаатай холбогдох маягтын агуулга, загварыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

**54 дүгээр зүйл.Эрсдэлтэй татварыг урьдчилан хураах үйл ажиллагаа**

54.1.Доор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь үүсэж, татвар төлөгч татвараа төлөхгүй нь тодорхой болсон тохиолдолд ногдол нь тодорхой татварыг татварын алба урьдчилан хурааж болно:

54.1.1.татвар төлөгчийн хөрөнгөд энэ хуулийн 6.1.4-т заасан албадан гүйцэтгэх үйл ажиллагаа эхэлсэн;

54.1.2.татвар төлөгч татан буулгах шийдвэр гаргасан;

54.1.3.татвар төлөгч Монгол Улсад оршин суух хаяггүй болсон;

54.1.4.татвар төлөгч хууль бус үйлдлээр татвар төлөхөөс зугтах, эсхүл зугтахыг оролдох, татварын бүцаан олголт авах, эсхүл авахыг оролдох, залилангийн шинжтэй үйлдлээр хөрөнгө шилжүүлэх, санаатайгаар дампуурах зэргээр татварын өр хураах үйл ажиллагаанаас зугтах, эсхүл зугтахыг оролдсон.

54.2.Энэ хуулийн 54.1-д заасны дагуу татварыг ажлын 3 өдөрт багтаан төлүүлэхээр урьдчилан нэхэмжлэх хуудас хүргүүлнэ.

## АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ
## ТАТВАРЫН ӨР ХУРААХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

**55 дугаар зүйл.Татварын өр хураах үйл ажиллагаа**

55.1.Татварын алба дараах тохиолдолд татварын өр хураах үйл ажиллагааг эхлүүлнэ:

55.1.1.татвар төлөгчөөс болон татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдээс татварын өрийг нэхэмжлэхэд заасан хугацаанд бүрэн төлөөгүй;

55.1.2.татвар төлөгч энэ хуулийн 54.2-т заасан урьдчилан нэхэмжлэх хуудас болон энэ хуулийн 53 дугаар зүйлээр тогтоосон хугацаанд татвараа бүрэн төлөөгүй;

55.1.3.өв залгамжлагчаас татварын өрийг нэхэмжлэхэд заасан хугацаанд татвараа бүрэн төлөөгүй;

55.1.4.татвар төлөх хугацаанаас хойш нэхэмжлэх хүлээн авсан татвар төлөгчид энэ хуулийн 54.1-д заасан нөхцөл байдал үүссэн.

55.2.Татварын алба татварын өрийг хураах үйл ажиллагааг дараах дарааллын дагуу хэрэгжүүлнэ:

55.2.1.нэхэмжлэх хүргүүлэх;

55.2.2.татварын өрийг үл маргах журмаар гаргуулах;

55.2.3.бэлэн мөнгө хураах;

55.2.4.хөрөнгө болон авлага битүүмжлэх;

55.2.5.битүүмжилсэн хөрөнгийг хураах;

55.2.6.битүүмжлэн хураасан хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлэх;

55.2.7.орлогыг хуваарилах;

55.3.Татварын өрийг бүрэн хураах зорилгоор энэ хуулийн 55.2-т заасан ажиллагааг давхардуулан явуулж болно.

**56 дугаар зүйл.Татварын давуу эрхийн зарчим**

56.1.Энэ хуулийн 56.2, 56.3, 56.4, 56.5, 56.6, 56.7-д зааснаас бусад тохиолдолд татварыг аливаа авлагаас түрүүлж гаргуулна.

56.2.Татвар төлөгчийн хөрөнгөд энэ хуулийн 6.1.4-т заасан албадан гүйцэтгэх үйл ажиллагаа явуулж, хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлсэн тохиолдолд тухайн мөнгөн хөрөнгөөс татварын алба татварын өрийг гаргуулах хүсэлт гаргасан бол татварын өрийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад бүртгэгдсэн дараалал үл харгалзан тухайн үйл ажиллагааны зардлын дараа хураана.

56.3.Татвар төлөгчийн хөрөнгийг татварын өр хураах үйл ажиллагааны дагуу мөнгөн хэлбэрт шилжүүлсэн бол тухайн мөнгөн хөрөнгөөс татвар хураах шууд зардлыг энэ хуулийн 56.4, 56.5.3, 56.6, 56.7-д заасныг үл харгалзан бусад татвар болон авлагаас түрүүлж хураана.

56.4.Онцгой албан татвар болон автобензин, дизелийн түлшний албан татвар ногдох зүйлийг албадан гүйцэтгэх ажиллагааны дагуу мөнгөн хэлбэрт шилжүүлсэн бол тухайн мөнгөн хөрөнгөөс шилжүүлгийн дүнд үүссэн онцгой албан татвар, автобензин, дизелийн түлшний албан татварыг энэ хуулийн 56.5, 56.6, 56.7-д заасныг үл харгалзан бусад татвар болон авлагаас түрүүлж хураана.

56.5.Татварын өр хураах үйл ажиллагаагаар хийсэн битүүмжлэлд хамаарах хоёр болон түүнээс дээш татварын албанд бүртгэлтэй татвар төлөгчийн татварын өрийг дараах байдлаар хураана:

56.5.1.тухайн татварын өрийг хураах зорилгоор хөрөнгө битүүмжилсэн бол битүүмжлэлд хамаарах татварыг суутгуулах хүсэлт гаргасан бусад татварын өрөөс түрүүлж;

56.5.2.хэд хэдэн суутгуулах хүсэлт гаргасан татварын өрийн хувьд хүсэлт гаргасан дарааллаар татварын өрийг түрүүлж;

56.5.3.татвар төлөгч татвар төлөх хугацааг хөнгөлүүлж, хөрөнгө барьцаалсан бол энэ хуулийн 56.5.1, 56.5.2-т заасныг үл харгалзан барьцаанд хамаарах татварыг бусад татварын өрөөс түрүүлж.

56.6.Татвар төлөгчийн барьцаа, ипотекийн барьцаа зэрэг гуравдагч этгээдээс давуу эрхтэйгээр шаардах эрхтэй хөрөнгөөс татварын өрийг гаргуулах тохиолдолд татварын өрийг эдгээр авлагын дараа хураана.

56.7.Бүртгүүлэх боломжгүй барьцаа, эсхүл бүртгэл хийгдээгүй ч түрүүлж авах шаардах эрхийн хувьд албадан гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагад нотолсон тохиолдолд энэ хуулийн 56.6-д заасан давуу эрх үйлчилнэ.

56.8.Энэ хуулийн 56.7-д заасан этгээд нь баримт нотолгоо гаргаагүй бол энэ хуульд заасан давуу эрхийг эдлэхгүй.

56.9.Бусдын амь нас, эрүүл мэндэд учруулсан гэм хорыг арилгуулах, тэжээн тэтгэх үүрэгтэй холбоотой бол энэ хуульд заасныг үл харгалзан татвар, авлагаас түрүүлж уг хохирлыг барагдуулна.

**57 дугаар зүйл.Татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээд**

57.1.Өртэй татвар төлөгчийн хөрөнгөөс татварын өрийг хураахад уг хөрөнгө хүрэлцэхгүй нь тогтоогдсон бөгөөд татварын өр үүссэн хуулийн хугацаанаас нэг жилийн өмнөх өдрөөс хойш хугацаанд тухайн өртэй татвар төлөгч хөрөнгөө үнэгүй, эсхүл хэт бага үнээр бусдад шилжүүлсэн, бусдаас авах авлагаа хүчингүй болгож бусад этгээдэд ашигтай байдлыг бий болгосон бол шилжүүлж авсан хөрөнгө, хүчингүй болгосон авлагын хэмжээгээр тухайн этгээд татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээд болно.

**58 дугаар зүйл.Татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдээс татварын өр хураах нийтлэг журам**

58.1.Татвар төлөгчийн татварын өрийг төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдээс татварын өрийг гаргуулахаар тухайн этгээдэд доор дурдсан агуулга бүхий мэдэгдэх хуудас хүргүүлнэ:

58.1.1.өртэй татвар төлөгчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;

58.1.2.татварын өр үүссэн хугацаа, татварын төрөл, татварын өрийн дүн, татвар төлөх эцсийн хугацаа;

58.1.3.татварын өр төлөх газар, дансны нэр, дансны дугаар.

58.2.Энэ хуулийн 58.1.2-т заасан татварын өр төлөх эцсийн хугацаа нь мэдэгдэх хуудас хүргүүлснээс хойш ажлын 20 өдөр байна.

58.3.Татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээд энэ хуулийн 58.1.2-т заасан хугацаанд төлөөгүй бол татварын алба эрсдэлтэй татварыг урьдчилан хураах үйл ажиллагааг явуулахаас бусад тохиолдолд нэхэмжлэх хүргүүлнэ.

58.4.Татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдэд энэ хуулийн 53, 54 дүгээр зүйл нэгэн адил үйлчилнэ.

58.5.Хөрөнгийн үнэ цэнэ огцом буурах магадлалтайгаас бусад тохиолдолд татварын өрийг өртэй татвар төлөгчийн битүүмжилсэн хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааг эхлүүлэхээс өмнө татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдийн хөрөнгөөс татварын өр хураах үйл ажиллагааг хэрэгжүүлж болохгүй.

58.6.Татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдээс өртэй татвар төлөгчийн татварын өрийг гаргуулсан бол тухайн өртэй татвар төлөгчөөс нэхэмжлэх эрхтэй.

58.7.Татварын өрийг татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдээс гаргуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

**59 дүгээр зүйл.Өртэй татвар төлөгчийн хөрөнгийн байдлыг тогтоох**

59.1.Татварын улсын байцаагч татварын өр хураах үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд өртэй татвар төлөгчийн хөрөнгийн байдлыг дараах аргаар тогтооно:

59.1.1.хөрөнгийн байдлын талаар асуулга явуулах;

59.1.2.татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэлд үндэслэн хөрөнгийн байдлыг тогтоох;

59.1.3.энэ хуулийн 5 дугаар бүлэгт заасан татварын албанаас хэрэгжүүлэх нийтлэг ажиллагаа явуулах;

59.1.4.хөрөнгийн өмчлөл, эзэмшил, ашиглалтыг гуравдагч этгээдийн мэдээлэл, лавлагаанд үндэслэн тогтоох.

59.2.Энэ хуулийн 59.1.1-д заасны дагуу дараах этгээдэд асуулга явуулж, шаардлагатай тохиолдолд тухайн этгээдийн хөрөнгийн талаарх бичиг баримтыг шалгаж болно:

59.2.1.өртэй татвар төлөгч;

59.2.2.өртэй татвар төлөгчийн хөрөнгийг эзэмшигч гуравдагч этгээд, эсхүл тухайн хөрөнгийг эзэмшиж байгаа гэж үзэх хангалттай шалтгаан бүхий гуравдагч этгээд;

59.2.3.өртэй татвар төлөгчтэй авлага, эсхүл өглөгийн харилцаатай этгээд, өртэй татвар төлөгчийн хөрөнгийг авсан гэж үзэх хангалттай шалтгаан бүхий этгээд;

59.2.4.өртэй татвар төлөгчийн хувь нийлүүлсэн, хөрөнгө оруулсан хуулийн этгээд.

59.3.Энэ хуулийн 59.1.3-т заасан нийтлэг ажиллагааг явуулахдаа энэ хуулийн 19.4-т заасан журмыг баримтална.

59.4.Энэ хуулийн 59.1.4-т заасан хөрөнгийн талаарх мэдээлэл, лавлагааг улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон холбогдох бусад байгууллагаас гаргуулж авна.

59.5.Татварын улсын байцаагч татварын өр хураах үйл ажиллагаанд шаардлагатай тохиолдолд өртэй татвар төлөгчийн оршин суугаа газар болон тухайн хөрөнгийг нуусан байж болзошгүй газарт үзлэг хийж болно.

59.6.Татварын улсын байцаагч үзлэг хийх явцад татварын өртэй этгээд болон гуравдагч этгээдээр хаалга, сейф, бусад агуулах савыг нээлгүүлэх, татвар төлөгч уг ажиллагааг хийхээс татгалзсан тохиолдолд татварын улсын байцаагч шаардлагатай арга хэмжээг авч нээж болно.

**60 дугаар зүйл.Хөрөнгө битүүмжлэх**

60.1.Өртэй татвар төлөгчийн хөрөнгийг битүүмжлэх гэснийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 49.1-д заасан утгаар ойлгох бөгөөд барьцааны эрхгүй хөрөнгөөс эхлэн битүүмжлэх зарчим баримтална.

60.2.Энэ хуулийн 60.1-д заасан барьцааны эрхгүй хөрөнгөөс татварын өрийг хурааж хүрэлцэхгүй тохиолдолд барьцааны эрхтэй хөрөнгийг битүүмжилж болно.

60.3.Гуравдагч этгээдийн шаардах эрхтэй хөрөнгийг битүүмжилсэн тохиолдолд тухайн гуравдагч этгээдээс татварын албанд ирүүлсэн хүсэлтийг үндэслэн өртэй татвар төлөгчийн битүүмжилсэн хөрөнгийг татварын өрийг хураах боломжтой, түргэн борлогдох болон гуравдагч этгээдийн эрхийн үйлчлэлгүй хөрөнгөөр сольж болно.

60.4.Татварын алба татварын өр хураах зардал бага байх, хөрвөх чадвар өндөртэй хөрөнгийг түрүүлж битүүмжлэх замаар татварын өрийг хураана.

60.5.Татварын өр хураахад шаардлагатайгаас бусад хөрөнгийг битүүмжилж болохгүй.

60.6.Битүүмжлэх хөрөнгийн үнийн дүн нь битүүмжлэх болон татварын өр хураах зардал, тухайн татварын өрөөс өмнө хураагдах барьцааны эрх бүхий гуравдагч этгээдэд төлөх өрийн нийлбэр дүнд хүрэлцэхгүй тохиолдолд тухайн хөрөнгийг битүүмжлэхгүй.

60.7.Татварын алба өртэй татвар төлөгчийн хөрөнгийг битүүмжилсэн бол битүүмжлэх актыг үйлдэнэ. Битүүмжилсэн хөрөнгө нь хөдлөх эд хөрөнгө, үнэт цаас, банкан дахь данс, авлага, шаардах эрх бүхий биет бус хөрөнгө байгаа тохиолдолд битүүмжлэх акт, мэдэгдэх хуудсын хуулбарыг өртэй татвар төлөгчид хүргүүлнэ.

60.8.Өртэй татвар төлөгч татварын өрөө бүрэн барагдуулсан, эсхүл энэ хуулийн 53 дугаар зүйлд заасан татвар төлөх хугацааны хөнгөлөлт эдэлсэн тохиолдолд татварын алба хөрөнгийг битүүмжлэх актыг хүчингүй болгоно.

60.9.Хөрөнгө битүүмжлэх, хураах, хадгалах, хамгаалахтай холбогдох харилцааг зохицуулах журмыг энэ хуульд өөрөөр заагаагүй бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 49, 50, 51, 52, 53, 54, 56 дугаар зүйлд заасныг жишиг болгон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Тайлбар:“шаардах эрх бүхий биет бус хөрөнгө” гэж банк, банк бус санхүүгийн байгууллага болон хадгаламж, зээлийн хоршоонд оруулсан хөрөнгө, хувьцаа худалдах, худалдан авахаар брокер, дилерт өгсөн захиалга зэрэг хамаарна.

**61 дүгээр зүйл.Битүүмжлэхийг хориглох хөрөнгө, орлого**

61.1.Дараах хөрөнгийг битүүмжлэхийг хориглоно:

61.1.1.өртэй татвар төлөгч, түүний гэр бүлийн гишүүдийн өдөр тутмын хэрэглээний хувцас, хэрэглэл;

61.1.2.өртэй татвар төлөгчийн байнга амьдран суугаа зөвхөн нэг орон сууц болон өртэй татвар төлөгчийн хүйтний улиралд хэрэглэж байгаа түлээ, түлш;

61.1.3.газар тариалан, мал аж ахуй, гар урлал эрхэлдэг этгээдийн хувьд амьжиргааны эх үүсвэр болдог үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай багаж хэрэгсэл, эд зүйлс, тоног төхөөрөмж, мал, малын тэжээл;

61.1.4.гамшиг, аюулт үзэгдэл, осол, онцгой нөхцөл байдлын улмаас үзүүлж байгаа тусламж, тэтгэлэг, хандив;

61.1.5.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж;

61.1.6.донорын олговор;

61.1.7.нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж болон нийгмийн халамжийн үйлчилгээ, нийгмийн хөгжлийн үйлчилгээний хүрээнд олгосон тусламж, дэмжлэг.

61.2.Удаан хадгалах боломжгүй, түргэн муудах хүнсний бүтээгдэхүүн, хуучирч элэгдэн хэрэгцээ хангахгүй болсон эд зүйлийг битүүмжлэхгүй.

61.3.Өртэй татвар төлөгчийн хөдлөх эд хөрөнгө болон үнэт цаасыг гэр бүлийн гишүүн, харилцан хамааралтай этгээдээс бусад гуравдагч этгээд эзэмшдэг бөгөөд тухайн гуравдагч этгээд нь шилжүүлэхээс татгалзсан тохиолдолд битүүмжлэхгүй.

**62 дугаар зүйл.Хөдлөх эд хөрөнгө болон үнэт цаас битүүмжлэх, бэлэн мөнгө хураах, татварын өр гаргуулах**

62.1.Хөдлөх эд хөрөнгө, үнэт цаасыг битүүмжлэхдээ татварын улсын байцаагч тухайн хөрөнгийг татварын албаны мэдэлд авч хэрэгжүүлнэ. Битүүмжлэлийн үйлчлэл нь татварын улсын байцаагч хөрөнгийг татварын албаны мэдэлд авснаар үүснэ.

62.2.Өртэй татвар төлөгчийн хөрөнгийн байдлыг тогтоох үед бэлэн мөнгө илэрсэн тохиолдолд татварын өрөөс илүүгүй хэмжээгээр хураан авч нэн даруй татварын орлогын дансанд шилжүүлнэ. Шилжүүлсэн мөнгөн дүнгийн хэмжээгээр тухайн татвар төлөгчөөс татварын өрийг хураасан гэж үзнэ.

62.3.Үнэт цаас битүүмжилсэн тохиолдолд татварын алба тухайн үнэт цаасыг борлуулж татварын өрийг хурааж болно. Үнэт цаасыг борлуулсан орлогын хэмжээгээр өртэй татвар төлөгчөөс татварын өрийг хураасан гэж үзнэ.

62.4.Татвар төлөгчийн хөрөнгөөс татварын өрийг хурааж хүрэлцэхгүй бол татвар төлөгчийн гуравдагч этгээдэд эзэмшүүлсэн хөдлөх эд хөрөнгө болон үнэт цаасыг татварын албаны мэдэлд авна.

62.5.Энэ хуулийн 62.4-т заасныг хэрэгжүүлэхдээ гуравдагч этгээдэд хөрөнгийг ажлын 5 өдрийн дотор шилжүүлэх тухай бичгээр үүрэг болгож энэ тухай өртэй татвар төлөгчид мэдэгдэнэ.

62.6.Энэ хуулийн 62.5-д заасны дагуу гуравдагч этгээд хөрөнгийг шилжүүлээгүй тохиолдолд татварын улсын байцаагч тухайн хөдлөх эд хөрөнгө, үнэт цаасыг битүүмжилж болно.

62.7.Энэ хуулийн 62.4-т заасан гуравдагч этгээд нь өртэй татвар төлөгчтэй гэрээ байгуулсан түрээсийн эрх, үнэгүй түрээслэх эрх болон бусад хөдлөх хөрөнгийг ашиглах, эсхүл ашиг орлого олох эрхэд суурилсан эзэмшлийн эрхтэй тохиолдолд гэрээг цуцлах, эсхүл гэрээг цуцлахгүйгээр гурван сараар хязгаарлан тухайн хөдлөх хөрөнгийг ашиглах, ашиг орлого олох хоёр нөхцөлөөс аль нэгийг нь сонгох боломжтой.

62.8.Татварын алба шаардлагатай тохиолдолд битүүмжилсэн хөдлөх хөрөнгө, үнэт цаасыг өртэй татвар төлөгч, эсхүл тухайн хөрөнгийг эзэмшиж байгаа гуравдагч этгээдэд хадгалуулж болно. Хадгалсан газар нь энэ хуулийн 62.1-д зааснаас үл хамааран лацдах, олон нийтэд мэдээлсэн болон бусад битүүмжлэл тодорхойлох аргаар битүүмжилсэн болохыг илэрхийлсэн тохиолдолд битүүмжлэл үйлчилж эхэлсэн гэж үзнэ.

62.9.Энэ хуулийн 62.8-д заасны дагуу битүүмжилсэн хөрөнгийг хадгалуулсан тохиолдолд татварын өр хураахад хүндрэл үүсэхгүй нь тодорхой бол татвар төлөгчид уг хөрөнгийг ашиглах, эсхүл ашиг орлого олохыг зөвшөөрч болно.

62.10.Татварын улсын байцаагч үнэт цаасыг битүүмжлэх актыг тухайн үнэт цаасыг арилжих, бүртгэх, төлбөр тооцоог гүйцэтгэх, хадгалах үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдэд хүргүүлж гүйцэтгэнэ.

Тайлбар: “мэдэлд авах” гэж татварын алба татварын өртэй этгээдийн хөрөнгийн өмчлөл, эзэмшлийг өөрчлөхгүйгээр тухайн хөрөнгийг захиран зарцуулах, эзэмших, ашиглах эрхийг хязгаарлан битүүмжилсэн тухай тэмдэглэгээ үйлдэх арга хэмжээг ойлгоно.

**63 дугаар зүйл.Татварын өрийг үл маргах журмаар гаргуулах**

63.1.Үл маргах журмаар татвар төлөгчийн банкан дахь дансыг битүүмжлэх, татварын өрийг гаргуулахад дараах журмыг баримтална:

63.1.1.татварын улсын байцаагч татварын өрийг өртэй татвар төлөгчийн банкан дахь мөнгөн хөрөнгөөс хураах тухай битүүмжлэх мэдэгдэх хуудсыг татварын албаны даргаар батлуулан харилцагч банканд хүргүүлэх;

63.1.2.энэ хуулийн 63.1.1-д заасан битүүмжлэх мэдэгдэх хуудсанд өртэй татвар төлөгчийн нэр, татвар төлөгчийн дугаар, битүүмжилсэн мөнгөн хөрөнгийг шилжүүлбэл зохих банкны нэр, дансны дугаар, харилцагч банкны нэр, хаяг, татварын өр хураах үндэслэл, татварын өрийн дүн, зарлагын гүйлгээг бүрэн буюу хэсэгчлэн зогсоох тухай заах;

63.1.3.битүүмжлэх мэдэгдэх хуудас хүлээн авсан даруйд банк битүүмжлэх мэдэгдэх хуудсанд заасан дансанд өртэй татвар төлөгчийн нэг буюу түүнээс дээш дансанд байгаа мөнгөн хөрөнгөөс татварын өрийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн шилжүүлэх;

63.1.4.банкан дахь мөнгөн хөрөнгө нь татварын өрийг төлөхөд хүрэлцэхээргүй бол уг данснаас төлөгдөх шүүхийн шийдвэрээр төлөх үүрэг бүхий авлагыг хамруулсан бусад зарлагын гүйлгээг бүрэн буюу хэсэгчлэн зогсоож, тухайн данснаас татварын өрийг битүүмжлэх мэдэгдэх хуудсанд заасан дансанд шилжүүлэх.

**64 дүгээр зүйл.Авлага битүүмжлэх, татварын өр гаргуулах**

64.1.Авлага битүүмжлэх ажиллагааг өртэй татвар төлөгчид өглөгтэй гуравдагч этгээдэд битүүмжлэх мэдэгдэх хуудас хүргүүлж хэрэгжүүлнэ. Авлага битүүмжлэх ажиллагаа авлага битүүмжлэх мэдэгдэх хуудсыг гуравдагч этгээдэд хүргүүлснээр эхэлнэ.

64.2.Авлагыг нийт дүнгээр нь битүүмжлэх боловч татварын өр авлагаас бага тохиолдолд хэсэгчлэн битүүмжилж болно.

64.3.Цалин хөлс, болон тэдгээртэй адилтгах байнгын орлогыг битүүмжлэх ажиллагаа битүүмжилсний дараа орж ирэх орлогоос хураавал зохих татварын өрийг бүрэн хураах хүртэл хугацаанд үргэлжилнэ.

64.4.Татварын улсын байцаагч авлага битүүмжлэхдээ шаардлагатай тохиолдолд холбогдох бичиг баримтыг хураж болно.

64.5.Татварын улсын байцаагч татварын өрийг битүүмжилсэн авлагаас гаргуулан хураах эрхтэй.

64.6.Цалин хөлс /цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого хамаарна/-ийг битүүмжлэхэд дараах журмыг баримтална:

64.6.1.татварын улсын байцаагч татварын өрийг өртэй татвар төлөгчийн цалин хөлснөөс гаргуулахын тулд цалин хөлсийг олгох үүрэгтэй хувь хүн, хуулийн этгээдэд битүүмжлэх мэдэгдэх хуудас хүргүүлэх;

64.6.2.битүүмжлэх мэдэгдэх хуудсанд өртэй татвар төлөгчийн нэр, хаяг, битүүмжлэгдсэн цалин хөлсийг шилжүүлбэл зохих банкны нэр, дансны дугаар, татвар төлөгчид цалин хөлсийг олгох хувь хүн, хуулийн этгээдийн нэр, хаяг, татварын өрийн дүн, төлбөр хийх хугацаарь, битүүмжлэх мэдэгдэх хуудсыг гардуулсан огноог тус тус заах;

64.6.3.битүүмжлэх мэдэгдэх хуудас хүлээн авсан хувь хүн, хуулийн этгээд нь цалин хөлсийг олгох өдөр төлбөрийн хугацарийн дагуу татварын өрийг суутгаж, суутгал хийснээс хойш ажлын 3 өдрийн дотор битүүмжлэх мэдэгдэх хуудсанд заасан дансанд шилжүүлэх;

64.6.4.татварын өрийг шүүхийн шийдвэрээр төлөх үүрэгтэй авлагыг хамруулсан бусад авлагаас түрүүлж шилжүүлэх;

64.6.5.өртэй татвар төлөгч ажлаас чөлөөлөгдсөн, эсхүл халагдсан бол ажлын 7 өдрийн дотор татварын өрд суутгасан дүн болон өртэй татвар төлөгчийн шилжилт хөдөлгөөний мэдээллийг татварын албанд хүргүүлэх;

64.6.6.цалин хөлснөөс татварын өрийг гаргуулахдаа Хөдөлмөрийн тухай хуулийн 63.2-т заасныг баримтална.

64.7.Авлага битүүмжилсэн хугацаанд өртэй татвар төлөгч гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээ, хэлцэлд өөрчлөлт оруулах, дуусгавар болгохыг хориглоно.

**65 дугаар зүйл.Үл хөдлөх эд хөрөнгө, агаарын хөлөг, автомашин, барилгын тоног төхөөрөмжийг битүүмжлэх, татварын өр гаргуулах**

65.1.Үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжлэх, үйлчлэлийн хугацаа болон битүүмжилсэн үл хөдлөх эд хөрөнгийг ашиглах, ашиг орлого олох харилцааг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

65.1.1.үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжлэхдээ өртэй татвар төлөгчид битүүмжлэлийн хуудас хүргүүлэх бөгөөд битүүмжлэх ажиллагаа нь тухайн битүүмжлэлийн хуудсыг өртэй татвар төлөгчид хүргүүлснээр эхлэх;

65.1.2.татварын алба үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжилсэн талаар бүртгэх байгууллагад бүртгүүлэх бөгөөд бүртгэлийг битүүмжлэлийн хуудас хүргүүлэхээс өмнө хийсэн бол энэ хуулийн 65.1.1-д заасныг үл хамааран бүртгүүлснээр битүүмжлэх ажиллагаа үүсэх;

65.1.3.татвар төлөгч битүүмжилсэн үл хөдлөх эд хөрөнгийг ашиглах, ашиг орлого олох боломжтой боловч үл хөдлөх эд хөрөнгийн үнэ цэнийг огцом бууруулах магадлалтай үйлдэл хийх гэж байгаа нь тогтоогдсон тохиолдолд татварын алба тухайн үл хөдлөх хөрөнгийн ашиглалт болон ашиг олох үйл ажиллагааг хязгаарлаж болох бөгөөд энэ нь битүүмжилсэн үл хөдлөх эд хөрөнгийг ашиглах болон ашиг орлого олох эрхтэй гуравдагч этгээдэд мөн хамаарах.

65.2.Агаарын хөлгийг битүүмжлэх, үйлчлэлийн хугацаа болон битүүмжилсэн агаарын хөлгийг түр зогсоох ажиллагааг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

65.2.1.агаарын хөлгийг битүүмжлэхдээ энэ хуулийн 65.1.1, 65.1.2-т заасныг баримтлах;

65.2.2.нислэг үйлдэхэд бэлэн байгаа агаарын хөлгөөс бусад агаарын хөлгийг татварын албаны шийдвэрээр түр хугацаагаар зогсоох;

65.2.3.татварын өр хураах үйл ажиллагаанд шаардлагатай бол битүүмжилсэн агаарын хөлгийг хамгаалах, хадгалах арга хэмжээг авах;

65.2.4.энэ хуулийн 65.2.3-т заасан арга хэмжээг битүүмжлэлийн хуудас хүргүүлэхээс өмнө авсан бол тухайн арга хэмжээг авах үед битүүмжлэх ажиллагааг эхлэх;

65.2.5.татварын албаны даргын шийдвэрээр агаарын хөлгийг битүүмжилсэн, эсхүл энэ хуулийн 65.2.2-т заасны дагуу зогсоосон агаарын хөлгийг хүндэтгэн үзэх шалтгаантай бол хөдөлгөх зөвшөөрөл олгох.

65.3.Автомашин, барилгын тоног төхөөрөмжийн битүүмжлэх ажиллагаа, үйлчлэлийн хугацаа болон битүүмжилсэн автомашин, барилгын тоног төхөөрөмжийг хөдөлгөх, ашиглах ажиллагааг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

65.3.1.улсын бүртгэлд бүртгэлтэй автомашин, барилгын тоног төхөөрөмжийг битүүмжлэхдээ энэ хуулийн 65.1.1, 65.1.2-т заасныг баримтлах;

65.3.2.автомашин, барилгын тоног төхөөрөмж битүүмжлэхэд энэ хуулийн 65.2.3, 65.2.4-т заасныг дагаж мөрдөх;

65.3.3.татварын албаны шийдвэрээр автомашин, барилгын тоног төхөөрөмжийг битүүмжлэх бөгөөд энэ тохиолдолд өртэй татвар төлөгч тухайн хөрөнгийг татварын албаны мэдэлд шилжүүлэх;

65.3.4.энэ хуулийн 65.3.3-т заасны дагуу автомашин, барилгын тоног төхөөрөмжийг татварын албаны мэдэлд шилжүүлсэн тохиолдолд энэ хуулийн 62.1, 62.4, 62.5, 62.6, 62.7, 62.8-д заасныг дагаж мөрдөх;

65.3.5.татварын алба энэ хуулийн 65.3.3-т заасны дагуу мэдэлдээ авсан автомашин, барилгын тоног төхөөрөмжийг өртэй татвар төлөгч болон тухайн хөрөнгийг эзэмшиж байгаа гуравдагч этгээдэд хадгалуулж болох бөгөөд лацдах, олон нийтэд мэдэгдэх аргыг хэрэглэх зэргээр автомашин, барилгын тоног төхөөрөмжийг татварын алба мэдэлдээ авсныг тодорхой болгох;

65.3.6.Татварын алба энэ хуулийн 65.3.3, 65.3.5-д заасны дагуу мэдэлдээ авсан, эсхүл хадгалуулсан автомашин, барилгын тоног төхөөрөмжийг хүндэтгэн үзэх шалтгаантай бол ашиглуулахыг зөвшөөрөх.

Тайлбар:“агаарын хөлөг хадгалах, хамгаалах” гэж тухайн агаарын хөлгийг нислэг үйлдэх боломжгүй болгож байрлуулах, эсхүл агаарын хөлгийн бүртгэлийн баримт бичиг бусад хөдөлгөөнд оролцоход шаардагдах бичиг баримтыг хураан авахыг хэлнэ.

**66 дугаар зүйл.Биет бус хөрөнгө битүүмжлэх**

66.1.Биет бус хөрөнгийн хувьд гуравдагч этгээд ашиглаагүй тохиолдолд уг хөрөнгийг битүүмжлэх ажиллагааг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

66.1.1.патентын эрх, зохиогчийн эрх болон бусад гуравдагч этгээд ашиглаагүй хөрөнгийг битүүмжлэхдээ өртэй татвар төлөгчид битүүмжлэлийн хуудсыг хүргүүлэх бөгөөд битүүмжлэх ажиллагааны үйлчлэл нь тухайн битүүмжлэлийн хуудсыг өртэй татвар төлөгчид хүргүүлснээр эхлэх;

66.1.2.татварын албаны даргын шийдвэрээр хөрөнгийн эрхийг шилжүүлэх зорилгоор бүртгүүлэх шаардлагатай хөрөнгийг битүүмжилсэн тохиолдолд холбогдох байгууллагад бүртгүүлэх;

66.1.3.энэ хуулийн 54 дүгээр зүйлд заасан нөхцөл үүссэн тохиолдолд 66.1.1-д заасныг үл харгалзан 66.1.2-т заасан битүүмжлэх ажиллагааг бүртгүүлснээр битүүмжлэлийн үйлчлэл үүсэх;

66.1.4.захиран зарцуулах эрхийн хязгаарлалтыг бүртгүүлэх шаардлагатай хөрөнгийн битүүмжлэх ажиллагааны үйлчлэл нь энэ хуулийн 66.1.1, 66.1.3-т зааснаас үл хамааран бүртгүүлэхэд үүсэх.

66.2.Биет бус хөрөнгийн хувьд гуравдагч этгээдийн ашиглаж байгаа уг хөрөнгийг битүүмжлэх ажиллагааг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

66.2.1.хэвлэх эрх, хувьцаа болон бусад гуравдагч этгээдийн ашиглаж байгаа хөрөнгийг битүүмжлэхдээ гуравдагч этгээдэд битүүмжлэх мэдэгдэх хуудсыг хүргүүлэх бөгөөд битүүмжлэх ажиллагааны үйлчлэл нь тухайн битүүмжлэх мэдэгдэх хуудсыг гуравдагч этгээдэд хүргүүлснээр эхлэх;

66.2.2.энэ хуулийн 66.2.1-д заасан хөрөнгийг шилжүүлэх зорилгоор бүртгүүлэх шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 66.1.2, 66.1.3-т заасныг баримтлах.

**67 дугаар зүйл.Татварын өр хураахаар бусад байгууллагад суутгах хүсэлт гаргах**

67.1.Татвар төлөгчийн хөрөнгийг албадан гүйцэтгэх ажиллагаагаар мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагаа эхлүүлсэн бол татварын алба тухайн үйл ажиллагааг гүйцэтгэж байгаа байгууллагад татварын өрийг суутгах хүсэлтийг хүргүүлнэ. Суутгах хүсэлт хүргүүлснээр тухайн татвар төлөгчид болон хөрөнгийн барьцаалсан эрх бүхий этгээдэд мэдэгдэнэ.

67.2.Татвар төлөгчид татварын өр хураах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд мөнгөн хэлбэрт шилжүүлэхэд хялбар, гуравдагч этгээдийн эрхийг хөндөхгүй өөр хөрөнгөтэй, тухайн хөрөнгөөс татварын өрийг хураах боломжтой болох нь тогтоогдвол татварын алба суутгах хүсэлтийг гаргахгүй.

**68 дугаар зүйл.Битүүмжилсэн хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагаа**

68.1.Татвар төлөгч нөхөн ногдуулалтын актад гомдол гаргасан бол эцсийн шийдвэр гарах хүртэл хугацаанд энэ хуулийн 63 дугаар зүйлд зааснаас бусад тухайн татвар төлөгчийн битүүмжилсэн хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлэх ажиллагааг эхлүүлэхгүй.

68.2.Татвар төлөгч өөрийн ногдуулсан татвараа хуульд заасан хугацаанд нь төлөөгүйн улмаас үүссэн татварын өр, хуульд заасан хугацаанд гомдол гаргаагүй нөхөн ногдуулалтын актын өр, эсхүл нөхөн ногдуулалтын актад гаргасан гомдлын дагуу төлөхөөр Маргаан таслах зөвлөл болон шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн татварын өрийг татварын алба битүүмжилсэн хөрөнгө, энэ хуулийн 53.6, 53.7, 53.8-д заасан барьцааны зүйлээс Иргэний хуулийн холбогдох заалт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмын дагуу дуудлага худалдаа зохион байгуулж, эсхүл энэ хуульд заасан журмын дагуу шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлнэ.

68.3.Татварын алба энэ хуулийн 68.2-т заасан хөрөнгийн дуудлага худалдааны үнийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмын дагуу тогтооно.

68.4.Тухайн татвар төлөгч болон татварын улсын байцаагч, татварын албаны ажилтан мөнгөн хэлбэрт шилжүүлэх хөрөнгийг шууд болон шууд бус байдлаар худалдан авах эрхгүй.

68.5.Шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааг дараах нөхцөлд явуулна:

68.5.1.тухайн хөрөнгийг дуудлага худалдаагаар борлуулахад тохиромжгүй, эсхүл түргэн гэмтэж муудахаар байх;

68.5.2.Хөрөнгийн биржид бүртгэлтэй хөрөнгийг тухайн өдрийн зах зээлийн үнээр борлуулах бүрэн боломжтой байх;

68.5.3.дуудлага худалдааг хоёр удаа зохион байгуулсан боловч оролцогч байхгүй, худалдах үнэ нь дуудлага худалдааны анхны үнэд хүрэхгүй, эсхүл худалдан авагч төлбөр төлөх хугацаандаа төлбөрөө төлөөгүйгээс худалдан авах шийдвэрээ цуцалсан байх.

68.6.Дуудлага худалдаагаар болон шууд гэрээгээр борлуулсан хөрөнгийн орлого нь татварын өрийг хураахад хүрэлцэхээргүй бол татвар төлөгч уг татварын өрийн үлдсэн хэсгийг төлөх үүргээс чөлөөлөгдөхгүй.

68.7.Дуудлага худалдаа зохион байгуулах болон шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааны нийтлэг журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

**69 дүгээр зүйл.Мөнгөн хэлбэрт шилжүүлсэн орлогыг хуваарилах**

69.1.Мөнгөн хэлбэрт шилжүүлсэн хөрөнгийг хуваарилахдаа дараах зарчмыг баримтална:

69.1.1.татварын алба битүүмжилсэн хөрөнгийн борлуулсан орлогын дүн болон үнэт цаас, авлага, эсхүл биет бус хөрөнгийн битүүмжлэлийн дагуу гуравдагч этгээдээс хүлээн авсан мөнгөн хөрөнгийг /цаашид “шилжүүлсэн мөнгөн хөрөнгө” гэх/ битүүмжлэлтэй татвар, суутгах хүсэлт гаргасан татвар, битүүмжилсэн хөрөнгийн барьцаат эрх, ипотекийн эрх, түрүүлж авах давуу эрхийн дагуу барьцаалагдсан авлагад хуваарилах;

69.1.2.битүүмжилсэн мөнгөн хөрөнгө болон суутгалын хүсэлтээр хүлээн авсан мөнгөн хөрөнгийг тухайн битүүмжлэл, эсхүл суутгалын хүсэлтэд хамаарах татварт шилжүүлэх;

69.1.3.энэ хуулийн 69.1.1, 69.1.2-т заасны дагуу хуваарилсан мөнгөн хөрөнгөөс үлдсэн тохиолдолд тухайн үлдэгдэл мөнгөн хөрөнгийг өртэй татвар төлөгчид олгох;

69.1.4.шилжүүлсэн мөнгөн хөрөнгө нь энэ хуулийн 69.1.1-д заасан татвар болон бусад авлагын нийт үнийн дүнд хүрэлцэхгүй бол энэ хуульд заасан татварын давуу эрхийн зарчим, Иргэний хууль болон бусад хуульд заасан дараалал, үнийн дүнг тогтоон хуваарилах;

69.1.5.энэ хуулийн 69.1.1, эсхүл 69.1.2-т заасны дагуу татварын хуваарилалт хийгдсэн мөнгөн хөрөнгийг татвар, алданги, торгуульд хуваарилахдаа энэ хуульд заасан татварын өр барагдуулах дарааллыг баримтлах.

69.2.Авлагатай этгээдээс татварын албанд гаргасан хүсэлтийг дараах байдлаар хянана:

69.2.1.энэ хуулийн 69.1.1-д заасан авлагатай этгээд хөрөнгө худалдах шийдвэр гаргахаас өмнө татварын албанд хандан авлагын хүсэлт гаргах;

69.2.2.татварын алба энэ хуулийн 69.2.1-д заасан авлагын хүсэлтийг хүлээн авч, нягтлах бөгөөд бүртгэгдсэн барьцаат авлагын эрх, ипотекийн зээлийн эрх, түрүүлж авах давуу эрх болон бүртгэх боломжгүй барьцаа, эсхүл түрүүлж авах давуу эрх нь мэдэгдэж байгаа этгээд авлагын хүсэлт гаргаагүй тохиолдолд татварын албаны дарга тухайн авлагын хэмжээг тодорхойлох;

69.2.3.энэ хуулийн 69.1.1-д заасан битүүмжилсэн хөрөнгийн барьцаат эрх, ипотекийн зээлийн эрх, түрүүлж авах давуу эрхийн дагуу барьцаалагдсан авлагын хувьд энэ хуулийн 69.2.2-т заасан авлагаас бусад авлагатай этгээд хөрөнгө худалдан борлуулах шийдвэр гаргах хүртэл авлагын хэмжээтэй холбоотой хүсэлт гаргаагүй бол тухайн авлагатай этгээдэд хуваарилахгүй байх.

69.3.Хуваарилалтын тооцооллын акт үйлдэх, шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг олгохдоо дараах байдлаар хэрэгжүүлнэ:

69.3.1.Татварын алба энэ хуулийн 69.1-д заасны дагуу хуваарилахдаа хууль тогтоомжийн дагуу хуваарилах авлага, энэ хуулийн 69.2.2-т заасны дагуу татварын албаны тодорхойлсон дүн, энэ хуулийн 69.3.2-т заасан мөнгөн хөрөнгийг шилжүүлэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан хуваарилалтын тооцооллын акт үйлдэн, түүний хуулбарыг мөнгөн хөрөнгийг шилжүүлснээс хойш ажлын гурван өдөрт багтаан авлагын хүсэлт гаргасан этгээд болон энэ хуулийн 69.2.2-т заасны дагуу авлагын хэмжээг тодорхойлсон авлагатай этгээд, өртэй татвар төлөгчид хүргүүлэх;

69.3.2.шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг авлагатай этгээдэд олгох хугацааг хуваарилалтын тооцооллын актын хуулбарыг хүргүүлснээс хойш ажлын долоон өдрийн дараагийн өдөр гэж үзэх;

69.3.3.татварын алба шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг тухайн хуваарилалтын тооцооллын актын хугацааг үндэслэн олгох.

69.4.Хуваарилалтын тооцооллын акттай холбоотой санал, гомдлыг шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг олгохоос өмнө гаргаж болно.

**70 дугаар зүйл.Татварын өр хураах үйл ажиллагааг шилжүүлэх**

70.1.Татварын алба битүүмжилбэл зохих хөрөнгө болон битүүмжилсэн хөрөнгө нь тухайн албаны харьяаллын бус байвал тухайн хөрөнгө байршиж байгаа татварын албанд татварын өр барагдуулах үйл ажиллагааг шилжүүлж болно.

70.2.Татварын алба битүүмжилсэн хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлэхэд шаардлагатай бол бусад татварын албанд татварын өр барагдуулах үйл ажиллагааг шилжүүлж болно.

70.3.Энэ хуулийн 70.1, 70.2-т заасны дагуу шилжүүлсэн тохиолдолд шилжүүлэн авсан татварын алба энэ тухай өртэй татвар төлөгчид мэдэгдэнэ.

**71 дүгээр зүйл.Бусад хууль тогтоомжид заасан эрх хязгаарлах болон түдгэлзүүлэх арга хэмжээ авах**

71.1.Татварын алба энэ хуульд заасан татварын өрийг хураах ажиллагааг хэрэгжүүлэхээс өмнө татварын өрийн хэмжээнээс хамаарч татвар төлөгчид сануулах байдлаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах арга хэмжээг авч болно.

71.2.Доор дурдсан нөхцөл нэгэн зэрэг бий болсон тохиолдолд татварын алба татварын өртэй гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг татварын өрөө төлж дуустал Монгол Улсын хилээр нэвтрүүлэхгүй байхаар эрх бүхий байгууллагад хандах эрхтэй:

71.2.1.татварын өртэй этгээдэд татварын өр барагдуулах хөрөнгө, авлагагүй;

71.2.2.татварын өрийн хэмжээ нь 20 сая төгрөг ба түүнээс дээш байх.

71.3.Энэ хуулийн 71.1-д заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх журмыг санхүү, төсвийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

**72 дугаар зүйл.Татварын албаны үндэслэлгүй илүү хураасан мөнгөн хөрөнгө**

72.1.Нөхөн ногдуулалтын актыг хүчингүй болгосон буюу өөрчилсний улмаас бүрэн буюу хэсэгчлэн буцаан олгох татвар, торгууль, алдангийг татварын буцаан олголтын актаар баталгаажуулна.

72.2.Энэ хуулийн 72.1-д заасан актаар баталгаажуулснаас хойш ажлын 30 өдрийн дотор илүү төлсөн татварыг буцаан олгоно.

72.3.Энэ хуулийн 72.1-д заасан мөнгөн хөрөнгийг татвар төлөгч зөвшөөрвөл энэ хуулийн 49.1.2, 49.1.3-т заасан журмаар шийдвэрлэх бөгөөд энэ нь тухайн илүү төлөлтийн дүнд энэ хуулийн 73 дугаар зүйлд заасны дагуу алданги тооцохгүй байх үндэслэл болохгүй.

72.4.Энэ хуулийн 72.1-д заасан буцаан олгох дүнг татвар төлөгч эс зөвшөөрвөл татварын буцаан олголтын актыг гардан авснаас хойш Маргаан таслах зөвлөлд 30 хоногийн дотор гомдол гаргаж болно.

**73 дугаар зүйл.Алданги**

73.1.Татвар төлөгчийн хуулиар тогтоосон хугацаанд төлөөгүй татварт, эсхүл татварын албаны үндэслэлгүй илүү хураасан татварт тус тус алданги тооцох бөгөөд тухайн татварын жилд мөрдөх алдангийн хэмжээг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн татварын жилийн 1 дүгээр сард багтаан дараах зарчмыг үндэслэн тогтооно:

73.1.1.татвар төлөгчийн хугацаандаа төлөөгүй татварт тооцох алдангийн хэмжээг Монголбанкнаас зарласан арилжааны банкуудын зээлийн хүүгийн жилийн жигнэсэн дунджаас 20 хувиар илүү байхаар;

73.1.2.татварын албанаас үндэслэлгүй илүү хураасан татварт тооцох алдангийн хэмжээг Монголбанкнаас зарласан арилжааны банкуудын зээлийн хүүгийн жилийн жигнэсэн дундаж байхаар.

73.2.Алданги тооцох хугацааг доор дурдсанаар тодорхойлно:

73.2.1.татварын хууль тогтоомжид заасны дагуу тухайн татварыг төлбөл зохих өдрөөс түүнийг төлсөн өдрийг хүртэлх хоногийн тоогоор;

73.2.2.Татварын албаны илүү хураасан энэ хуулийн 73.1-д заасан мөнгөн хөрөнгийг хураасан өдрөөс эхлэн түүнийг буцаан олгох шийдвэр гарсан өдөр хүртэлх хоногийн тоогоор.

73.3.Татварын алданги, торгуульд алданги тооцохгүй.

## АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ
## МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБАНЫ ТОГТОЛЦОО

**74 дүгээр зүйл.Монголын татварын алба**

74.1.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь татварын хууль тогтоомжийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн.

74.2.Монголын татварын алба нь татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн татварын газар, хэлтэс, тасаг, татварын улсын байцаагч, хураагчаас бүрдэнэ.

74.3.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь том татвар төлөгчтэй харилцах, хэвлэл мэдээлэл, мэдээллийн технологи, сургалт, татварын үйлчилгээ хариуцсан харьяа нэгжтэй байж болно.

74.4.Татварын алба нь өөрийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэх, татварын болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

74.5.Татварын алба нь бэлгэ тэмдэгтэй байх бөгөөд түүний загвар, хэрэглэх журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

**75 дугаар зүйл.Татварын албаны чиг үүрэг**

75.1.Татварын алба дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

75.1.1.татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах;

75.1.2.татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

75.1.3.төсвийн орлогыг бүрдүүлэх.

75.2.Татварын алба нь татвар төлөгчийн хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хүндэтгэн, татвар ногдуулах, төлөх, тайлагнах үйл ажиллагаатай холбогдуулан түүнийг хууль тогтоомжийн дагуу мэдээллээр хангаж, туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

75.3.Энэ хуулийн 78 дугаар зүйлд заасны дагуу татвар төлөгчид хүргүүлсэн зөвлөмжийг доод шатны татварын алба нь хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд шаардлагатай тохиолдолд уг зөвлөмжийг хэрэгжүүлэх асуудлаар зөвлөмж гаргасан этгээдээс зохих тодруулгыг авч болно.

75.4.Татвар төлөгч нь татварын хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх, эрхээ эдлэх талаар хуулиар зөвшөөрөгдсөн татварын мэргэшсэн зөвлөхийн туслалцаа, зөвлөгөө авах эрхтэй.

75.5.Татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх харилцааг Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулиар зохицуулна.

75.6.Татварын алба татварын хууль, тогтоомжийг олон нийтэд танин мэдүүлэх зорилгоор татварын хууль тогтоомж, заавар, аргачлалын талаар сургалт зохион байгуулна.

75.7.Татварын алба цахим хуудсандаа татварын хууль тогтоомжийг байршуулах, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтийг хамарсан сурталчилгаа, сургалт, мэдээллийн нэвтрүүлэг зохион байгуулах, нийтлэл гаргана.

75.8.Татварын алба бүх нийтийн татварын боловсролыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах, энэ чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллана.

**76 дугаар зүйл.Татварын албаны үйл ажиллагааны зарчим, эрх үүрэг, хориглох зүйл**

76.1.Татварын алба нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

76.1.1.хууль дээдлэх;

76.1.2.бусдын нөлөөнд үл автах;

76.1.3.татвар төлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, түүнийг хэрэгжүүлэх боломжийг хангах, тэдэнд итгэл үзүүлэх;

76.1.4.доод шатны байгууллага нь дээд шатны байгууллагадаа шууд захирагдах.

76.2.Хувь хүн, хуулийн этгээд, албан тушаалтан татварын алба, татварын улсын байцаагчаас хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож дарамт, шахалт үзүүлэхийг хориглоно.

76.3.Татварын алба, татварын улсын байцаагч энэ хуулийн 76.2-т заасныг зөрчсөн этгээдийн талаар холбогдох байгууллагад гомдол гаргаж, учирсан хохирлыг барагдуулахаар шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

76.4.Татварын алба, татварын улсын байцаагчийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар хуульд зааснаас бусад тохиолдолд аливаа этгээд шийдвэр гаргахыг хориглоно.

76.5.Хуульд зааснаас бусад тохиолдолд аливаа этгээд татвар ногдуулах, хөнгөлөх, чөлөөлөхтэй холбогдсон асуудлаар бусдын өмнө үүрэг хүлээхийг хориглоно.

76.6.Татварын алба бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ бусдын нөлөөнд үл автан гагцхүү хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн баримт бичгийг удирдлага болгон ажиллах бөгөөд татварын алба энэ үүргээ хэрэгжүүлэхгүй бол татвар төлөгч хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийг шаардах эрхтэй.

76.7.Татварын алба, татварын улсын байцаагч нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ татварын улсын байцаагчийн ёс зүйн дүрмийг баримтлан татвар төлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэж, тэдэнд итгэл үзүүлэн ажиллана.

76.8.Татварын алба, татварын улсын байцаагч, хураагч нь хуульд заасны дагуу татвар ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийх, татварын ногдлыг тодорхойлох, татвар төлөлтөд хяналт тавих, татвар хураахтай холбоотойгоос бусад асуудлаар татвар төлөгчийн үйл ажиллагаанд оролцохгүй.

76.9.Татварын улсын байцаагч, хураагч нь хувийн зорилгоор татвар төлөгчтэй холбогдож түүнд аливаа хэлбэрээр зөвлөгөө өгөх, нягтлан бодох бүртгэл хөтлөх, тайланг гаргах, аудит хийх, татвараас зайлсхийхэд туслах, шаардахыг хориглоно.

**77 дугаар зүйл.Татварын албаны удирдлага, түүний бүрэн эрх**

77.1.Татварын алба нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байна.

77.2.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын, аймаг, нийслэлийн татварын газар, хэлтэс татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын, дүүргийн татварын хэлтэс, сумын татварын хэлтэс, тасаг, татварын улсын байцаагч, хураагч нь аймаг, нийслэлийн татварын газар, хэлтсийн удирдлага доор тус тус ажиллана.

77.3.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага бүх шатны татварын албаны үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлага, төсөв хөрөнгөөр хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллана.

77.4.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргыг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн $18^3$.2 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Засгийн газар томилж, чөлөөлнө.

77.5.Аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн даргыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлнө.

77.6.Аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн даргыг санхүү, эдийн засаг, эсхүл нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэй иргэнийг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулна.

77.7.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга нь татварын улсын ерөнхий байцаагч байх бөгөөд Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.3-т зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

77.7.1.татварын алба, татварын улсын байцаагчийн бүрэн эрхийн хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалт болон төсөв хөрөнгөөр хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих ажлыг зохион байгуулах;

77.7.2.татварын хууль тогтоомжийг Монгол Улсын нутаг дэвсгэрт нэг мөр дагаж мөрдүүлэх ажлыг зохион байгуулах;

77.7.3.энэ хууль болон татварын бусад хууль тогтоомжоор олгосон эрхийн хүрээнд тушаал гаргах, нийтээр дагаж мөрдөх журам, заавар, аргачлал, акт, маягтын загварыг баталж мөрдүүлэх, зөвлөмж гаргах;

77.7.4.татварын улсын байцаагчийн эрх олгох, эрхийг хасах, хүчингүй болгох, түдгэлзүүлэх;

77.7.5.татварын хууль тогтоомжийн төсөл боловсруулахад оролцох, тэдгээрийг татварын албанаас хэрэгжүүлэх арга, хэлбэр, боломжийн талаарх саналаа бэлтгэж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад танилцуулах;

77.7.6.орлого ба хөрөнгийн татварыг давхардуулан ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай олон улсын хэлэлцээрийн төсөлд санал бэлтгэж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад танилцуулах;

77.7.7.татварын алба, улсын байцаагчийн шийдвэрийг хуулийн хүрээнд хянан үзэж, шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл өөрчлөх, хүчингүй болгох;

77.7.8.татварын албаны ажилтныг шилжүүлэх, сэлгэж ажиллуулах, шагнаж урамшуулах, сахилгын шийтгэл оногдуулах;

77.7.9.татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн татварын албаны ажилтныг томилох, чөлөөлөх;

77.7.10.татварын албаны дотоод хяналтыг хэрэгжүүлэх;

77.7.11.хууль тогтоомжид заасны дагуу татварын мэргэшсэн зөвлөхийн эрх олгох ажлыг эрх бүхий байгууллагатай хамтран зохион байгуулах;

77.7.12.татварын улсын байцаагчийн мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах;

77.7.13.татварын албаны төсөв, хөрөнгийг захиран зарцуулах;

77.7.14.татварын албыг гадаад, дотоодод болон шүүх, арбитрт төлөөлөх;

77.7.15.Татварын улсын байцаагчийн ёс зүйн дүрмийг боловсруулж, батлах.

77.8.Сумын татварын ажилтныг тухайн аймгийн татварын албаны дарга тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлөх бөгөөд тухайн ажилтанд сахилгын шийтгэл оногдуулах эрхтэй байна.

77.9.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга бөгөөд татварын улсын ерөнхий байцаагч нь энэ хуулийн 77.7.3, 77.7.4, 77.7.8, 77.7.13, 77.7.15-д зааснаас бусад 77.7 дахь хэсэгт заасан бүрэн эрхээс нийслэл, аймаг, дүүргийн татварын албаны удирдлагад тушаалаар шилжүүлж болно.

77.10.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын эзгүйд түүнийг дэд дарга орлоно.

**78 дугаар зүйл.Татварын хууль тогтоомж хэрэгжүүлэх зөвлөмж**

78.1.Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга энэ хуулийн 77.7.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд татварын алба үйл ажиллагаандаа заавал дагаж мөрдөх доор дурдсан зөвлөмжийг гаргаж болно:

78.1.1.татвар төлөгчийн хүсэлтэд үндэслэн, эсхүл татварын албаны санаачилгаар татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зөвлөмж;

78.1.2.Маргаан таслах зөвлөл, шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн асуудлыг улсын хэмжээнд нэг мөр хэрэгжүүлэх зөвлөмж.

78.2.Татварын алба татвар төлөгч, төрийн болон бусад этгээдийн нууцад хамаарснаас бусад мэдээллийг агуулсан олон нийтэд нээлттэй зөвлөмжийн цахим сантай байна. Зөвлөмж гарснаас хойш 10 өдрийн дотор цахим санд нийтэлнэ.

78.3.Энэ хуулийн 78.1.1-д заасан хүсэлтийг дараах тохиолдолд татварын улсын ерөнхий байцаагч хүлээн авахаас татгалзаж болно:

78.3.1.татвар төлөгч нь татварын хяналт шалгалтад хамрагдаж байгаа, эсхүл татварын хяналт шалгалт хийх талаар мэдэгдсэн;

78.3.2.татварын алба нь хүсэлтэд дурдсан асуудлаар зөвлөмж гаргаж байсан;

78.3.3.татварын албаны чиг үүрэгт үл хамаарах асуудлаар хүсэлт гаргасан;

78.3.4.татвар төлөгч татварын асуудлаар Маргаан таслах зөвлөл, шүүхэд гомдол гаргасан, эсхүл татвар төлөгчтэй холбоотой хэрэг хууль хяналтын байгууллагаар хянан шалгагдаж байгаа;

78.3.5.татвараас зайлсхийх, зугтах зорилготой асуудлыг тусгасан;

78.3.6.хөрөнгө оруулалтын гэрээ, бүтээгдэхүүн хуваах гэрээ, тогтворжуулалтын гэрчилгээтэй холбоотой татварын харилцааг тусгасан;

78.3.7.харилцан хамааралтай этгээд тогтоолгох болон үнэ шилжилтийн тохируулга, үнэ шилжилтийн тайлантай холбогдсон харилцааг тусгасан;

78.3.8.энэ хуулийн 78.7-д заасан журмаар тогтоосон шаардлага хангаагүй.

78.4.Зөвлөмж нь хуульд нийцээгүй болон энэ хуульд заасан шаардлагыг хангаагүй бол татварын улсын ерөнхий байцаагч, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн бүрэн буюу хэсэгчлэн хүчингүй болгож болно. Хүчингүй болгосон тухай хүсэлт гаргасан татвар төлөгч болон олон нийтэд мэдэгдэнэ.

78.5.Зөвлөмжид туссан асуудлаар татварын хууль тогтоомжид өөрчлөлт орсон бол түүнийг дагаж мөрдөж эхэлсэн өдрөөс зөвлөмжийг хүчингүйд тооцно.

78.6.Зөвлөмжөөр татвар төлөгчийн тухайлсан ажил, гүйлгээг татварын тайланд тусгах аливаа дүн, татварын ногдлын хэмжээг баталгаажуулахгүй.

78.7.Энэ зүйлийн зөвлөмж авах хүсэлтэд тавигдах шаардлага, хүсэлтийн маягт, зөвлөмжийн маягт, зөвлөмжийг хүчингүй болгох, олон нийтэд мэдээлэхтэй холбогдсон журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

**79 дүгээр зүйл.Татварын алба, татварын улсын байцаагчийн үйлдэх баримт бичиг**

79.1.Татварын албанаас татвар хураах, хяналт тавих, татварын шалгалт хийхтэй холбогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ гаргасан шийдвэрийг мэдэгдэл, шаардах хуудас, битүүмжлэх акт, битүүмжлэлийн хуудас, нөхөн ногдуулалтын акт, нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулсан акт, илтгэх хуудас, тэмдэглэл, татварын бүцаан олголтын акт, нэхэмжлэх, урьдчилан нэхэмжлэх хуудас, мэдэгдэх хуудас, шаардлага, суутгалын хүсэлт, хуваарилалтын тооцооллын акт, зарлан дуудах хуудас, битүүмжлэх мэдэгдэх хуудас, зөвлөмж болон татварын албаны үйлдэх бусад баримт бичиг үйлдэн баталгаажуулна.

79.2.Энэ хуулийн 79.1-д заасан баримт бичигт түүнийг үйлдсэн албан тушаалтны нэр, гарын үсэг, гаргасан шийдвэр, тухайн шийдвэрийг гаргах үндэслэл, биелүүлэх хугацаа, баримт бичгийг гардуулсан он, сар, өдрийг тусгана.

79.3.Энэ хуулийн 79.1-д заасан баримт бичгийг татвар төлөгчид биечлэн гардуулсан болон түүний оршин байгаа, эсхүл ажиллаж байгаа газрын хаягаар шууданд хийснээр, эсхүл цахимаар илгээснээр уг баримт бичгийг татвар төлөгчид гардуулсанд тооцох бөгөөд татвар төлөгчийн оршин байгаа газрыг холбогдох бүртгэх байгууллагад хамгийн сүүлд бүртгүүлсэн хаягаар тодорхойлно.

79.4.Энэ хуулийн 79.1-д заасан баримт бичгийг дараах үндэслэл, журмын дагуу үйлдэнэ:

79.4.1.татвар төлөгч болон бусад этгээдийг дуудан ирүүлэхэд мэдэгдэл бичих бөгөөд түүнд татвар төлөгчийн болон татварын улсын байцаагчийн нэр, гарын үсэг, татварын албанд ирэх хугацаа, уг мэдэгдэл үйлдсэн болон гардуулсан он, сар, өдрийг тусгах;

79.4.2.татварын хууль тогтоомжийг зөрчихөд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулах зорилгоор шаардах хуудас бичих бөгөөд түүнд шалгалт хийсэн холбогдох нэгжийн дарга болон татварын улсын байцаагч гарын үсэг зурж, зөрчлийн тухай тэмдэглэл, зөрчил гарахад нөлөөлсөн нөхцөл, шалтгааныг арилгаж, хариу өгөх хугацаа, уг шаардах хуудсыг үйлдсэн он, сар, өдөр, дугаарыг тусгах;

79.4.3.татвар төлөгчид хууль тогтоомжийн дагуу татварыг нөхөн ногдуулж хариуцлага хүлээлгэх, алданги тооцоход нөхөн ногдуулалтын акт үйлдэх бөгөөд түүнд хяналт шалгалт хийсэн холбогдох нэгжийн дарга болон татварын улсын байцаагч гарын үсэг зурж, зөрчлийн тухай тэмдэглэл, шийдвэрлэсэн үндэслэл, уг актыг үйлдсэн он, сар, өдөр, дугаарыг тусгах;

79.4.4.татварын хяналт шалгалтаар татварын хууль тогтоомж зөрчөөгүй нь тогтоогдвол илтгэх хуудас үйлдэх бөгөөд түүнд шалгалт хийсэн холбогдох нэгжийн дарга болон татварын улсын байцаагч, татвар төлөгч гарын үсэг зурж, үйлдсэн он, сар, өдөр, дугаарыг тусгах;

79.4.5.татварын алба бүрэн эрхийнхээ хүрээнд татвар төлөгчийн байр, агуулахад үзлэг хийх, тооллого явуулах, ажлын зураг авалт хийх, хөрөнгө битүүмжлэх, ярилцлага хийх, нөхөн ногдуулалтын актыг гардуулахдаа тэмдэглэл үйлдэх ба түүнд хяналт шалгалт хийсэн холбогдох нэгжийн дарга болон татварын улсын байцаагч гарын үсэг зурж, тэмдэглэл үйлдсэн он, сар, өдөр, татвар төлөгчийн хаягийг тодорхой тусгаж, шаардлагатай гэж үзвэл тэмдэглэл үйлдэхэд байлцсан хүмүүсээр гарын үсэг зуруулах;

79.4.6.татварын албаны үндэслэлгүйгээр илүү хураасан мөнгөнд алданги тооцож татвар төлөгчид олгоход татварын буцаан олголтын акт үйлдэж, түүнд буцаан олгох дүнг тогтоосон татварын улсын байцаагч гарын үсэг зурж, мөнгөн дүн, алданги тооцсон хугацаа, тооцсон алдангийн дүн, илүү төлсөн мөнгө, алдангийг тусгах;

79.4.7.татварын алба татвар төлөгчийн татварын өрийг төлүүлэхээр нэхэмжлэх, урьдчилан нэхэмжлэх хуудас, татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээд, батлан даагчаас гаргуулахдаа мэдэгдэх хуудас, татварын өрийг үл маргах журмаар болон авлагаас гаргуулахдаа битүүмжлэх мэдэгдэх хуудас бичих бөгөөд түүнд татварын өрийн хэмжээ, төлөх эцсийн хугацаа, татварын өрийг төлөх банкны данс болон татвар төлөгчийн харилцах банк болон дансны дугаар, татвар төлөгчийн болон татвар төлөгчийн нэрийн өмнөөс татварын өрийг төлөх хувь хүн, хуулийн этгээдийн нэр, хаяг, татварын улсын байцаагчийн нэр, гарын үсэг, үйлдсэн болон гардуулсан он, сар, өдөр зэрэг энэ хуульд заасан мэдээллийг тусгах;

79.4.8.татварын алба энэ хуулийн 30 дугаар зүйлийг хэрэгжүүлэхээр шаардлага үйлдэх бөгөөд түүнд шаардлага бичсэн шалтгаан, нөхцөл, татвар төлөгчийн, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээдийн болон шаардлага үйлдсэн улсын байцаагчийн нэр, гарын үсэг, үйлдсэн болон гардуулсан он, сар, өдрийг бичих;

79.4.9.татварын өрийг татвар төлөгчийн хөрөнгөөс гаргуулахдаа энэ хуульд заасны дагуу битүүмжлэх акт болон битүүмжлэлийн хуудас үйлдэнэ. Битүүмжлэх акт, битүүмжлэлийн хуудаст татварын өрд хамаарах татварын тайлант хугацаа, татварын төрөл, төлөх хуулийн хугацаа болон хэмжээ, битүүмжилсэн хөрөнгийн нэр төрөл, тоо, шинж чанар, байршил, өртэй татвар төлөгчийн нэр, хаягийг тусгах;

79.4.10.өртэй татвар төлөгчийн хөрөнгийг албадан гүйцэтгэх ажиллагаагаар мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагаа эхлүүлсэн байгууллагад татварын өрийг суутгуулахаар суутгалын хүсэлтийг хүргүүлэх бөгөөд түүнд өртэй татвар төлөгчийн нэр, хаяг, суутгуулах татварын тайлант хугацаа, татварын төрөл, төлөх хуулийн хугацаа, хэмжээ, суутгалын хүсэлтэд хамаарах албадан гүйцэтгэлээр мөнгөн хэлбэрт шилжүүлэх ажиллагааг эхлүүлсэн хөрөнгийн нэр төрөл, тоо, шинж чанар болон хаягийг тусгах;

79.4.11.татварын өр хураах зорилгоор татвар төлөгчийн хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлсэн орлогыг хуваарилахад хуваарилалтын тооцооллын акт үйлдэх бөгөөд түүнд татвар төлөгчийн нэр, хаяг, хуваарилбал зохих нийт мөнгөн хөрөнгө, битүүмжлэлд хамаарах татварын дүн, хуваарилах дараалал, хуваарилах мөнгөн дүн, авлагын хүсэлт гаргасан этгээдийн нэр, хаяг, авлагын хэмжээ, хуваарилах дараалал, хуваарилах мөнгөн дүн, хуваарилалтыг олгох хугацааг тусгах;

79.4.12.татварын хууль тогтоомж зөрчсөн татвар төлөгчид уг зөрчлийг дахин гаргуулахгүй байх, хууль тогтоомжийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж үйлдэх бөгөөд түүнд татварын төлөгчийн нэр, хаяг, татварын улсын байцаагчийн нэр, хүргүүлсэн он, сар өдрийг тусгах;

79.4.13.татварын хяналт шалгалтад шаардагдах магадлагаа, баримтын хуулбар, банкны гүйлгээний хуулга болон эдгээртэй адилтгах нотлох баримтыг татвар төлөгчтэй харилцагч аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн, санхүүгийн байгууллагаас гаргуулан авах зорилгоор зарлан дуудах хуудас үйлдэж, татвар төлөгчид хүргүүлэх бөгөөд түүнд татвар төлөгчийн нэр, хаяг, татварын улсын байцаагчийн нэр, хүргүүлсэн он, сар өдрийг тусгах.

79.5.Татварын улсын байцаагчийн үйлдэх баримт бичгийн загварыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

79.6.Энэ хуулийн 79.4-т заасан баримт бичгийг батлагдсан загварын дагуу дахин давтагдахгүй нэгдсэн дугаартайгаар ашиглах бөгөөд татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд заавал бүртгэнэ.

79.7.Татварын алба, татварын улсын байцаагч нь энэ зүйлд заасан баримт бичгийн хэвлэмэл хуудас, маягтыг зөвшөөрөлгүй хэвлэн ашиглах, хүчингүй буюу хуурамч хуудас хэрэглэх, зориулалт бусаар ашиглахыг хориглоно.

79.8.Татвар төлөгч нь энэ зүйлд заасан шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй.

**80 дугаар зүйл.Татварын улсын байцаагчийн эрхийн баталгаа**

80.1.Татварын улсын байцаагчийн цалин хөлс нь Төрийн албаны тухай хуулийн 57.2.2-т зааснаас гадна ажлын үр дүнгийн шагнал болон хууль тогтоомжид заасан бусад нэмэгдлээс бүрдэнэ.

80.2.Татварын улсын байцаагчид үр дүнгийн шагнал олгох журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Төсвийн тухай хуульд нийцүүлэн батална.

80.3.Татварын улсын байцаагчид доор дурдсан цол олгож болно:

80.3.1.татварын жинхэнэ зөвлөх;

80.3.2.татварын итгэмжит зөвлөх;

80.3.3.татварын зөвлөх.

80.4.Татварын улсын байцаагч нь албан үүргээ гүйцэтгэхэд шаардагдах хувцас, хэрэглэлээр хангагдсан байна.

80.5.Татварын улсын байцаагч хувцас, хэрэглэл хэрэглэх, цол, түүний нэмэгдэл олгох журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
## БУСАД

**81 дүгээр зүйл.Татвар төлөгчийн гомдлыг хянан шийдвэрлэх**

81.1.Татварын алба болон татварын улсын байцаагчийн гаргасан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас бусад шийдвэрийн талаар татвар төлөгч нь захиргааны журмаар дараах харьяаллаар гомдол гаргаж, учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй:

81.1.1.татварын улсын байцаагчийн үйлдсэн татварын актаас бусад шийдвэртэй холбогдсон гомдлыг тухайн байцаагчийг шууд харьяалах татварын албаны даргад;

81.1.2.татварын албаны шийдвэрийн талаарх гомдлыг түүний дээд шатны татварын албаны даргад;

81.1.3.татварын улсын байцаагчийн үйлдсэн татварын акттай холбогдсон гомдлыг харьяаллын дагуу Маргаан таслах зөвлөлд;

81.1.4.Маргаан таслах зөвлөлийн шийдвэртэй холбогдсон гомдлыг шүүхэд.

81.2.Энэ хуулийн 81.1.1, 81.1.2-т заасны дагуу гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл татвар төлөгч нь гомдлоо шүүхэд гаргах эрхтэй.

**82 дугаар зүйл.Төлөх татварын хэмжээг бууруулсан этгээдэд хүлээлгэх хариуцлага**

82.1.Татвар төлөгч нь татвар төлөхгүй байх, төлөх татварын хэмжээг бууруулах, эсхүл татвар ногдох зүйлийг нуух зорилгоор татвар ногдуулаагүй буюу татварын ногдлыг бууруулсан бол татварын улсын байцаагч татварыг нөхөн төлүүлж, дараах хэмжээгээр торгоно:

82.1.1.төлбөл зохих татварын дүнг 50 хүртэл хувиар бууруулсан бол нөхөн төлөх татварын дүнгийн 30 хувиар;

82.1.2.төлбөл зохих татварын дүнг 50 ба түүнээс дээш хувиар бууруулсан бол нөхөн төлөх татварын дүнгийн 40 хувиар.

82.2.Өмнө нь татварын албаны хяналт шалгалтаар илрүүлж нөхөн ногдуулалтын актаар тогтоосон энэ зүйлд заасан зөрчлийг давтан үйлдвэл, тухайн зөрчилд ногдох нөхөн төлбөл зохих татварын дүнгийн 50 хувиар торгоно.

**83 дугаар зүйл.Татвар суутгах үүргээ биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлага**

83.1.Суутгавал зохих татвараа суутгаагүй, эсхүл суутган авсан боловч төлж, тайлагнаагүй суутган төлөгч нь уг татварыг нөхөн төлөх үүрэгтэй.

83.2.Энэ хуулийн 83.1-д заасан этгээдийг нөхөн төлбөл зохих татварын дүнгийн 40 хувиар торгоно.

83.3.Өмнө нь татварын албаны хяналт шалгалтаар илрүүлж нөхөн ногдуулалтын актаар тогтоосон энэ зүйлд заасан зөрчлийг давтан үйлдвэл, тухайн зөрчилд ногдох нөхөн төлбөл зохих татварын дүнгийн 50 хувиар торгоно.

**84 дүгээр зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага**

84.1.Дараах үйлдэл, эс үйлдлийн улмаас төсөвт төлөх татварын хэмжээг бууруулсан буюу төлөөгүй бол төлбөл зохих татварыг нөхөн төлүүлж, нөхөн төлөх татварын дүнгийн 40 хувиар торгоно:

84.1.1.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх шаардлагыг хангасан боловч гэрчилгээ авалгүйгээр бараа үйлдвэрлэсэн буюу борлуулсан, түүнчлэн ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн;

84.1.2.нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлсэн хувь хүн, хуулийн этгээд үйлдвэрлэсэн буюу борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээндээ нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулаагүй;

84.1.3.нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгч үйлдвэрлэсэн буюу борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээндээ нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулсан боловч уг татварыг төсөвт төлөөгүй;

84.1.4.нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлээгүй этгээд бараа үйлдвэрлэсэн буюу борлуулсан, түүнчлэн ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн бөгөөд тэдгээрт албан татвар ногдуулсан боловч түүнийг төсөвт төлөөгүй;

84.1.5.төсөвт төлөх нэмэгдсэн өртгийн албан татварыг бууруулах, эсхүл буцаан авах татварын хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор нэмэгдсэн өртгийн албан татварын падаан, төлбөрийн баримтын мэдээллийг зөрүүтэй гаргасан, эсхүл падаан, төлбөрийн баримтыг үйлдээгүй.

84.2.Өмнө нь татварын албаны хяналт шалгалтаар илрүүлж нөхөн ногдуулалтын актаар тогтоосон энэ зүйлд заасан зөрчлийг давтан үйлдвэл, тухайн зөрчилд ногдох нөхөн төлбөл зохих татварын дүнгийн 50 хувиар торгоно.

**85 дугаар зүйл.Татварын улсын байцаагчийн хариуцлага**

85.1.Татварын улсын байцаагч, хураагчийн үйлдсэн доор дурдсан зөрчилд холбогдуулж Захиргааны ерөнхий хуулийн 105, 106, 107 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ:

85.1.1.татварын хууль тогтоомжоор хамгаалагдсан татвар төлөгчийн мэдээллийн нууцыг задруулсан;

85.1.2.энэ хуульд заасан албан тушаалын эрхээ хэтрүүлсэн, эсхүл үүргээ зохих ёсоор хэрэгжүүлээгүй.

85.2.Татварын улсын байцаагч, хураагчийн энэ хуулийн 85.1-д заасан зөрчлийн улмаас татвар төлөгчид хохирол учруулсан бол уг хохирлыг гэм буруутай албан хаагч хариуцна.

**86 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

86.1.Энэ хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА**
**Г.ЗАНДАНШАТАР**